



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-4</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>5-61</i>
<i>1. Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>5-60</i>
<i>2. Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох</i>	<i>60-61</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
Хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 38 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Ж.Батсуурь, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, Л.Мөнхбаатар, Г.Мөнхцэцэг, Г.Тэмүүлэн, Н.Учрал, Б.Чойжилсүрэн, Б.Энх-Амгалан, Л.Энх-Амгалан, Б.Энхбаяр;

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ё.Баатарбилэг, Э.Батишугар, Б.Баярсайхан, Н.Ганибал, Х.Ганхуяг, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, С.Одонтуяа, Л.Оюун-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Т.Энхтүвшин, Ж.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, М.Оюунчимэг, Д.Өнөрболор, Ш.Раднаасэд;

Тасалсан: Э.Бат-Амгалан, Г.Ганболд, Ч.Ундрэм;

Хоцорсон: С.Амарсайхан-28минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Адъяа нараас албан бичиг ирүүлснийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Адъяа нар үг хэлэв.

Нэг.Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн газрын зөвлөх Б.Төгөлдөр, Э.Цацрал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар, Ц.Мөнхцэцэг, Б.Жаргалмаа, Б.Баттөмөр, Х.Болорчулуун, Д.Сарангэрэл, Ш.Адъяа, Б.Пүрэвдорж, Д.Ганбат,

Г.Амартүвшин, Г.Дамдинням, Ц.Сандаг-Очир, С.Ганбаатар, Х.Булгантуяа, Ж.Батжаргал, Н.Наранбаатар, Т.Доржханд, Т.Аубакир нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн газрын зөвлөх Б.Төгөлдөр, Э.Цацрал нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 55 минут үргэлжилж, 13 цаг 33 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 10 минутад эхэлж, Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд дэмжиж үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг дараагийн хуралдаанаар явуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар нар байлцав.

1.Гэрийн тэжээвэр амьтадын тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /14:44/

2.Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг санал хэлэв. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /14:44/

3.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /14:44/

4.Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /14:44/

5.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /14:44/

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /14:44/

7.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /14:45/

8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /14:45/

9.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /14:45/

10.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /14:45/

Бусад. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 30 минут үргэлжилж, 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр 14 цаг 45 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их
хуралдай” танхим 10 цаг 38 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Гишүүдийн ирц бүрдсэн тул 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хурал хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл, Соёлын харилцаа, хамтын ажиллагааг дэмжих, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газрын мэдээлэл сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу гишүүн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах дараалалд өөрчлөх асуудал нэмэх горимын санал гаргах бол нэгдсэн хуралдаан эхлэхээс өмнө 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Бөхчулууны Пүрэвдорж, Ширнэнбандийн Адъяа нараас албан бичиг ирүүлсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн 1 дүгээр сарын 5-ны өдрийн чуулганы хуралдаанд хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотой үг хэлнэ гэсэн байна. Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Тэтгэврийг тогтоохдоо 7 жилийн цалингийн

дунджаар биш 5 жилийн цалингийн дунджаар тогтоох тухай хуулийг Нийгмийн даатгалын багц хуультай хамтран хэлэлцэж баталсан байгаа. Энэ хуулийг хэрэгжүүлэх явцад ялангуяа Засгийн газрын 238 дугаар тогтоолын дагуу итгэлцүүрийг тогтоохдоо тодорхой олон жилийн ужгирсан асуудлыг шийдвэрлэсэн ийм сайн тал байна. 6 сард гарсан Засгийн газрын тогтоолын дагуу. Гэвч яг энэ итгэлцүүрийн дагуу 2023 оны 7 сарын 1-нд ихэнх ахмадын тэтгэвэр нэмэгдсэн. Тэнд ямарваа нэгэн байдлаар ахмадууд бага нь бага нэмэгдсэн, их нь их нэмэгдсэн гэдэг ийм гомдол гаргаснаас биш тодорхой хэмжээгээр бүх ахмадуудын тэтгэвэр хамгийн багадаа 50 мянган төгрөгөөс дээшээ нэмэгдээд явсан юм. Гэтэл өнөөдөр энэ 7 жилээр бодуулсан хүмүүсийг тэтгэврийг нь дахиж бодохдоо нийтэд нь нэг программаар шууд автоматаар бодож байгаа учраас амьдрал баян.

Зарим хүмүүс олон янз янзын нөхцөл байдал дээр тэтгэврээ тогтоолгож байгаа, цалин авч байсан ийм хүмүүс байгаад байгаа юм. Тийм учраас энэ хүмүүсийн тэтгэвэр зарим нь урьд нь 2019 онд тэтгэвэрт гарахдаа миний хүү би хэрвээ 5 жилээр бодвол хэдэн төгрөгөөр нэмэгдэх байсан бэ гээд асуухад 110 мянган төгрөгөөр нэмэгдэх байсан байна гэж хэлж байсан бол өнөөдөр яг тэр тэтгэврээ нэмэгдүүлээд бодохоор 1000 төгрөг, 2000 төгрөг, 10 мянган төгрөг нэмэгдээд байгаа ийм зүйлүүд тодорхой ахмадууд дээр гараад байна. Мэдээж энэ программын дагуу ихэнх ахмадуудын тэтгэвэр нэмэгдэж байгаа. Тэгэхдээ нэлээн олон ахмадууд над руу бичээд байна. Энэ тэтгэврийн чинь хуулийн дагуу бид нарын тэтгэвэр хангалттай нэмэгдсэнгүй гэдэг ийм зүйлийг яриад байна. Тэгээд энэ дээр гол ямар асуудлууд байна вэ гэхээр жишээ нь 2019 онд тэтгэвэрт гарсан хүн 2020 оны тэтгэврийн нэмэгдэл авсан 10 хувийн нэмэгдэл, 2022 оны 2 сарын 1-нд

нэмэгдсэн 15 хувийн нэмэгдлийг авсан, 2023 оны 7 сарын 1-нд итгэлцүүрийн дагуу нэмэгдсэн нэмэгдлээ авсан. Гэтэл тэтгэврийг дахиж нөхөн бодоходоо зөвхөн 2023 оны 7 сарын 1-ний нэмэгдлийг бодоод, үлдсэн өмнөх 2020 оны, 2022 оны нэмэгдлийг хийгээгүй ийм асуудлууд маш их гараад байна. Тэгээд үүнийгээ болохоор ялангуяа Засгийн газрын шийдвэрийн дагуу 7 сард тэтгэвэр нэмэхдээ бүх ахмадуудын асуудлыг асуудалгүй нэмчхээд, Пүрэвдоржийн өргөн барьсан 7 жилийг 5 жил болгох хуулийн хүрээнд энэ дээр асуудалтай хууль нэмж нэмж байгаа нь тэр программдаа байна. Энэ бол Монгол Улсын өнцөг булан бүрд ажиллаж байгаа тэр мянга, мянган нийгмийн даатгалын байцаагч нарын буруу биш. Тэр хүмүүс дээрээс өгсөн чиглэлийн дагуу тэр программын дагуу л асуудлаа бодож байгаа. Манай ахмадууд яг тэнд сууж байгаа тэр нийгмийн даатгалын байцаагч хүмүүс рүү янз, янзын асуудлаар ярьж ярих хэрэггүй. Энэ хүмүүс тэр Засгийн газрын гаргасан, тэр яамнаас гаргасан, НДЕГ-аас санаачилж оруулсан тэр программын дагуу бодож өгч байгаа.

Тийм учраас энэ асуудал дээр ялангуяа гомдолтой байгаа нэлээн олон ахмадууд байна. Тэр ахмадуудын асуудлыг дахин программаар биш, яг тэр гомдолтой хүмүүсийн өргөдлийг нь хүлээж аваад, дахиж яг хувьчилж бодож өгөх энэ асуудлыг шийдвэрлэж өгөхгүй бол янз, янзын нөхцөл байдалд цалинтай байсан тэр хүмүүсийн асуудал хүндэрч, ялангуяа ахмадууд ийм харгис төртэй, юм болгонд дандаа заавал нэг хэдэн төгрөг яаж бага өгөх вэ л гэдэг ийм төртэй байж болохгүй гэж бүх ахмадууд бодож сэтгэж сууж байгаа. Тийм учраас энэ иргэдийн асуудлыг шийдвэрлэх талаар Булгантуяа сайд аа, энэ талаар сайн ажиллаарай. Ялангуяа нэг их тийм олон хүн биш байна. Тэр хүмүүсийн асуудлыг яг нэг, нэгээр нь бодож өгөх талаар бас тэр ажил нөхцөл нь болдог юм уу, болдоггүй

юм уу, түүн дээр бас сайн шийдэж өгөөч ээ гэж хүсмээр байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Та бүгдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая. Өнөөдөр энэ Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлын дэг дарааллын дагуу үг хэлье гэж үг авсан юм аа. Тэгэхлээр энэ Их хурлын даргаас нэг хүсэх зүйл байна. Энэ Засгийн газрын сайдуудын асуудал, энэ Их Хурлын гишүүдтэй холбоотой асуудлыг ингэж шүүмжилж ярих гэхээр миний яриаг тасалчхаад байна. Танаас гуйж байна, энэ миний яриаг нэг яриулаад өгчхөөч ээ гэж.

Г.Занданшатар: Дэгийн дагуу л ярина шүү. Энэ хэлэлцэх асуудалтай холбоотой.

Ш.Адьяа: Дэгийн дагуу л би ярьж байгаа. Тэгэхээр хэлэлцэх асуудалтай холбогдуулж хэлнэ. Тийм учраас танаас гуйж байна шүү. Миний үгийг хэлүүлээд өгчхөөрэй. Би бас ард түмний төлөөлөл хуулийн дагуу явна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн тухай хуулийг Засгийн газраас нэн яаралтай горимоор өргөн бариад 2 сар болсон. Харин өчигдөр даргын зөвлөлөөр энэ асуудлыг хэлэлцэх болсон тухай бас дарга надад хэллээ. Би баяртай байна. Энэ яагаад хэлэлцүүлэхгүй байгаа юм гэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал зөрчсөн учраас л хэлэлцүүлэхгүй байгаа юм. Ер нь тэгээд авлигатай тэмцэх, хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ, шинэ түвшинд гаргадаг гэдэг халхавчийн дор авлигын шүүх байгуулна.

Мөрдөн шалгах ажиллагааны нууц задруулахад хүн гэдэг ойлголтыг оруулж ирж шударга үгээ хэлсэн, үзэл бодлоо илэрхийлсэн иргэд, сэтгүүлчдийг шүүх цагдаад баривчлах ийм хууль оруулж ирээд энэ олон нийтийн эсэргүүцэлтэй тулгараад замхарсан. Шүүх хуулийн өмнө

бид тэгш байх ёстой. Сайд байна уу, Их Хурлын гишүүн байна уу, хууль зөрчсөн бол хариуцлага хүлээх ёстой. Энэ мөрдөн шалгах ажиллагааны нууц, гүйцэтгэх ажлын нууцыг чинь энэ асуудал хариуцсан сайд нь өнөөдөр задруулаад байна шүү дээ. 20 тэрбумын хөрөнгөтэй сэтгүүлч байна гэж зарласан. Энэ мөрдөн байцаалтын нууц, гүйцэтгэх ажлын нууц. Энэ ямар эх сурвалжаас 20 тэрбумын хөрөнгөтэй сэтгүүлч байгаа тухай энэ мэдээллээ ард түмэнд нээлттэй зарлахыг би Хууль зүй, дотоод хэргийн сайд Энхбаяраас шаардаж байна. Шүүх хуулийн өмнө бид тэгш байдаг. Мөрдөн байцаалтын нууцыг задруулахгүй гэж байдаг юм бол гүйцэтгэх ажлын нууцыг задруулахгүй гэж байдаг юм бол тэр 20 тэрбумын хөрөнгөтэй сэтгүүлчийг Энхбаяр хаанаас олсон юм. Ямар эх сурвалжаас олсон юм гэдгийг нь ард түмэнд тайлбарлахыг би шаардаж байна.

Яагаад гэхээр Энхбаяр сайд өнөөдөр Ерөнхий сайдын шударга ёсны илд байна гэж хэлж гарч ирсэн. Гэтэл энэ хүн өнөөдөр шударга ёсны илд биш шударга ёсыг нухчин дардаг, хүний эрхийг, том гэмт хэргийг нуун дарагдуулдаг буг чөтгөр боллоо гэж ойлгож байна би. Энэ Улсын Их Хуралд ард түмний төлөөлөл мөн юм бол эрээ цээрээ алдсан ийм сайдуудтай, тэдний гар хөл болсон энэ хүмүүстээ бид хариуцлага тооцох хууль эрх зүйн орчин бүрдүүлэх ийм цаг болсон байна. Ийм хуулийн төсөл санаачилъя гэж бодож байгаа. Энэ асуудал бол нийт Монгол Улсын эрх ашиг өнөөдөр энэ авлигатай тэмцэх шударга ёс, хүний эрхийн асуудал учраас би хууль тогтоогчийн хувьд, ард түмний төлөөллийн хувьд ийм шаардлага тавьж үг хэлж байгаа юм шүү. Би хэн нэгэн хүний нэр төр, хэн нэгэн хүний асуудлыг би энд ярих гээгүй шүү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Анхаарал тавьсанд баярлалаа. Индэр ашиглаад илд

бамбай ярихгүй байхыг хүсье. Хэлэлцэх асуудлаа ярина. Одоо хэлэлцэх асуудалдаа орно. Хэлэлцэх асуудалд орохын өмнө бас гишүүдийн сая Пүрэвдорж гишүүний хэлсэнтэй холбогдуулаад ер нь бол энэ 7, 5 жил болоход эхнээс нь хэлж байсан юм шүү дээ. Эерэг, сөрөг талтай шүү гэдгийг. Тэгээд энэ талаар Булгантуяа сайд тодорхой мэдээлэл олон нийтэд өг. Өчигдөр бас ярьсан асуудалтай холбогдуулаад сонгуулийн жил эхэлсэн. Энэ үед хариуцлагатай байхыг сануулсан. Ирц дээрээ, хурлын идэвх оролцоо дээрээ. Дамдинням гишүүний хувьд бол энэ зарим хүмүүс цагаан сар ашиглаад мөнгө тараагаад байвал яах вэ гэсэн асуудал ярихад, мөнгө тараах асуудлыг ярьж болохгүй гэснийг бас мушигж ярьж байгаа. Түүнээс биш Дамдинням гишүүнийг шалгаад үзэхэд ямар ч мөнгө тараадаг хүн биш, тараагаагүй, бас тойрогтоо л иргэдийн саналыг авч ажиллаж байгаа юм байна билээ гэдгийг онцлон тэмдэглээд, харин энэ жил бол энэ янз бүрийн ийм эд зүйл тараадаг биш энэ том тойрог дээр ард иргэдийнхээ нийтлэг эрх ашгийг хамгаалдаг ард түмний төлөөлөгч байж ажиллах, энэ зарчимтай холбогдуулж энэ цагдаагийн даргад энэ санал хүсэлтүүдийг тавьсан. Бас тэр хуурамч хиймэл оюун ухаан ашигласан ийм сошиал медиаг бид хянах боломжгүй байгаа шүү дээ. Үүнээс урьдчилан сэргийлэх талаар хууль тогтоомж боловсронгуй болгох талаар анхаарах хэрэгтэй байгаа. Ингээд хэлэлцэх асуудалдаа орё.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Ч.Хуралбаатар: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна гэж үндэсний аюулгүй байдлын үзэл үзэл баримтлалд эдийн засгийн олон тулгуурт оновчтой бүтэц бүхий хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхыг бүрдүүлж эдийн засгийн бие даасан байдал хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх бодлого баримтална гэж тусгасан. Төрөөс Үндсэн хуульд үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогыг батлахдаа эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих бодлогыг тодорхойлж, энэ хүрээнд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх асуудлыг тусгасан.

Монгол Улсын Засгийн газраас бодлогын баримт бичигт туссан Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын хүрээнд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан өргөн бариад байна.

Хууль санаачлагчдын зүгээс гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогыг тодорхойлохын тулд өнөөгийн тулгамдаж байгаа нөхцөл байдлыг судалсан. Монгол Улсад 1990-2023 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 41.1 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирснээс 73 хувь нь уул уурхайн олборлолт, 11 хувь нь худалдаа үйлчилгээний салбарт хийгдсэн бол бусад салбарууд нийлээд 16 хувийг эзэлж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалт төрөлжихгүй зөвхөн нэг салбарт харьцангуй ихээр төвлөрч байгааг

харуулж байна. Оюу Толгойн төслийн уул уурхайн олборлолт бүтээн байгуулалттай холбоотойгоор Монгол Улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт 2011 оноос эрс нэмэгдсэн боловч хууль эрх зүйн орчны тогтворгүй байдлаас үүдэлтэйгээр сүүлийн 10 жилийн хугацаанд нийт орж ирсэн гадаадын хөрөнгө оруулалт чамлахаар хэмжээнд байна. Монгол Улсын хэмжээнд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар хуулийн этгээдийн улсын бүртгэлд нийт 246.8 мянган аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас гадаадын хөрөнгө оруулалттай 9350 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа явуулж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлд 1990-2023 онд нийт 14836 гадаадын хөрөнгө оруулалт аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс өнгөрсөн хугацаанд 5486 аж ахуйн нэгж татан буугдсан байна. Эдгээр аж ахуйн нэгжийн 33 хувь нь 2010-2022 онд татан буугджээ. Ийнхүү нөхцөл байдлыг дүгнэвэл гадаадын хөрөнгө оруулалт нь уул уурхайн салбарт илүүтэй хийгдэж байгаа нь Монгол Улсын эдийн засгийн төрөлжилт энэ хэмжээгээр хязгаарлагдмал бусад салбарт гадаадын хөрөнгө оруулалт орж ажиллах боломж нөхцөл хязгаарлагдмал байгааг харуулж байна.

Хуулийн төслийг нийт 65 хоногийн хугацаанд иргэд, олон нийт, хөрөнгө оруулагч нарын дунд нээлттэй хэлэлцүүлж санал авсан бөгөөд олон улсын байгууллага гадаад улсын Элчин сайдын яаманд мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, төрийн байгууллага, гадаад, дотоодын 120 гаруй байгууллагын 250 орчим төлөөллөөс нийтдээ 700 орчим саналыг хүлээж авсан. Хууль санаачлагчийн зүгээс олон нийтээс ирүүлсэн санал хуулийн хэрэгжилтийн үр нөлөө болон практик шаардлагад нийцүүлж гадаадын хөрөнгө оруулалтын шинээр татах, эдийн засгийг төрөлжүүлж, суурийг тэлэх, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны эрх, ашиг

сонирхлыг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдад үзүүлэх төрийн үйлчилгээг хялбаршуулах замаар хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг хадгалах зорилгод нийцүүлэн хуулийн төслийг боловсруулаа.

Хуулийн төсөлд туссан зарчмын гол асуудлуудыг дурдвал:

1.Хөрөнгө оруулалтыг төрөлжүүлэх шинээр орж ирэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахад шаарддаг 100 мянган ам.доллар зарим салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтад тавьсан хязгаарлалтыг байхгүй болгосон. Ингэснээрээ эдийн засгийг төрөлжүүлэх нөхцөл бүрдэх ба уул уурхайн салбараас бусад салбарт хөрөнгө оруулалтыг энэ хуулиар татах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

2.Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлийг байгуулж, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл эс үйлдэхүйтэй холбоотой хөрөнгө оруулагчийг хохироосон аливаа гомдлыг шалган шийдвэрлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Энэ зохицуулалт туссанаар хөрөнгө оруулагчид өөрсдийн үйл ажиллагаанд үүссэн хүндрэл бэрхшээлийг цаг алдалгүй шийдвэрлэх цаашилбал гомдол нь даамжирна. Шүүхийн болон арбитрын маргаан болж төрд болон хөрөнгө оруулагчдад хүндрэл үүсгэдэг байдлыг арилгана гэж үзэж байна.

3.Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулалттай холбоотой гомдол маргаан үүссэн тохиолдолд олон улсын арбитра хандах эрхийг нээлттэй болгож хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хууль бусаар дайчлан хураахгүй байх баталгааг төрөөс

олгох тухай зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хамгаалах баталгааны зохицуулалтыг хуульд тусгаснаар Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх итгэлийг сэргээнэ гэж үзэж байна.

4.Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд төрөөс тухайн жилд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын тоог хуулиар тогтоон хэрэгжүүлэхээр тусгалаа. Энэ нь хөрөнгө оруулалт, бизнес эрхлэлтийг дэмжих, төрийн хүнд суртлын бууруулах бизнесийн үйл ажиллагаанд учруулдаг шаардлагагүй дарамтыг бууруулах томоохон хөшүүрэг болно гэж харж байна.

5.Хөрөнгө оруулалтын чиглэлээр төрийн бүх байгууллагуудын хүлээх үүргийг ойлгомжтой тодорхойлж тусгалаа. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хөрөнгө оруулагчдад төрөөс нөхөн төлбөр олгохоор шийдэгдсэн тохиолдолд тухайн хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хохироосон шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтнаар төрд учирсан хохирлыг буцаан төлүүлэх, хариуцлага тооцох тухай зохицуулалтыг тусгалаа. Энэхүү зохицуулалт нь аливаа албан тушаалтан хөрөнгө оруулагчийн хууль, ёсны эрх ашгийг хувийн үзэмж ашиг сонирхлын үүднээс ялгамжтай байдлаар шийдвэр гаргаж хохироодог байдлыг бууруулахад ач холбогдолтой гэж үзэж байна.

6.Хөрөнгө оруулагч нарт үзүүлэх төрийн үйлчилгээг хялбаршуулж нэг цонхны зарчмаар хөрөнгө оруулагчдад үйлчилгээ үзүүлэхээр тусгалаа. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулагчдад үйлчилгээ үзүүлэх төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах замаар хөрөнгө оруулагчид нэгдсэн нэг сувгаар төрийн дэмжлэг үйлчилгээг үзүүлэх давуу тал бий болно гэж үзэж байна.

7.Хөрөнгө оруулагч нарт эргэлзээ үүсгэж байсан хөрөнгө оруулалтын тухай

хуулийн зарим зүйл, заалтыг ойлгомжтой болгож, хуулийн давхардлыг арилгалаа.

Тухайлбал татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой зохицуулалт нь татварын хуульд заагдаагүй тохиолдолд хэрэгждэггүй байсан. Иймд хөрөнгө оруулагч нарт эргэлзээ үүсгэсэн эдгээр зохицуулалтыг Хөрөнгө оруулалтын хуулийн төслөөс хасаж аливаа татварын дэмжлэгийг зөвхөн Татварын хуулиар зохицуулж байхаар төсөлд тусгалаа.

8.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу үзүүлэх татварын хувь хэмжээг тогтворжуулах асуудлыг тодорхой ойлгомжтой болгосон. Тухайлбал Тогтворжуулах гэрчилгээ олгох асуудлыг хялбаршуулж шаардлага хангасан аж ахуйн нэгжийн хүсэлтэд үндэслэн цахимаар шийдвэрлэдэг байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа. Засгийн газраас ойрын хугацаанд Газрын тухай багц хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байгаатай холбогдуулан газрын харилцаатай холбоотой асуудлыг цогцоор нь шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр буцаан татсан.

Хөрөнгө оруулалтын тухай хууль батлагдсанаар Монгол Улсын хөгжлийн бодлогод туссан зорилтууд хангагдаж хөрөнгө оруулалт л нэмэгдэх, Монгол Улсын гадаад валютын нөөц өсөж, улмаар бизнес эрхлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, Монгол Улсын өрсөлдөх чадварыг сайжруулна гэж үзэж байна.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хуулийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд танилцуулна.

Т.Доржханд: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь Монгол Улс дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, шинээр хөрөнгө оруулалт орж ирэх үед тусгай зөвшөөрөл авах, бүртгүүлэх үйл ажиллагааг сайжруулж хөрөнгө оруулалтын үе шатад тогтвортой байдал үйл ажиллагааг шуурхай явуулах нөхцөлийг хангах. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах, гомдол маргааныг шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх. Хөрөнгө оруулалтын бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг улс, салбар, салбар хооронд болон бүс орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хөрөнгө оруулалтын чиглэлээр төрийн байгууллагын уялдаа холбоог хангах, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулж буй зарим харилцааг тодруулах, хууль хоорондын уялдааг сайжруулан гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, хөрөнгө оруулалтын орчинд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулжээ.

Хуулийн төслийг *D-parliament.mn* цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байна. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам татварын болон татварын бус урамшууллын талаарх гадаадын хөрөнгө оруулагчид олгох газар ашиглах эрхийн хугацаа болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хохироосон хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг хянан шалгах ажлын хэсгийн үйл явцын талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг тус тусгайлан хянан шийдвэрлэх бизнесийн хэргийн дагнасан шүүх байгуулах боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг нар хөрөнгө оруулагч бүртгүүлэх, зөвшөөрөл олгох явцыг хялбаршуулах төрийн үйлчилгээний хүнд суртлын бууруулах, ноу хау бүхий гадаадын боловсон хүчинд хөнгөлөлттэй нөхцөл үзүүлэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцод хуулийн төсөл нийцсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл гадаадын хөрөнгө оруулалт буурсан шалтгааныг хэрхэн тодорхойлсон, хууль батлагдсанаар хөрөнгө оруулагчид ямар давуу нөхцөл байдалтай болох талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд хөрөнгө оруулалтыг эдийн засагт үзүүлэх ач холбогдол зах зээлд ойр байдлаар нь байдлаар нь эрэмбэлсэн эсэх хөрөнгө оруулалт татахад сөргөөр нөлөөлдөг ханиийн эрсдэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Гадаадын хуулийн этгээдэд олгох газар ашиглах эрхийн хугацааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Хөрөнгө оруулагчийн өмчийг хэрхэн хамгаалах, гомдол маргааныг шийдвэрлэх, шүүх байгууллага болон данс битүүмжлэх эрх бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар, хууль батлагдсанаар Монгол Улс Дэлхийн банкны бизнесийн орчны судалгаанд

эрэмбэлэгдсэн одоогийн байр сууриас хэдий хэмжээгээр дээшлэх талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцыг судалж үүрэг хариуцлагыг нь нөхцөлдүүлэх гадаадын хөрөнгө оруулагчид газар ашиглуулах асуудлыг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл Монгол Улсын газар зүйн байрилын онцлог нь татварын хувь хэмжээнд сөргөөр нөлөөлдөг асуудлыг сайтар судалж хуулийн төсөлд тусгах, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газрын албан хаагчдыг хөрөнгө оруулалт татах чиглэлээр үүрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд хөрөнгө оруулалтыг эдийн засагт үзүүлэх ач холбогдол зах зээлийн боломжоор уул уурхайгаас бусад салбарт чиглэсэн байдлаар эрэмбэлэх, хани тогтворжуулах арга хэмжээгээ тодорхойлж гадаадын хөрөнгө оруулалтыг тэлэх замаар эдийн засгийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг тус тус гаргасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хөрөнгө оруулалтын тухай Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт

оруулах тухай хуулийн төсөл, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Усны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хуулийн хэрэгжилт хангуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Чимэдийн Хүрэлбаатар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Идэшийн Батхүү, Эдийн засаг хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Бат-

Ирээдүйн Анар, Эдийн засаг хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын зөвлөх Батжаргалын Төгөлдөр, Эдийн засаг хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын зөвлөх Эрдэнэбатын Цацрал байна.

Зочид танилцуулъя. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт сайн сайхныг хүсье. Шинэ оны мэнд дэвшүүлъя.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд Нанзадын Наранбаатар гишүүнээр тасаллаа. Аубакир гишүүнийх орчхоод гараад явчихсан байна гэж байна. Буцаагаад оруулчих. Цэрэнпиллийн Даваасүрэн гишүүн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр миний бас нэг анхаарах зүйл байгаа юм. Би өмнө нь энэ Хөрөнгө оруулалтын хууль дээр 50 мянган долларын босгыг авч 50 мянга болгож бууруулсантай холбогдолтой энэ асуудлыг хөндөж байсан юм 100 мянгыг. 50 мянган доллароор 1 машин худалдаж аваад, байр худалдаж аваад ингээд Монголд байнгын оршин суух ийм гаднын иргэнтэй болох нь гэж. Энэ хууль дээр босго нь байхгүй. Бүүр босгогүй болчихсон. Тэгээд уг нь хөрөнгө оруулалтын хэлбэр 4 төрлөөр байсан юм. Одоо маш олон төрөл болчихсон. Түүн дотор нь барилгад хөрөнгө оруулалт буюу зүгээр нэг хямдхан байшин худалдаад авчихвал Монголд байнга оршин суух эрхтэй болж байгаа юм. Тэгээд энэ асуудлыг Засгийн газрын хуралдаан дээр ярьсан, би хэлсэн. Тэгээд үүнийг сая ярьж байж оруулж ирье гэсэн боловч өнөөдөр энэ заалт нь хэвээрээ явж байгаа юм байна. Энэ болохгүй ээ.

Энэ үндэсний аюулгүй байдал нөлөөлнө. Одоо манайхан ингээд 2 хөршийгөө баян болчихсон гээд байгаа юм. Тийм юм байхгүй. Хангалттай ядуу улсууд тэнд байгаа. Манай өмнөд хөршид хүн амын 13 хувь нь буюу өдөрт 5 доллароор амьдардаг 180-аас 200 сая иргэн байна. Манай хойд хөршид бас хангалттай. Дайны нөхцөл байдал улам хүнд байна. Юу ч болж болно. 1921 оны үед цагаантнууд манайхаар зүгээр чөлөөтэй ороод л гарсан шүү дээ. Түүн шиг жишээлбэл энэ дайны хор уршгаар Орост юу ч болж болзошгүй. Тэгээд бид нар энэ 2 том орны дунд оршин тогтносон үндэсний дархлаагаа ер хэрхэвч алдаж болохгүй. Тэгээд энэ дотор ингэж байгаа юм. Ерөөсөө 1 сая төгрөгөөр дүрмийн сантай компани байгуулбал Монголд байнгын амьдран оршин суух эрх авч байгаа. 16.1.5 байнгын оршин суух эрх ингэж болохгүй шүү дээ. Энэ Монгол ядуу хүмүүсийн хогийн сав биш. Хөрөнгө оруулалтыг бол өөрсдийн хийж чадахгүй байгаа зүйл дээрээ, үзүүлж чадахгүй байгаа үйлчилгээ дээрээ, байхгүй байгаа технологи дээрээ авдаг эд. Түүнээс биш бүх салбарт авч, ажлын байраа булаалгадаг байж болохгүй.

Нөгөө талаар ер нь бол стратегийн салбарууд дээр гол бүтээгдэхүүнүүдээр хөрөнгө оруулалт татна гэдэг ойлголт гадаадад байдаггүй. Би та нарт нэг жишээ хэлье л дээ. Манай хэсэг гишүүд Чили, Перугаар явсан юм. Тэгээд бид нар тэнд уулзаж байгаад хөрөнгө оруулалт татах тухай юм ярьсан чинь 2 орныхон хоёулаа тэгж байгаа юм инээгээд байгаа юм. Үгүй ээ, алтан дээр, зэс дээр хөрөнгө оруулалт татна гэж байдаггүй шүү дээ. Би яриагаа үүнээс эхэлье гэж. Нөгөө 2 нь тэгж байгаа юм. Перу чинь бас авлигад нэлээн идэгдчихсэн орон шүү дээ. Тэгэхдээ бүүр татвараа хангалттай аваад, роялти тэнд 8-10 хувь байгаа. Гэтэл гарч байгаа мөнгөн дээр нь 2 хувь авна. Манайд юу ч байдаггүй шүү дээ. Гэтэл Чили бол бүүр

маш өндөр роялти авна, гарч байгаа мөнгөн дээр нь 20 хувийн татвар авна. Тэгэхээр манайд хөрөнгө оруулалт хангалттай татварын хөнгөлөлттэй. Ганц л гай бий. Янз бүрийн хүчний байгууллагатайгаа нийлж байгаад дээрэмддэг гаднынхныг. Жапан Таун байна. Үүнийгээ зогсоо л доо. Энэ гаднынхныг луйвардаад байгаа, дээрэмдээд байгаа юмнуудаа л зогсоо. Түүнээс биш Монгол гаднынхныг 1 сая төгрөг төлөөд орж ирдэг ядуучуудын цуглуулга хогийн сав биш.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулна. Шадар сайд.

Ч.Хүрэлбаатар: Жаахан мушигдсан байдлаар ярьж байна. Энэ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар хөрөнгө оруулах зорилгоор виз авах, оршин суух зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд ямар нэг өөрчлөлт ороогүй, хэвээрээ байгаа. Саяын хэлээд байгаа заалт нь өмнө байсан хуульдаа байсан заалт нь. Тэгэхээр энэ дээр оролдоогүй байгаа гэдгийг нэгдүгээрт нь хэлчихмээр байгаа юм.

Хоёрдугаарт нь, Монгол Улс дэлхийн ер нь цаашидаа хөгжлөө яаж явах вэ л гэдгээ бид нар нэлээд харах ёстой. Бүх юмаа хаагаад, зөвхөн дотроо өөрсдөө хийнэ ээ гээд ингээд хөгжүүлж бас болно. Гэхдээ хөгжил их л удаан байх байх. Монголчуудын дийлэнх олонхын амьдралын түвшин доогуур ядуу хэвээрээ л байх, байх. Яах вэ энд сууж байгаа олон хүний амьдрал сайхан байгаа байх. Бид нар энгийн ард иргэдийнхээ амьдралыг бодох ёстой, нэг.

Хоёрдугаарт, бизнес эрхлэгчид, ард иргэдийн юу хийхийг бид нар энд зааж өгөх гэж оролдож яах юм. Аль нийгэмд амьдарч байгаа юм бэ бид нар. Тэр хүн бизнесээ хийх орчин нь юу хийхээ, ямар бизнес хийх, яаж хийх вэ гэдгээ өөрсдөө шийддэг л дээ, сонголт нь нээлттэй байг л дээ. Үүнийг бид нар өмнөөс нь заавал

шийдэх гэж оролдоод яах юм. Нээлттэй байг. Бид нар ард иргэддээ боломжийг нь олго. Бизнес эрхлэгчдэд боломжийг нь олгох хуулийг бид нар оруулж ирж байгаа. Би нэг жишээг маш сайн санаж байна. МИАТ-ийн жишээ. Манайх их олон хүн ярьдаг л даа. МИАТ-ийг ингээд гаднын компаниудыг оруулж ирэх юм бол ингээд МИАТ чинь ингээд дампуурна, орлого нь буурна, энэ ингээд дампуурна шүү гээд байсан. Гэтэл иргэний агаарын тээврийг либералчилчихсан. Одоо хуучин Солонгос руу 17 нислэг байсан бол одоо 80 нислэгтэй байгаа.

Энэ чинь юу гэсэн үг вэ гэхээр нислэгийн тоо нэмэгдэхээр МИАТ-ийн зах зээл нь ч хүртэл томроод эхэлж байна. Түүгээр дамжаад МИАТ-ийн ашиг орлого нь нэмэгдэж байна. Онгоц аваад явах боломж нь нээгдэж байгаа. Тэгэхээр бид нар ийм боломжуудыг хааж болохгүй. Энд ер нь нээж өгөөд явах нь зөв гэдэг л ганцхан зарчмаар байгаа. Тэр хуучин байсан зүйлүүдийг оролдоогүй. Эмзэг сэдэв байгаа учраас тэд нарыг бид нар оролдоогүй гэдгээ хэлье. Бас мушгиж яриад дэмий байлгүй дээ.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулж асууна.

Ц.Даваасүрэн: Мушгиж ярьсан юм ерөөсөө байхгүй. Хууль дээр би ингээд уншихаар хамтарсан компани байгуул гэж байгаа юм. Нөгөө 100 мянган долларын босго байхгүй болчихсон. Тэгэхээр чинь 1 сая долларын дүрмийн сантай хамтарсан компани байгуулбал байнгын оршин суух виз авна. 16.1.5-ыг хар. Барилгад хөрөнгө оруулбал гээд 5 дээрээ байж байгаа. 10 сая төгрөгөөр арай юм зүгээр 20 сая төгрөгийн нэг хуучин байшин худалдаад авчихад 16.1.5-аар байнгын оршин суух виз авна. Үгүй ээ, хууль дээрээ ийм л байгаа зүйлийг би яриад байна шүү дээ. Тэгвэл үүнийгээ аваад хаячих л даа. Монголд тэгж чөлөөтэй амьдардаг гаднынхан байж болохгүй. Яг хөрөнгө оруулахыг нь бол хатуу заагаад,

ямар технологи дээр, ямар салбарт, юун дээр хөрөнгө оруулалт татах юм гэдгээ бид нар тодорхой болгох болохоос биш замбараагүй байж болохгүй л гэж би хэлээд байгаа шүү дээ.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар Шадар сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд харцуулна.

Ч.Хүрэлбаатар: Бид нар яг ний нуугүй хэлэхэд бүгдийг нь мэддэг хүмүүс биш л дээ. Тэгээд бизнес эрхлэгчид эд нар өөрсдөө сонголтоо хийг л дээ. Яагаад тэр хүмүүсийн боломжийг нь бид нар хааж, заавал чи үүнийг хий, ингэж хий гэж заадаг ийм юм болоод байгаа юм. Бид нар ямар коммунист нийгэмд амьдарч байгаа юу. Зах зээл ардчиллын нийгэмд амьдарч байна. Энэ хувийн бизнес эрхэлж байгаа хүмүүсдээ бизнес хийх эрх чөлөөг нь чөлөөтэй олго л доо. Яваад ирсэн зам чинь болохгүй байна гэж үзээд байна шүү дээ, нэгд.

Хоёрдугаарт, компани байгуулахын тулд 100 мянган доллар оруулж ир гэдэг, энэ чинь зөвхөн том компаниудад л үйлчилнэ. Энгийн тэр эдийн засгийг төрөлжүүлэх бусад салбарт орж ирэхэд нэгдүгээрт нь саад. Хоёрдугаарх гол шалтгаан нь юу вэ гэхээрээ гадаадаас ямар нэгэн хэмжээний мөнгө шилжүүлэгч ингээд мөнгө угаах, авлига гээд олон зүйлүүдийг шалгаж нягталдаг учраас зүв зүгээр хаа нэгэн газар руу компани байгуулагдаагүй байхад мөнгө шилжүүлж болдоггүй хууль хэрэгжээд явж байгаа шүү дээ. Монголчууд ч гэсэн үүний дагуу 20 сая төгрөгөөс дээшээ мөнгө шилжүүлэхэд бид нар бүгдийг нь мөнгө угаахын дагуу шалгадаг.

Тийм учраас энэ заалт чинь өөрөө хиймлээр бүгдийг нь хааж хориглож байна л гэж байгаа. Хаагаад хориглоод, тэр бизнесийн эрх чөлөөг нь бид нар хаагаад энэ улс хөгжих үү, хөгжихгүй шүү дээ. Бүх юмаа хаачихсан Хойд Солонгосоо

хар л даа, Кубыг хар. Тэнд ард иргэдийн амьдрал нь 15 доллароор цалингаа аваад, тэгээд амьдрах хэцүү шүү дээ. Тэгэхээр бид нар энэ хааж, боодог нийгэм рүү биш бид нар илүү нээлттэй байж энэ улс орон нь хөгжинө. Боломжийг нь олгоо гэдэг ийм л зүйл байгаа. МИАТ-ийн жишээг би хэллээ шүү дээ. Хаагаад боогоод ингээд явсан, улс орноороо яасан. Гэтэл иргэний агаарын тээврийг салбарлангуут МИАТ ч хөгжинө. Энгийн Монгол ард иргэд хямдхан билетээр гадагшаа зорчиж юм үзэх эрх нь нээгдэж байгаа. Хуучин зөвхөн мөнгөтэй хүн.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Бизнесийг хааж байгаа зүйл алга. Монголд орж ирэх гэж байгаа гаднын цагаачдыг хязгаарлах тухай яриад байгаа юм би. Монголд 1 сая төгрөг төлөөд хамтарсан компани нэртэй, хэдхэн төгрөг төлөөд байр авсан нэртэйгээр бүх иргэнд нээлттэй болгодог чинь тэгээд сайхан зүйл үү. Гаднынханд нээлттэй байх тухай яриад байна шүү дээ. Би гаднынханд нээлттэй байж болохгүй гэж хэлээд байна. Гуравхан сая хүнтэй Монгол шүү дээ энэ чинь. Дороо уусаад алга болно. Бидэнд үнэ цэнтэй нэг юм бий тэр бол тусгаар тогтнол. Үүнийгээ бид хайрлаж гамнаж явах ёстой. Бид нар ингээд гаднынхныг цувуулаад, цувуулаад байх юм бол нэг өдөр тэд нар бид нараас илүү олонх болчихсон. Энэ чөлөөт ардчилсан нийгэм чинь хамгийн их санал өгдөг, энэ төрийг чинь бүрдүүлдэг болчихно. Түүнээс биш би хувь хүний бизнесийн тухай яриагүй. Би Монголд ирэх гэж байгаа цагаачдын тухай ярьж байна.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар Шадар сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: Даваасүрэн гишүүн та үүнийг мушгиад яриад байна л даа. Би гадаадын хөрөнгө оруулалтын

тухай хууль оруулж ирж байгаа юм. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулж ирээгүй. Таны яриад байгаа зүйл тэр хуулиараа зохицуулагдаад явж байгаа. Тэр хуульд чинь гар хүрээгүй. Худлаа ингэж мушгиж бас ярьж болохгүй шүү дээ. Юм болгоныг хаана, бооно гэдэг наад коммунист сэтгэлгээ чинь Монгол Улсыг хаашаа л аваачих бол доо. Бид нар Монгол улсад аль болохоор их эрх чөлөөтэй гадагшаа харсан бодлогоо зөв явуулж байж л энэ Монгол улс хөгжинө, бизнес хөгжинө. Түүнээс биш нэг худлаа ингэж хоолойгоо шахаж ярьдаг, худлаа гүтгэж ярьдаг, бизнесийн орчныг хаадаг, бизнес эрхлэгчид болон иргэдэд юу хийхийг нь хүртэл бүгдийг нь зааж өгнө гэдэг наад сэтгэхүй чинь Монгол Улсыг хорлоно шүү. Бид нар, би энэ Монгол Улсынхаа ард иргэдэд итгэж байгаа. Залуу үе, бизнес эрхлэгчдэд итгэж байгаа.

Энэ хүмүүсийн бизнес хийх эрх чөлөөг нь л бид нар нээж өгөх хэрэгтэй. Тэгж байж энэ Монгол Улс хөгжинө. Одоо та нар гараад яваад үз л дээ, бизнес эрхлэгчид ямар хүндрэлтэй байна вэ. Болохгүй, бүтэхгүй л гэж ярьдаг байсан. Би дахиад хэлье. МИАТ-ийн жишээ. Энэ Иргэний агаарын тээврийн зах зээлийг либералчилчих юм бол манай МИАТ дампуурчихна гэж ярьдаг байсан. Гэтэл либералчилсан, МИАТ ч хөгжсөн. Манай энгийн ард иргэд гадагшаа хямдхан үнээр гадагшаа явдаг болсон. Энэ зөв бодлого юм байна гэдгийг МИАТ дээр бид нар харж байна шүү дээ. Энэ л зүйл. Бусад зөвхөн уул уурхайн салбарт томоохон хөрөнгө оруулагч нар л орж ирж байх ёстой юу. Үгүй шүү дээ. Бусад салбаруудад нь бас хөрөнгө оруулалт орж ирэг. Үүнийг манай бизнес эрхлэгч нар шийдэг л дээ. Ард иргэд өөрсдөө л шийдэг л дээ. Цөөн нэгэн хүн өөрсдийнхөө бодлыг тулгах шаардлагагүй шүү дээ.

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Бид нар сүүлийн 10 жил энэ тухай их ярьж байна. Гадаадын хөрөнгө оруулалт, дотоодын хөрөнгө оруулалт гээд. Тэгээд энэ дээр бас үе, үе яригдаж байгаа бид нарын нэг асуудал байгаад байгаа юм. Аж үйлдвэржилтийн бодлогын асуудал гэж яриад байгаа. Зарим гишүүд худалдааны бодлого чинь манай төрд тодорхой болоогүй байна шүү дээ гээд ингээд яриад байгаа юм. Сая тэгээд Хүрэлбаатар сайд ч байна уу, Даваасүрэн сайд, Болорчулуун сайд ч гэсэн ингээд асуудлууд ярьж байгаа юман дээр ер нь сүүлийн үед 2 хандлага яригдаад байна шүү дээ. Нэг нь бол протекционист бодлого буюу хамгаалалтын бодлогыг зарим нь дэмжээд байна.

Нөгөөдөх нь болохоор зэрэг либералчлал хийж улс орны эдийн засгийн амь оруулж дэмжих ёстой байна гээд. Гэтэл энэ дээр чинь ерөөсөө явж явж эхлээд хөрөнгө оруулалт нь зөв үү, буруу юу гэж. Хөрөнгө оруулалт бүгд зөв шүү дээ. Гол юм нь бид нарын сүүлийн үеийн ерөөсөө яригдаад байгаа юм нь манай улсын аж үйлдвэржилтийн бодлого, худалдааны бодлого юу юм бэ гэдэг дээр тодорхой болгочих юм бол хаана нь хамгаалаад, хаана нь дэмжих юм бэ. Хүнсний хувьсгал хийнэ гэж байна. Тодорхой хэмжээний татаас дэмжлэг, хамгаалалтын тэр протекционист бодлогыг нь явуулна гэдэг санаа байгаа юу, байгаа. Хүнсний хувьсгал дээр.

Тэгэхээр бид нар үүнийгээ бодохгүй бол түрүүн хэлж байна шүү дээ. Импортыг орлох бүтээгдэхүүн бараа ажил үйлчилгээг үйлдвэрлэж байгаа бол дэмжинэ гээд. Жишээлбэл сүүлдээ Цогтбаатар гишүүн, бусад гишүүд ч гэсэн яриад it паркийн чөлөөт бүсийг байгуулъя. Энэ дээр хөрөнгө оруулалт татварын, тарифын ч гэдэг юм бүх чиглэлийн хөнгөлөлттэй бодлого явуулъя ч гэдэг юм уу. Тэгэхээр энэ юмнууд нь ингээд нөгөө яригдаж өгөхгүй болохоор, зүгээр хөрөнгө оруулалт зөв шүү дээ гээд. Тэгэхээр нөгөө талын хүмүүс ерөөсөө энэ

чинь хавтгайд нь ингээж оруулж болохгүй гээд л. Тэгээд энэ дотор зарим нь ярихдаа ажлын байр нэмэгдүүлэх нь чухал, өрсөлдөөнийг дэмжих нь чухал, үйлдвэрлэлийг дэмжих нь чухал гээд л. Гэтэл үйлдвэрлэлийг дэмжихийн тулд энэ чинь янз, янзын арга хэрэглэнэ л дээ. Түүнийг чинь хамгаалахыг нь ч хамгаална, дэмжихийг нь ч дэмжинэ. Либералчилж импортын хязгаарлалтуудыг нь авч хаяхыг нь ч хаяна, экспортыг нь дэмжинэ гэдэг ч юм уу. Тэгэхээр би энэ асуудал дээр Эдийн засгийн хөгжлийн яам ингээд ирэхээр Худалдааны хуультай болж болохгүй гэж ярьдаг гишүүд байгаа. Худалдааны хуультай байх ёстой гэж ярьдаг гишүүд байж байгаа. Тэгэхээр энэ улс орнуудыг чинь хараад байхаар тодорхой хотууд хүртэл худалдаа үйлчилгээний бодлогоосоо хамаараад баар нь хэдэн цагт ажиллах вэ. Нэг дор ажиллахгүй ажиллахгүй байна, зарим өдөр нь нөгөөдөх нь ажиллана зэрэгцээ хажуудаа ажиллахгүй ч байна гэдэг юм уу ингээд юмнууд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ болгонд чинь би юу хэлэх гээд байгаа юм гэхээр, энэ хөрөнгө оруулалтын бодлогыг ярихдаа тэр би мэргэжлийн хүн биш. Гэхдээ бусад улс орнуудыг харахад тэр трейд полиси буюу тэр худалдааны бодлого тэр шинэчлэл чинь өөрөө эхлээд чухал байгаа юм биш үү. Түүнийгээ дамжсан аж үйлдвэржилтийн бодлого гээд. Тэгэхгүй болохоор ингээд ярихад бол хөрөнгө оруулалтыг дэмжигч тал, хөрөнгө оруулалтыг тодорхой хэмжээгээр хязгаарлах тал гэдэг юм. Хуваагдчихаад байгаа юм, нэгд. Тэгэхээр энэ дээр бодлого юу байна.

Хоёрдугаарт, Хүрэлбаатар сайдын хэлээд байгаа асуудал уул уурхай дээр их ороод байна бусад чиглэлд гэж. Тэгэхээр бусад чиглэлд юм жишээлбэл энэ Хөрөнгө оруулалтын тухай хуульд бидэнд хамгийн амин чухал юм харахад энэ сүүлийн үед бид Эстониог яриад байгаа. Жижиг улсууд бол төрөлжсөн нэг тодорхой юм байгаад байна шүү дээ. IT-ийн чиглэл дээр хоцрогдол байна уу, байна

манайд. Тэгэхээр энэ дээр бусад улс орноос илүү бүүр онцгой тийм нөхцөл олгох арга юу байгаа юм. Үүнийгээ бодмоор.

Хөдөө аж ахуй дээр гээд ярихаар манай хөдөө аж ахуй чинь уламжлалт зах зээл, уламжлалт юмаа хамгаална гээд яваад байдаг. Тэгвэл тэнд арай жоохон жим гаргаад уламжлалт зах зээлээсээ болиод, зөвхөн тэр эрчимжсэн хот төв суурин хэсгийнхээ хэсэг дээр хөрөнгө оруулалтын орчныг дэмжсэн бодлого нь хаанаа чиглэх ёстой юм ч гэдэг юм уу. Ийм мэтийн онцлог юмнууд нь юу байж болох вэ гэж. Хууль бол төрийн бодлого шүү дээ.

Өнөөдрийн энэ орж байгаа Хөрөнгө оруулалтын тухай хууль ороод ирэнгүүт дахиад л нөгөө сүүлийн 10 жил яригдсан, өө тэр нь ингээд ерөнхийдөө ингэж байгаа гэж. Либералчлал нь хаанаа илүү очоод байгаа юм, хаанаа юм нь чангараад байгаа юм. Тэгэхээр энэ онцлог нь жишээлбэл илтгэл ч юм уу бусад юман дээр гарч ирэх ёстой. Энэ онцлог ялгаа нь эндээ би байх ёстой болов уу гэж бодож байгаа.

Түүнээс биш ерөнхий зарчим ярих юм бол бүгд бид нар чинь бараг хараад үзэх юм бол аль, аль нь зөв яриад байгаа юм. Тэгэхээр тэнд би энэ асуудлууд дээр нь илүү чиглэж тодорхой тайлбар өгвөл бас хаа хаанаа ойлгогдох юм болов уу гэсэн ийм л бодолтой байгаад байгаа юм.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: Сүхбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь Худалдааны хууль байх ёстой юу гэвэл би байх ёстой гэж ойлгож байгаа. Тухайлбал энэ нүүрс байна. Нүүрсний худалдааг бид нар нэлээд их хийсэн. Тэгсэн мөртөө ингээд ихээхэн хэмжээний гэрээ хийгээд, оффтейк гэрээнүүд хийгээд, нүүрсээ бид

нар ам үнээр зардаг. Нүүрсээ ам үнээр зарахаар худалдан авагч тал нь тээврээ хариуцаж байгаа. Гэтэл би бол Худалдааны хууль хэрвээ гаргаад, экспортыг ямар нөхцөлөөр хийх байсныг заачихсан бол тухайлбал тэр хууль дотор хил үнээр бүтээгдэхүүний экспортолно гээд заагаад өгчихсөн байсансан бол энд олон төрлийн оффтейк гэрээнүүд хийгдэхгүй. Маши их хэмжээний валют гадагшаа гадаадын тэр компаниудад тээвэр хийхэд нь зарцуулагдахгүй байсан. Хил үнээр хийчих юм бол тэр бүх тээвэрлэлтийг манай Монголын компаниуд хийх шаардлагатай болчхож байгаа юм. Тийм учраас би яг Сүхбаатар гишүүний хэлж байгаа зүйлүүд дээр Монголынхоо эдийн засагтай алдагдалтай байж болох тэр худалдааны асуудлуудыг бүгдийг нь зохицуулсан Худалдааны хууль байх нь зөв гэдэг зүйлийг ялангуяа энэ нэг нүүрстэй холбоотой асуудалтай холбоотойгоор энэ Эдийн засаг хөгжлийн сайд болсноосоо хойш хатуу ойлгож авсан. Тэгээд манай яам энэ дээр ажиллаж байгаа гэдгийг нэгдүгээрт нь хэлье.

Хоёрдугаарт нь, үйлдвэржилтийн тухай асуудал байгаа. Энэ чинь хөрөнгө оруулалтыг дэмжих хууль гэдэг чинь Монгол улсад баригдах үйлдвэрийг, ажиллах хууль эрх зүйн орчныг бид нар хангаад байна шүү дээ. Хангах гээд яриад байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ хууль батлагдаж байж тэр үйлдвэрүүд нь орж ирэх бололцоо нь орж ирнэ. Өнөөдөр хүртэл яагаад орж ирэхгүй юм бэ гэхээр төрөл бүрээр нь хавчдаг, хаадаг ийм л зүйл байгаа юм. Тэгэхээр энэ Хөрөнгө оруулалтын тухай хууль хийгдэж байж тэр үйлдвэрүүд чинь Монголд орж ирнэ. Үйлдвэр үйлчилгээнүүд нь Монголд орж ирж ажиллах ийм боломж нь нээгдэж өгөх ийм юм. Тэгэхгүй бол бид нар ингээд хаагаад, бүх талаар нь хааж боодог, нөгөөх нь мөнгө шилжүүлэх бүх боломжийг нь хаачихсан байхад бид нар Монгол Улсад хөрөнгө оруулалт орж ирэхгүй шүү дээ. Бид нар тэр бизнес

эрхэлж байгаа хүмүүст өөрсдөө яаж шийдвэрээ гаргах боломжийг нь олго, сонголтыг нь олгоод өгчих гэсэн ганцхан ийм зорилгоор энэ хуулийн асуудал орж ирж байгаа.

Ер нь эдийн засгийг хөгжүүлбэ гэвэл, эдийн засгийн эрх чөлөө эрх чөлөөг нэлээд нэмэгдүүлж өгөх ёстой. Эдийн засгийн эрх чөлөө нь “тэг” байж, байж эдийн засаг хөгжинө гэж байхгүй шүү дээ. Тэгвэл нийт ард түмэн иргэд ядуу л байна. Ядуу байвал нөгөө цөөхөн цус ярьдаг хэдэн хүмүүс сонгогдоод яваад байна. Тэгмээргүй байна шүү дээ. Энэ сайхан залуучуудыг ажиллах амьдрах бүх бололцоог нь бид нар хангаж өгөх ёстой. Боломж олго, эрх чөлөөг олгоё гэдэг л ийм л үндсэн асуудлууд бидний өмнө тулгамдаад байгаа юм гэж хэлмээр байна.

Г.Занданшатар:

Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн тодруулж асууя.

Ж.Сүхбаатар: Тэгэхээр энэ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хэлэлцэх эсэх явж байгаа. Сая миний асуултуудыг бол хариулт гэхээс илүүтэй бас манай энэ Ажлын хэсэг ч гэсэн яамныхан энэ онцлог, саяын хэлдэг чиглэлээр ялгааг хувааж олон нийтэд болоод гишүүдэд Байнгын хороон дээр үүнийгээ тодруулж яримаар байгаа юм. Яг л уламжлалт байдлаар Хөрөнгө оруулалтын хуулийг яримааргүй байгаа юм. Тухайлбал илтгэлд нэг зүйлүүд гарахгүй л байх. Шинэ сэргэлтийн бодлоготойгоо холбогдуулаад хөгжилд саад болж байгаа хүчин зүйлүүдийг 2030 он хүртэл алга болгоно гээд байгаа шүү дээ. Нөгөө боомтын сэргэлт, нөгөө аж үйлдвэр, нөгөө ногоон хөгжлийн асуудлууд ч гэдэг юм уу. Тэгэхээр энэ асуудлуудтай нь уясан либералчлал байлаа гэж бодоход шинэ юм нь юу юм бэ. Геополитикийн энэ хойд 2 хөрш чинь ийм байна, энэ тэрээ гэгчихсэн энэ байгаа үед хөрөнгө оруулалтын бодлого маань өөрөө ямар

уян хатан маневртай юм шилжиж байгаа юм бэ гэдэг юмыг нь бас гаргаж өгмөөр байгаа юм.

Тэгээд нэг зүйлийг нэмээд хэлэхэд энэ гэрээний асуудал их чухал шүү. Гэрээ хуулиас доогуур гэж Монголд ойлгодог, энэ байдал дээр бол бас их анхаармаар байгаа юм. Гэрээ бол хуулиар.

Г.Занданшатар: Хариулах уу. Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Би Сүхбаатар гишүүнтэй санал нэг байна. Ер нь энэ дээр төрөл бүрийн хуулиудтай холбоотой ер нь энэ гишүүдэд мэдээллээ гаргаж өгөх, хамтарч ажиллах чиглэлийг энэ хэлэлцэх эсэхээ асуудлаа шийдчихээд хийгээд явах нь зөв. Яагаад гэвэл Хөрөнгө оруулалтын хуультай холбоотойгоор эргэлзээнүүд ч байдаг. Нэг талд нь гаргаж мушигдаг ийм зүйлүүд ч байгаа учраас Сүхбаатар гишүүний хэлж байгаа энэ болгоомжлол ер нь нэлээн сайн ажиллах ёстой, үүнтэй санал нэг байна гэдгээ хэлье.

Г.Занданшатар:

Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Дэг дээр байгаа л даа. Тэгээд бас үүнийг ингэж бодоорой. Бас ажлын хэсэгт хэлэхэд. Сонгуулийн хуулиар анх удаа бүсчилсэн зохион байгуулалт руу орж байгаа шүү. Хөрөнгө оруулалтын бодлого бас бүсчлэлээрээ ялгаатай байж болно шүү, бас түүнийг бодоорой. Алслагдсан баруун хязгаар нутагт хөрөнгө оруулалтын бодлого гэж бараг заримдаа тусдаа бас гарч ирэх байх гэдэг хүртэл бас тооцооллыг бодоорой. Түрүүний тэгээд хэлдэг. Сая сүүлд Баабар гуай бичсэн байна билээ. Тэр Гэрээний хууль гээд байгаа юм. Уг нь гэрээний хууль гэж байх шаардлагагүй ч гэсэн манайд бараг гэрээний хууль гэж байгаа юм. Гэрээ бол хуулиас дутуугүй хүчин чадалтай байх ёстой. Шүүх дээр очихоор хууль нь ийм байна гээд байдаг. Гэрээ өөрөө. Тэгээд бид аргаа ядаад Хөрөнгө

оруулалтын хуулиудаар тогтвортой байдлын гэрээгээр чинь хуулиас давсан байдал гэдэг асуудал гаргаж тавьж ингэж хөрөнгө оруулагчдыг хамгаалаад байсан. Шүүмжлэлд их өртсөн.

Тэгэхээр гэрээ бол бас хууль юм гэдэг тэр механизмыг яаж энэ хөрөнгө оруулалтыгаа хууль бусад хуультай нь уялдуулж авч үзэх вэ гэдэг энэ юмыг хүртэл бас бодох хэрэгтэй гэж ингэж үзэж байна.

Г.Занданшатар: Санал юм даа. Тэгэхдээ энэ Эдийн засаг хөгжлийн яам тэр Худалдааны хууль дээр ажиллах зайлиггүй шаардлагатай байгаа. Ер нь худалдааны эрх зүй мянга гаруй жилийн түүхтэй. Зарим улсад Сүхбаатар гишүүний хэлж байгаа гэрээний эрх зүй, худалдааны эрх зүй бол Иргэний хуулиар болон паблик прайвит хуулиудаар зохицуулагддаг ч гэсэн манайд алинд нь ч ингэж нэг эрлийз байдалтай болчихоод байгаа учраас худалдааны эрх зүй, гэрээний эрх зүй тэгээд түүнээс үүсэж байгаа Дампуурлын тухай хууль Иргэний хуульд цогц өөрчлөлт хийж байж энэ хувийн эрх зүй, худалдааны эрх зүйн шинэчлэл хийхгүй зөвхөн Гадаад худалдааны хууль гэж бас байна. Демпингээс авхуулаад ингээд маш олон асуудал зохицуулагдаж байдаг. Ийм эрх зүйн харилцаанд тэр Худалдааны яам, худалдааны эрх зүй, тэгээд гааль, тэгээд Эксим банк энэ тэр чинь нэг ийм тогтолцоо байгаа юм л даа. Тэгээд энэ бүхнийг нэг мөр цэгцлэх шаардлагатай байгаа юм. Дамдины Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Тэгэхлээр надад хэд, хэдэн асуулт байна. Нэгдүгээрт, Хүрэлбаатар сайд аа, Монголд одоо хөрөнгө оруулъя гээд хөрөнгө оруулах сонирхлоо илэрхийлчхээд байгаа хэр хэмжээний мөнгө байгаа юм бэ. Энд ингээд хэлэлцүүлгийг сонсож байхад нэг үүдэн дээр баахан мөнгөтэй

хүн ирээд л очерлочихсон Монгол руу хөрөнгөө хийхгүй бол өөр газар хийх газар олдохгүй юм шиг болчихсон. Бид нар маш өрсөлдөөнтэй ертөнцөд амьдарч байгаа учраас тийм их мөнгө цуглачхаад тэгээд бид нар түүнийгээ оруулах, оруулахгүйг нь шийдэх гээд ингээд суугаад байна. Тийм моодонд орчихсон байгаа юм уу. Энэ эдийн засгийн өнөөдрийн нөхцөл байдал чинь тэр хөрөнгө оруулалтын нөхцөл байдалтайгаа харьцуулахад тэгвэл таарахааргүй байгаа байна. Тэгэхлээр энэ дээрээ тийм их мөнгө орох гээд байгаа юм уу, хэр хэмжээний хүлээлт байгаа юм. Мэдээжийн хэрэг хуулиа оруулахдаа энэ судалгаагаа хийсэн байгаа байх.

Хоёр дахь нь, энэ хууль чинь яг хөрөнгө оруулалтын асуудлыг шийдсэн хэд дэх хууль болж байна. Би яагаад үүнийг асууж байна гэхлээр манай Монголд хамгийн тогтворгүй юм бол харин ер нь гадаад хөрөнгө оруулалтын хууль юм биш үү. Дуртай үедээ хэдэн удаа өөрчилдөг. Тэгэхлээр ингэж өөрчлөөд байхлаар хууль нь өөрөө тогтворгүй гэдэг сэтгэгдэл төрчихсөний дараа юу ч гаргаад бид нар тогтвортой байлгаж чадахгүй. Жишээлбэл саяхан энэ Төсвийн хууль оруулж ирэхэд дагаад хэчнээн олон хууль өөрчлөгдсөн бэ. Хууль эрх зүйн орчин чинь өөрөө ингэж өөрчлөгдөөд байгаа юм. Тэгэхлээр тэр гадаадын хөрөнгө оруулагчид чинь хууль эрх зүйн орчны тогтвортой байдлыг л хүсээд байгаа юм. Тэгтэл бид нар төсвөө оруулахдаа өчнөөн эрх зүйн орчин өөрчлөгдөх ийм шинжтэй байгаад байвал энэ чинь хэр баталгаатай вэ. Тэгэхлээр энэ хууль маань өөрөө тэр тогтвортой байдлын хэр баталгааг гаргаж өгч чадах вэ гэдэг асуудал.

Гурав дахь нь, Сүхбаатар гишүүн түрүүн яг хэллээ. Миний асууя гэж байсан юмыг. Уг нь би дижитал бизнесийн чөлөөт бүс байгуулъя гэдэг санал гаргаад явж байсан юм. Тэгээд яг үнэхээр энэ дижитал бизнесүүдийг Монгол руу татъя гэж байгаа бол тэр дижитал бизнес юм. Түүнээс бусад бизнес юм биш шүү.

Чөлөөт бүсийг байгуулаад өгвөл уг нь ёстой энэ фэйсбүүк эд нарыг яг тэр Кембриж аналитика эд нар эхлэхээс нь өмнө энэ саналыг тавьж байсан. Тэгээд тэр гарсны дараа уг нь ёстой хөрөнгө татах боломж гарсан. Бид нар түүнийг алдчихсан байгаад байгаа юм. Гэхдээ боломж нээлттэй л байгаад байгаа учраас энэ асуудлыг хэр судалсан бэ, энэ хуулийг оруулахдаа.

Дөрөв дэх асуудал нь, Төрийн өмчит компаниудыг марторт тавих тогтоол ингээд оруулж ирсэн. Би энэ бол гадаадын хөрөнгө оруулалттай шууд холбоотой шүү. Яагаад гэвэл нөгөө бизнесийн шударга өрсөлдөөний орчин байна уу, үгүй юу гэдэг чинь гаднын хөрөнгө оруулагчдын хамгийн том шалгуур юм. Тэгэхлээр энэ төрийн өмчит компаниуд байгаа тохиолдолд бизнест энэ шударга орчин чинь бүрэн хэмжээндээ итгэл төрүүлэхгүй байхгүй байгаа шүү гэдгийг бас хэлмээр байгаа юм. Тэгэхлээр энэ асуултад бас хариулж өгөөч. Хэр үүнтэй уялдуулж харсан.

Тав дахь асуулт нь, экспортыг дэмжих зүйл, заалтууд энд хэр орсон байгаа вэ. Энэ 5 асуултыг хэлмээр байна. Худалдааны хууль дээр Хүрэлбаатар сайд хүртэл сая өөрөө ярьж байна. Энэ хил нөхцөлөөр зарна. Энэ чинь инкотермсинг угаасаа борлуулж байгаа улсууд өөрсдөө сонгодог зүйл. Үүнийг хуульд оруулж ирнэ гэвэл аюул болно шүү дээ. Бизнесүүд өөрсдөө сонгоно. Ер нь энэ Эдийн засгийн яамныхан Дэлхийн худалдааны байгууллагын трэйд паласыг уншсан хүн байна уу. Одоо энд сууж байгаа ажлын хэсгээс би асуумаар байна. Аль орныхыг уншсан. Ядаад Монголынхыгоо уншсан уу. Трэйд паласын ревью. Тэгээд дараа нь худалдааны хуулиа ярьцаая.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Эхний асуулт нь ингээд Монгол Улсын хил дээр ингээд

мөнгөө барьчихсан хөрөнгө оруулагч нар ингээд очерлоод зогсож байгаа юу гэдэг асуудал. Тийм юм байхгүй. Гадаадын хөрөнгө оруулалтыг өөртөө татаж авахын төлөө улс орнууд өрсөлддөг. Хэрвээ Монголд болохгүй бол өөр орон руу яваад өгнө шүү дээ. Тэр тусмаа өнөөгийн үе шиг ийм мөнгө үнэ цэнтэй болчихсон, хүү өсчихсөн ийм цаг үед бол хаана таатай нөхцөл байна тийшээ л хөрөнгө урсана. Тэнд хөгжил явагдана. Бид нар энэ дээр хил хаахаа яриад, цусаа яриад суугаад байвал энэ улс орон хөгжих үү, хөгжихгүй шүү дээ. Дотроо улам хагарна, дотроо улам эвдрэлцэнэ. Энэ нь эргээд хүмүүст энэ улс чинь хөрөнгө оруулалт оруулдаг таатай улс биш юм байна гээд гараад явчихна. Тэгэхээр нэг их очерлоод байгаа юм байхгүй.

Харин Монгол Улс руу бас боломжийг нь гаргаад үүсгээд өгчихвөл хөрөнгө оруулалт орж ирэхийг би үгүйсгэхгүй гэдгийг би энд онцолж хэлмээр байна. Тийм учраас бид нар хөрөнгө оруулалтыг татаж нэмэгдүүлж байж энэ улс орныхоо хөгжлийг хурдасгах тухай л ярьж байгаа. Өөр янз бүрийн зүйл байхгүй гэдгээ хэлье.

Худалдааны хуультай холбоотойгоор, хуучин Гадаад хэргийн яам бол гадаад худалдааны бодлогыг хариуцаж явж байсан. Манай яаманд энэ гадаад худалдааны бодлого ирсэн. Үүнтэй холбоотойгоор бид нар Өмнөд Солонгостой чөлөөт худалдааны хэлэлцээр хийж байна. ОХУ-тай Монголоос гарч байгаа арьс шир, мах, ноос, ноолууран бүтээгдэхүүн зэрэг 400 орчим нэр төрлийн бүтээгдэхүүнийг ямар нэгэн татваргүйгээр Оросын зах зээл рүү оруулах тухай ярьж байна. Тэгээд ер нь энэ худалдааны асуудлуудаа бид нар нэлээд харж үзэж байгаа. Янз бүрийн бодлогын бичиг баримтуудыг бодож, харж үзэж байгаа.

Харин түрүүчийн тэр хил үнэ гэдгийг би хэлэхдээ, жишигээр экспорт

дээр энэ бодлогуудаа тодорхой байлгахгүй бол хэтэрхий худалдан авагч талын хүсэл эрмэлзэл давамгайлах ийм талууд байгаа учраас энэ дээрээ төрийн бодлогоо гаргаж, харж, үзэж оролцох ёстой гэж ойлгож байгаа. Миний хувьд.

Г.Занданшатар: Үлдсэн дээр нь хэн хариулах вэ. Ажлын хэсэг. Идэшийн Батхүү 83.

И.Батхүү: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү.

Гадаад харилцааны яамнаас 2021 оны 3 сарын 7 онд Дэлхийн худалдааны байгууллагын гаргаж өгсөн тэр Монгол Улсын худалдааны бодлогын тайлантай бид мэдэж байгаа танилцсан. Өнгөрсөн хугацаанд Гадаад харилцааны яамнаас худалдааны бодлогыг шилжүүлж авсантай холбоотой баримт материалуудыг танилцаж судалж байгаа. Үүний зэрэгцээ 2023 оны 5 сард Засгийн газрын 178 дугаар тогтоолоор уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжих хуулийн төсөл боловсруулах мөн үүнтэй холбоотой бодлого боловсруулах чиглэл үүрэг аваад манай яамнаас төслийг боловсруулж ажиллаж байгаа. Үүнээс гадна сая Хүрэлбаатар сайдын дурдсан БНСУ-тай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн эхний раундыг сая 12 сард Гадаад харилцааны яам, бусад яамд гаалийн байгууллага гээд 35 хүний бүрэлдэхүүнтэйгээр очиж эхний раундыг хийсэн байгаа. Мөн ОХУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээрийг бас ОХУ-ын Эдийн засаг хөгжлийн яамтай байнга ажиллаад хийгээд явж байна.

Мөн бусад улс орнуудтай бүс нутагтай байгуулах чөлөөт худалдааны хэлэлцээрийн холбогдох судалгаануудыг манай яамны зүгээс ревью хийгээд ажиллаж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Энэ Хөрөнгө оруулалтын тухай хуульд ер нь хэдэн өөрчлөлт орсон бэ гэж. Анх энэ гадаадын хөрөнгө оруулалтын хууль 1993 онд батлагдсан. Үндсэндээ гадаад хөрөнгө оруулагч нар энэ хуулийг их сайн хууль болсон гэж үздэг юм байна билээ.

Дараагийнх нь 2013 онд томоохон өөрчлөлт орсон. Одоо энэ нь хэрэгжээд явж байгаа. Үүнийг өөрчлөлт оруулъя гэдгийг бид нар оруулж ирж байгаа юм гэдгийг хэлье. Дотор нь орсон нэг жишжиг сажиг өөрчлөлтүүд юу гэдэг юм, хөрөнгө оруулалтын асуудлыг хариуцсан агентлаг байна, байхгүй гээд л, байсныг нь татан буулгах эргэж сэргээх зэрэг ийм өөрчлөлтүүдийг оруулаад үзвэл 12 удаагийн өөрчлөлтүүд байгаа гэдгийг хэлье.

Дижитал чөлөөт бүс энэ хуулиар зохицуулагдахгүй.

Г.Занданшатар: Дамдины Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Тэр юуг уншсан гээд байгаа залуу надад хариулаадаа даа. Монголын худалдааны бодлогыг нэгдүгээрт хэдэн удаа хэлэлцэгдсэн байна. Хоёрт, хөрөнгө оруулалтын бодлого тэнд орсон байна уу. Яагаад бид ингэж асууж байгаагаа дараа нь би тайлбарлая.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Яах вэ бид нар энэ хөрөнгө оруулалтын тухай хууль оруулж ирж байгаа юм, Худалдааны хууль оруулж ирээгүй. Бид нар хэн юу мэддгээрээ мэтгэлцэж болно. Гэхдээ энэ оруулж ирсэн хуультай холбоотой асуудлаараа ярилцмаар байна.

Г.Занданшатар: Дамдины Цогтбаатар гишүүн асууя.

Д.Цогтбаатар: Би яагаад үүнийг асуугаад байгаа вэ гэхээр бүр хөөрхий жиижигхэн Монгол Улсынхаа *trade police* үзэхлээр тэнд *триймс* гээд арга хэмжээ байгаа. Бүр *триймс* гээд тусгай гэрээ байдаг юм Дэлхийн худалдааны байгууллагад. Энэ *trade related investment measures* гээд гадаадын хөрөнгө оруулалт тэр худалдаатай чинь шууд холбоотой бөгөөд тэр яригдаад байгаа худалдааны хуулийн асуудал энэ гадаадын хөрөнгө оруулалттай шууд холбоотой байдаг. 1992 оны манай гадаадын хөрөнгө оруулалтын хууль чинь гадаадын экспортыг дэмжих хууль байсан. Нөгөө 3 жилээр 100 хувь хөнгөлөөд дараа нь 5 жил 50 хувь хөнгөлнө.

Яагаад гэвэл экспорт хийхэд гээд. Энэ чинь худалдааны хууль. Худалдаа зохицуулж байгаа. Монгол Улс 30 жил худалдааны эрх зүйн зохицуулалтгүй явж ирсэн гэж яаж бодож болоод байгаа юм. Би түүнийг бүүр гайхаад байгаа юм. Энэ чинь Худалдааны гаалийн хууль, Төмөр замын хууль, Хөрөнгө оруулалтын хууль, Татварын хууль бүгд худалдаатай холбоотой. Гаалийн татварын хууль, гаалийн татвар дотроо гаалийн үнэлгээ чинь худалдааны асуудал. Тэгэхлээр энэ худалдааны зохицуулалт чинь өөрөө байж байгаа юм.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Цогтбаатар гишүүн ээ, бид нар энд Худалдааны хууль оруулж ирэхээр бид нар ажиллаж байгаа. Өнөрболоор гишүүн энэ Худалдааны тухай хууль дээр нэлээд ажиллаад, ажиллачихсан материалыг бид нар үүнийг үзэж байгаад Засгийн газар оруулж ирэх нь зөв юм байна гэж хэлээд, Өнөрболоор гишүүн надад ийм зузаан хавтастай ажиллачихсан материалаа

авчраад өгсөн дээр нь манай яам ажиллаад явж байгаа. Өнөрболоор гишүүн нэлээдгүй ажиллачихсан юм байна билээ. Тийм учраас би юу гэдэг юм огт худалдааны асуудлыг ямар нэгэн ямар ч зохицуулалтгүй явж ирсэн гэж хэлэхгүй. Энд тэндхийн олон янзын хууль дотор энд тэнд 2, 3 заалт үг, үсэг байгаа. Гэхдээ үүнийгээ нэг цэгцлээд Худалдааны хуультай болгочихвол илүү бас зөв юм байна. Ингэж байж энэ хуулиуд их ойлгомжтой болох юм байна, бизнес эрхлэгчдэд ойлгомжтой орчныг бид нар бүрдүүлэх юм байна гэж үзэж ярьж байгаа шүү гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Монгол Улсын эдийн засгийн яг өнөөгийн нөхцөл байдал, уул уурхайн баялаг, хөгжиж байгаа зах зээл гэдгээрээ бид нар олон улсын хөрөнгө оруулагч нарын бас анхаарал татсан их боломжийн эдийн засгийн бүсчлэл гэж харагдана. Гэвч яг гадаадын хөрөнгө оруулалт дээр, дотоодын хэвлэл мэдээллийн дээрээс нь бас тодорхой улс төрчдийн үндсэрхэг үзэлд тулгуурласан саад бэрхшээлүүд их байна. Тэгээд Монголын хөрөнгө оруулалтын талаарх олон улсын экспертүүд олон улсын байгууллагуудын дүгнэлтийг харахад нэлээд хэдэн зүйлийг хэлсэн байдаг.

Жишээлбэл, манай улсын энэ хөрөнгө оруулалтын нөхцөл байдлыг бол ер нь тогтворгүй бодлоготой, гадаадын хөрөнгө оруулагч нарт эрсдэлтэй, шүүхийн процесс хэргийн маргаан шийдвэрлэх процесс нь ойлгомжгүй, дээр нь хууль эрх зүйн орчин тогтворгүй гэдэг ийм сөрөг үндэслэлүүд дээр бас Монгол Улс маань гадаадын хөрөнгө оруулалтыг тогтвортой татаж чадахгүй байгаа.

Тийм учраас бид нар энэ Эдийн засгийн хөгжлийн яамнаас оруулж ирсэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийг маш

сайн ярилцаж дэмжих шаардлагатай. Хэдийгээр манай Улсын хөрөнгө оруулалтад уул уурхайн баялаг эзэлж байгаа боловч бид нар эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн бусад салбараа дэмжихийн тулд энэ тодорхой хөрөнгө оруулалтуудыг бүсчлэн тодорхой салбараар нь дэмжих нь зүйтэй болов уу. Мөн олон улсын экспертүүд Европын худалдааны Танхим зэрэг байгууллагаас хэд хэдэн судалгаа хийгдсэн. Энэ дээр юу гэж үзсэн юм гэхээр, ерөнхийдөө бас Монголын олон нийтийн дунд мөн тодорхой улс төрчдийн өдөөн хатгалтын үр дүнд ер нь гадаадын хөрөнгө оруулалт маань эрсдэлтэй. Гадаадын хөрөнгө оруулалтын шууд болон шууд бус хэсгийг бүрэн тооцсон ийм таниулсан мэдээлэл байдаггүй. Иймэрхүү сөрөг үр дагавар нэлээн хэлсэн байдаг. Тэгээд ер нь иргэдийн дундах энэ сошиал хөөсрөл тодорхой улс төрчдийн тэр дундаа байгалийн баялагт тулгуурласан үндсэрхэг популизм гээд сүүлийн үед манай эдийн засагчид эрдэмтэд нэрлэж байгаа. Энэ зүйлийн уригаар бид нар хөрөнгө оруулалтыг тогтвортой барьж чадахгүй байсан. Одоо энэ байдлаа засах хэрэгтэй байна.

Тэгээд гадаадын хөрөнгө оруулалтыг ямагт тагнуулын болон бусад аюулгүй байдлын шалтгаанаар үгүйсгэдэг. Энэ дээр бид нар эдийн засгийн тодорхой судалгаа тооцоолол мэдээж үндсэн аюулгүй байдлын бусад юмнуудаа хийсэн байж таарна аа. Тийм учраас энэ Эдийн засаг хөгжлийн яамнаас эхний асуулт маань ер нь олон нийтийн дундах энэ хөрөнгө оруулалтын талаар тодорхой цэгцтэй мэдээллийг өгөх асуудал, тэр дундаа гадаадын хөрөнгө оруулалтыг шууд ба шууд бус утгаар ашгийг нь хэрхэн тооцох энэ тал дээр ямар мэдээлэл сурталчилгааны ажлууд хийх вэ.

Ер нь Монгол Улс дахь энэ гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжсэн эрх зүйн орчны доторх нэг гол зүйл энэ

хөрөнгө оруулалтад тулгарсан маргаануудыг шийдвэрлэх, маргаан шийдвэрлэхэд олон улсын арбитрын журмыг оруулаа гэж байна. Энэ тал дээр ямар шинэлэг зохицуулалт орсон бэ гэдгийг нэгдүгээрт асуумаар байна.

Хоёр дахь асуулт нь, манай мэдээлэл энэ дотор нэлээн байна. Ер нь уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт Монгол Улсыг гадаадын хөрөнгө оруулалтын гол юуг эзэлж байна. Тэр дотроо сүүлийн 10 жилийн байдлаар энэ Оюутолгойн хөрөнгө оруулалт нийт гадаадын хөрөнгө оруулалтын 50 хувийг эзэлчихсэн байна. Тэгэхээр бид нар нөгөө алсын хараа болон Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны хөгжлийн бодлогуудад тавьсан гол зорилт бол эдийн засгийг төрөлжүүлэх буюу уул уурхайн бусад салбарыг дэмжих энэ чиглэлд гадаадын хөрөнгө оруулагчид ямар дэмжлэг, ямар зохицуулалт олгох вэ.

Жишээлбэл бид нар Европын холбоотой бас нэлээн хэдэн жилийн турш энэ нэхмэл бүтээгдэхүүн, арьсан бүтээгдэхүүн зэрэг гаргах татварын хөнгөлөлтийн бодлогуудыг хэрэглэж ирсэн байгаа. Энэ мэтээр бусад салбараа дэмжих хөрөнгө оруулалтыг хэрхэн хийх вэ гэдгийг асуумаар байна.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Маргаантай холбоотой асуудлыг манай Анар дарга бэлдэж байгаад хариулаарай гэдгийг хэлье. Ер нь Монгол Улс өөрөө ардчилсан улс. Ардчилсан улс учраас ер нь хүмүүс өөр өөрсдийнхөө л үзэл бодлыг илэрхийлдэг. Гаднын хөрөнгө оруулалт огт хэрэггүй гэж үздэг хүмүүс бас бий. Эсвэл зөвхөн Хятадаас хөрөнгө оруулалт оруулж болохгүй гэдэг үзэлтэй хүмүүс бий. Эсвэл зөвхөн Оросоос хөрөнгө оруулалт Монгол улсад оруулж ирэх ёстой гэж үздэг хүмүүс бий. Эсвэл гуравдагч орноос зөвхөн хөрөнгө оруулалтыг оруулж ирж өгөх

ёстой гэж үздэг хүмүүс бий. Гэхдээ бид нарын хувьд энэ хөрөнгө оруулагч нарыг улс орноор нь ялгах ялгаварлах ийм шаардлагагүй гэж үзэж байгаа. Хэн нь хүсээд, хэн нь эрсдэлээ тооцоод оруулж ирээд хөрөнгө оруулалт хийхэд нь энэ нь нээлттэй байг гэдэг ийм л үндсэн зарчим байгаа. Манай Үндсэн хуулиараа ч тийм. Ялгаварлаж болохгүй гэдэг. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалттай холбоотойгоор хүмүүс өөр өөрийнхөө байр суурийг илэрхийлж байдаг. Тэр чигээрээ нэлээд бас PR хийдэг. Заримынх нь PR нь хэтрээд хүн гутааж доромжлох руугаа чиглэхдээг юмнууд бий. Гэхдээ Мөнхцэцэг гишүүний хэлж байгаа сая зарчмын зүйлүүдтэй би 100 хувь санал нэг байна. Аль болохоор үүнийг зөвхөн төр засаг гэлтгүйгээр тэр хувийн хэвилийнхэн, бизнес эрхлэгчдэд яагаад энэ төрлийн хөрөнгө оруулалт хэрэгтэй вэ, ийм зовлонгууд байна үүнийг бид нар засах шаардлагатай байна гэдгээ нэлээд ил тод ярилцах ёстой.

Засгийн газар бол бизнес эрхлэгчидтэй олон удаагийн уулзалтууд хийж байгаа. Худалдаа аж үйлдвэрийн тэнхимтэй хэд ч уулзчихав. Янз бүрийн клубүүд байдаг юм байна билээ. Тэд нартай нь ч бас уулзлаа, бизнес эрхлэгчидтэй уулзлаа. Энэ хүмүүсийн ярьж байгаа зүйлүүдийг л бид нар энэ Хөрөнгө оруулалтынхаа хууль дээр тусгаж л орж ирж байгаа шүү дээ.

Өөрөөр хэлбэл тэр хүмүүсийн бидэнд нэг ийм боломж олгоодхооч ээ гэдэг зүйл хүсэлтийг хэлж байгаа юм. Боломж олгоод, сонголт бий болгоод өгөөч ээ гэдэг ийм хүсэлт. Түүнээс биш бид нар бүгдээрээ дээрээс нь гарч ирээд чи ингэж хий, энэ нь болохгүй гэж хэлдэг хэн бэ.

Ер нь яг үнэнийг хэлэхэд. Аль нийгэмд амьдраад байгаа юм. Өөрсдөө сонголтгоо хийдэг ийм ардчилсан нийгэмд бид нар амьдарч байна шүү дээ. Тэгэхээр ийшээгээ яваасай л гэж бид нар үзэж

байгаа. Нэг хувь хүний бодол бол хувь хүний л бодол. Тэгээд олонхоороо явна. Эцэстээ бид нар харин Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлсэн, Монгол Улсыг хөгжүүлсэн үү гэдэг асуудал бидний өмнө ирнэ.

Гадаадын хөрөнгө оруулагчдад хандах хандлага сүүлийн 10 хэдэн жилд байгаа байдал нь энэ шүү дээ. Тэгэхээр энэ дээр бид нар энэ танхим дотор бид нар сэтгэхүйгээ ч гэсэн өөрчлөх ёстой шүү гэдгийг хэлмээр байна. Ингээд Анар дарга хариул даа.

Г.Занданшатар: 80 Анар дарга хариулъя.

Б.Анар: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн хөгжлийн яам Анар. Хуулийн төсөлд хөрөнгө оруулагч хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлд гомдол гаргах, зөвлөлөөс гомдлыг хүлээн авч хянан магадлах шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлэх арга хэмжээ авахаар хуулийн төсөлд тусгасан байгаа. Энэ процесс нь өөрөө ямар нэгэн төрийн захиргааны байгууллага, албан хаагчийн хууль бус болон захиргааны актыг хүчингүй болгох эсвэл захиргааны акт гаргахыг даалгах зэрэг ийм захиргааны шүүхийн харьяаллын маргаан биш. Харин Захиргааны ерөнхий хуультай энэ байдлаар зөрчилдөхгүй гэж үзэж байгаа юм. Харин захиргааны шүүхийн харьяаллын маргааны хувьд шүүхийн харьяаллыг нь энэ хуулиар өөрчлөөгүй. Зөвлөлд гарах гомдлын асуудлыг нь сонсох, хэлэлцээр хийх буюу төрийн байгууллагуудын хууль бус үйлдэл эс үйлдэхүйд хөндлөнгийн хяналт тавих улмаар шаардлагатай тохиолдолд маргаан үүсэхээс урьдчилан сэргийлж Засгийн газрын түвшинд асуудлыг танилцуулдаг, шийдвэрлүүлдэг байх процессыг тусгаж өгсөн байгаа нэгд.

Хоёр дахь нь, хөрөнгө оруулалтын баталгаатай холбоотой заалтуудыг энэ хууль дээр нэлээн олон улсын олон улсад тавьдаг шаардлагууд руу илүү дөхүүлсэн. Баталгааг сайжруулсан зохицуулалтуудыг хууль дээрээ тусгасан. Үүнээс дурдах юм бол шинэ хуулийн төсөлд болон хөрөнгийг хураан авахыг хориглох, олсон хөрөнгө болон орлогоо саадгүй гаргах баталгааг төрөөс хуулиараа олгож байгаа. Үүн дээрээ нэмээд төрийн байгууллага албан тушаалтны хууль бус үйлдэл эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагч нь хохирсон тохиолдолд хууль бусаар хөрөнгө дайчлан авсанд тооцож нөхөх олговрыг нь хэрхэн ямар байдлаар тооцож шуурхай олгох зохицуулалтыг хуульд тусгаж оруулж байгаа. Хөрөнгө оруулалтын хууль зүйн болон эдийн засгийн баталгааг нь нэмэгдүүлж оруулсан байгаа.

Хөрөнгө оруулагч бол Монгол Улсад ерөнхийдөө хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахдаа 3 түвшний баталгааг ерөнхийдөө хардаг. Нэгд олон улсын гэрээ конвенцод нэгдэн орсон байна уу, үгүй юу.

Хоёрт, хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих харилцан хамгаалах 2 талт хэлэлцээрүүд байна уу, үгүй юу гэдгийг хардаг. Гуравт нь.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Хөрөнгө оруулалтын тухай хууль орж ирж байгаад талархаж байна. Мэдээж хэрэг Монгол Улсын хөгжлийн бас томоохон гарц хөрөнгө оруулалт яалт ч үгүй мөн. Гэхдээ бид нар энэ хуулиа эрсдэлийн тооцоогоо сайн хийхгүй бол Монгол Улсын хууль эрх зүйн орчин тогтвортой бус улс төрчид нь энгийнээр хэлэх юм үерхэж чаддаггүй гэдэг нөхцөл байдлаас шалтгаалан хөрөнгө оруулагчид дүрвэсэн нөхцөл байдал харагдаж байгаа. 2013 онд Хөрөнгө оруулалтын тухай хууль

баталснаас хойш нийтдээ 11 удаа бид нар нэмэлт өөрчлөлт хийсэн байна гэдэг бол Монгол Улсын хууль эрх зүйн орчин тогтворгүй байгаагийн бас томоохон илэрхийллийн тоон жишээ байх гэж би бодож байна.

Нөгөө талаараа хөрөнгө оруулалтыг сүүлийн 3 жилийн хугацаанд харах юм бол 23 хувийг буюу 2.63 их наяд төгрөгийн гадаадын хөрөнгө оруулалттай ААН бүрдүүлж байсан бол 2022 онд 16 хувь буюу 2.4 их наяд болж буурсан гэдэг ийм тоон мэдээлэл байна. Энэ нь нөгөө л тогтворгүй, туйлбаргүй гэдэг энэ байдлаас шалтгаалсан байдаг. Би хэд, хэдэн зүйлийг тодруулж асууя гэж бодож байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2024 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлж байгаа. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуультайгаа энэ хууль маань хэр нийцэж, хэр дүйцэж байгаа вэ гэдэг зүйлийг асууя. Яагаад ингэж асууж байна вэ гэвэл хөрөнгө оруулагчтай гэрээ хийх энэ асуудлыг Засгийн газрын гишүүд нь өөрсдөө хариуцна гэчихсэн байх юм. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиараа түншлэлийн төв байгуулаад Эдийн засаг хөгжлийн яам болон Сангийн яам хамтарсан түншлэлийн төв байгуулаад хамтран ажиллах түншлэлийн төвөө байгуулах ийм заалт тэр хуульд орсон байгаа. Энэ хуулиудтайгаа хэр нийцэж байгаа юм.

Яагаад Засгийн газрын гишүүн нь хөрөнгө оруулагчтай заавал гэрээ байгуулах ёстой юм. Зүгээр би нэг оёдлын үйлдвэртээ хөрөнгө оруулагч авчраад миний оёдлын үйлдвэрийг жишээ нь Хөдөө аж ахуйн яам гэдэг юм уу, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам хариуцах юм уу. Өөр хэн, ямар яам ба заавал би Болорчулуун сайд дээр очиж гэрээ байгуулах нь л дээ. Яагаад заавал Засгийн газрын гишүүн хариуцах ёстой юм. Энэ нэг асуулт.

Хоёрдугаарт, ямар, ямар салбарт хөрөнгө оруулалт оруулж болох вэ гэдэг

зүйлийг асуух гэсэн юм. Өөрөөр хэлбэл, энэ дээр хэн нэгэнд хориглосон заалт байхгүй байна. Банкны салбарт хөрөнгө оруулалт орж ирлээ гэхэд Монгол Улсад гадаадын банк орж ирэх нь гэдэг ийм ойлголтыг би энэ хуулийг уншаад харж байна л даа. Өөрөөр хэлбэл, Оюутолгойн гэрээ санхүүгийн бүх гүйлгээ гаднын банканд дээр хийгдсэнээрээ маш том эрсдэлийг авч дагуулсан гэдгийг бид нар бүгдээрээ мэдэж байгаа, түүх бидэнд харуулж байгаа. Тэгвэл энд хориглосон салбар байхгүй байна гэдэг энэ зүйл дээр хариулт өгөөч гэдэг зүйлийг асууя.

Үнэхээр Хөрөнгө оруулалтын тухай хууль өмнө нь орж ирээд 50 сая төгрөгөөр билүү худалдан авалт хийснээрээ хөрөнгө оруулагч болчихно гэдэг ийм зүйл ярьсан. Олон нийтийн дунд ч гэсэн энэ асуудал эргэлзээ төрүүлсэн хэвээрээ байгаа. Энэ дээр 4.1.6-д хувьцаа, хөрөнгө, саналын эрхийн 25 хувь буюу түүнээс дээш зүйлийг худалдан авснаараа хөрөнгө оруулагч болно. Санхүүгийн нээлттэй зах зээлээс хувьцаа бонд болон бусад санхүүгийн өгөөжийг хүртэж байх юм бол тодорхой хугацаанд хөрөнгө оруулагч болно гэсэн ийм заалтууд байна. Энэ дээр бас тайлбар өгөөч ээ. Хөрөнгө оруулагч нь энэ мэтээр хөрөнгө оруулагч болчих боломжийг үүссэн гэсэн үг үү. Үнэхээр бид нар гаднын хөрөнгө оруулалтыг Монголд оруулж ирсэн ирснээрээ хөгжлийн дараагийн шатыг харах боломж байгаа боловчиг нөгөө талаараа Монгол Улсын тогтвортой байдал, тусгаар тогтнол, дархлаа гээд том ярих юм бол олон зүйлийг ярьж болох байх. Тэгвэл яг энэ бүхэн дээр хязгаарлалт тавьсан зохицуулалтууд ер нь энэ хуульд ер нь хэр байна вэ гэдэг зүйлийг асуух гэсэн юм.

5.3 дээр төрөөс үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжоор гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хязгаарлаж болно гэсэн байна. Энэ дээр ямар нэгэн зүйл заалт

гэдэг юм уу, салбар байгаа юу гэдэг энэ асуултад бас хариулт авъя. Ер нь 5.1.7 дээр оюуны өмчийн эрхийг холбогдох хуульд заасны дагуу эдийн засгийн эргэлтэд оруулахад хөрөнгө оруулалт хийх боломжтой гэсэн байна. Оюуны өмчийн тухай хууль маань өнөөдөр ямар хэмжээнд байгаа билээ. Яг энэ зохицуулалт эргээд амьдрал дээр хэрэгжихэд боломж нь ер нь хэр байгаа юм. Өөрөөр хэлбэл бид уран бүтээлчдийнхээ оюуны өмчийг хулгайд алдахгүй байх, гаднын хөрөнгө оруулалтад алдчихгүй байх тэр эрсдэлийн тооцооллоо ер нь хэр хийж.

Г.Занданшатар: 80 Анар.

Б.Анар: Эдийн засгийн хөгжлийн яам Анар. Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хуультай хэр нийцэж байгаа вэ гэсэн эхний асуулт. Хөрөнгө оруулалтын хууль өөрөө эхлээд яг энэ хөрөнгө оруулалтын орчинтойгоо холбоотой малгай хууль нь байгаа. Яг хөрөнгө оруулалтын суурь орчин ямар байх вэ, хөрөнгө оруулагч гэж хэнийг хэлэх вэ, ямар хөрөнгө оруулалтууд орж ирэх вэ гэдэг ийм суурь асуудлуудыг зохицуулж байгаа. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль өөрөө төрийн хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх зохицуулалтыг нэлээн дэлгэрэнгүй процессын шинж чанартай үйл ажиллагааг ийм зохицуулсан байгаа. Товчхоноор хариулбал, Хөрөнгө оруулалтын хууль нь өөрөө батлагдсанаар төр хувийн хэвшлийн түншлэлийн хууль өөрөө 100 хувь хэрэгжих бүрэн боломжийг нээж өгөх ийм боломжийг бүрдүүлэхээр байгаа. 100 хувь бол энэ 2 хууль хоорондоо, шинээр өргөн мэдүүлж байгаа төсөл 2 хоорондоо нийцэж байгаа гэж хэлье. Компани байгуулахтай холбоотой, аж ахуйн нэгж байгуулахтай холбоотой зохицуулалт яг хуучны хууль дээрх байсан одоогийн хууль дээр байгаа зохицуулалт хэвээрээ байгаа.

25 хувиас дээш хувийг эзэмшиж байгаа бол тухайн аж ахуйн нэгж нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гэсэн харьяалал руугаа ороод явна. Ганицхан үүнтэй холбоотойгоор аж ахуйн нэгж байгуулахад тавьдаг байсан босго үнийн дүнтэй холбоотой зохицуулалт дээр л өөрчлөлт орсон байгаа.

Гурав дахь нь, энэ хориглолт, хязгаарлалттай холбоотой асуудлуудыг асууж байна. Хөрөнгө оруулалтын тухай хууль дээрээ өөрөө зарим зохицуулалт нь одоогийн хууль дээрээ зарим салбаруудыг хориглосон байдаг. Үүнээсээ нэмээд маш олон салбарын хуулиудаар гадаадын хөрөнгө оруулалтыг шинээр орж ирэхийг шууд хорьчихсон байдаг. Энэ хориглосон хаалттай байх энэ зохицуулалтуудыг аль болох нээлттэй болгох чиглэлийг шинэ хуулийн төсөл дээр барьж ажигласан. Энэ хүрээндээ гаднын болон дотоодын хөрөнгө оруулагч нарт хооронд нь ялгаатай байдлаар ханддаг ийм зохицуулалтуудыг илүү багасгасан байдлаар хуулийн төсөл дээр орж ирсэн байгаа.

Салбарыг зааж өгсөн. Одоогийн хууль дээр 3 салбарт, стратегийн 3 салбар гээд уул уурхай, харилцаа холбоо, банк санхүүгийн салбарыг гадаадын төрийн өмчит аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулахыг хориглосон байсан. Одоогийн байгаа бусад хуулиуд жишээлбэл Банкны тухай хууль бол Банкны тухай хууль дээрээ өөрөө ямар зөвшөөрлүүдийг авах вэ гэдгийг заасан байдаг. Харилцаа холбооны асуудлыг Өргөн нэвтрүүлгийн тухай хууль дээрээ зохицуулсан байдаг. Уул уурхайн салбарын тухай хууль бол Ашигт малтмалын тухай хууль болон бусад салбарын хуулиудаараа хөрөнгө оруулалтын асуудлуудаа зохицуулсан байдаг учраас Хөрөнгө оруулалтын тухай хууль дээрээ өөрөө хориглосон хязгаарласан зохицуулалт нь байх нь учир дутагдалтай байна гээд энэ зохицуулалтыг хуулиас авсан байгаа.

Хөрөнгө оруулалтын оюуны өмчийн эрхийг 5.1.7 буюу холбогдох хуульд заасны дагуу эдийн засгийн эргэлтэд оруулахад хөрөнгө оруулалтын хэлбэрээр байж болно гэдэг зохицуулалтыг оруулж ирсэн. Энэ нь өөрөө Оюуны өмчийн тухай хуультайгаа бүрэн нийцэж байгаа.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулъя.

Б.Жаргалмаа: Аль нэгэн салбарт хориглосон заалт байхгүй учраас банкны салбарт шууд хөрөнгө оруулалт орж ирж болно гэсэн ийм ойлголтыг авч байна. Энэ дээр та тайлбар хэлээрэй.

7.1.1 дээр хөрөнгө оруулалт хийх хэлбэр хэмжээ, хөрөнгө оруулалт хийх газар бүс нутаг зэргийг хараат бусаар сонгох, холбогдох шийдвэрийг бие даан гаргах эрх нь хөрөнгө оруулагчид байна гэсэн энэ заалт байна л даа. Газар нутаг бүс зэргийг хараат бусаар сонгох, холбогдох шийдвэрийг бие даан гаргах эрх, газар эзэмших эрх нь тухайн хөрөнгө оруулагчид байна гэсэн үг үү. Энэ дээр тайлбар авчихъя. Тэгэхдээ Хөрөнгө оруулалтын тухай хуулийг дэмжиж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Энэ банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалт орж ирж болох уу гээд болно. Оруулж ирмээр ч байна. Цөөхөн хэдэн банкттай. Тэр банкнууд нь эх үүсвэр багатай. Ингээд иргэд зээл авахад ч төвөгтэй, аж ахуйн нэгж зээл авахад ч төвөгтэй. Зээл олдсон ч асар өндөр хүүтэй. Би энэ банкны салбарт өрсөлдөөн их орж ирээсэй гэж үзэж байгаа. Нэг, хоёр банкны эрх ашгийг биш харин зээл авч байгаа аж ахуйн нэгж, зээл авч байгаа иргэдийн эрх ашгийг бид нар нэгдүгээрт нь тавих ёстой. Энэ улс ардчилсан улс л юм бол бид нар иргэдийн эрх ашгийг нэг номерт нь тавьж явах ёстой. Цөөн нэг, хоёр банкны эрх

ашигийг бид нар дээд талд нь тавьдаг ийм тогтолцооноос бид нар зайлсхийх ёстой.

Ийм учраас энэ банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалт орж ирж гаднын банкныг оруулмаар байна гэдгийг би энэ Их Хуралд байнгын хэлж байгаа. Харин ашгүй одоо тэр Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль гарч энд боломж нь нээгдсэн байгаа гэдгийг хэлье.

Дараагийнх нь газрын асуудал. 1993 онд батлагдсан хууль дээр газрыг зөвхөн ашиглахаар оруулж ирсэн. 2013 оны хууль дээр эзэмшүүлэх болон ашиглах гээд заагаад өгчихсөн. Энэ нь өөрөө Үндсэн хууль зөрчөөд байгаа учраас бид нар энэ хуулийнхаа өөрчлөлтөөр эзэмшүүлэхийг нь хасахаар оруулаад ирсэн байгаа юм. Үүнийг олон хүмүүс мушгиж л байгаа. Би харин эсрэгээр нь гайхаад байгаа юм. Энд тэнд эзэмших эрх авчихсан хүмүүс харин энэ хуулийн өөрчлөлтийг хийлгэхгүй гэж тийм юм хийгээд байхыг би үгүйсгэхгүй л юм байна гэж ойлгож байгаа. Хараад байхад дандаа бизнестэй ийм л хүмүүс эсэргүүцэж харагдаад байгаа шүү дээ.

Г.Занданшатар: Жаргалмаа гишүүн тодруулъя.

Б.Жаргалмаа: Банкны салбарын хөрөнгө оруулалтыг дэмжиж байгаа. Үнэхээр банкны салбарт зах зээлийн зарчмаараа явснаараа эргээд бас хөнгөлөлттэй зээл авах, хүү багатай байх тэр боломжуудыг нээх тэр боломж нээгдэнэ. Саяын 7.1.1 дээр би гайхаад байна л даа. Яг энэ үг, үсгээрээ явах юм бол 7.1.1 хөрөнгө оруулалт хийх газар бүс нутаг зэргийг хараат бусаар сонгох, холбогдох шийдвэрийг бие даан гаргах гэгчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр тухайн хөрөнгө оруулагч өөрөө тухайн газар нутгаа сонгох нөгөө засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж нөгөөдөх аймаг орон нутгийн Засаг дарга эрх хаачихав аа.

Энэ дээр хэн нэгэн хөрөнгөтэй мөнгөтэй хүний заалт биш бид газар нутгаа хамгаалах тэр эрх зүйн орчин чинь алга болчих юм биш үү гэдэг дээр л би асуулт асуугаад байгаа юм. Хүрэлбаатар сайд аа.

Г.Занданшатар: Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Яг л эсрэгээр нь яриад байгаа юм. Тэр манайх чинь бас хуультай шүү дээ. Тэр газар олгодог хууль байна. Газрын тухай хуулиудыг Засгийн газар багцаар нь оруулж ирнэ гээд Даваасүрэн сайд хариуцаад явж байгаа. Орж ирэх юм уу, үгүй юм уу бүү мэд. Тэр хуулийнхаа дагуу бүх юм асуудал шийдэгдэнэ. Харин хүн орж ирээд би ийм бизнес хийе гэхээр, үгүй ээ чи заавал юу гэдэг юм Увс аймгийн тэр Давст сумын хойно байгаа газар дээр очиж бизнес хийхийг гэж зааж өгөхгүй л байхгүй юу. Бизнес хийе гэж байгаа хүн орж ирээд би өөрөө энд бизнесээ хийе гэдэг сонголт хийх эрх нь нээлттэй л гэсэн үг. Холбогдох зөвшөөрлүүдийг тэр холбогдох хуульдаа заасныхаа дагуу авна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, хүн бизнес хийе гэхэд нь үгүй ээ чи энд хийе гэхээр үгүй ээ, чи хэрэггүй ээ, заавал тэнд хий гээд зааж өгөөд байх шаардлагагүй л гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын эдийн засаг хэзээ хөгжих вэ гэхээр энэ бизнест хийгддэг эрх чөлөө сонголт нь нээлттэй байж, байж л энэ улс орны эдийн засаг хөгжинө. Энэ бид нар энэ олон жил арилгаж чадахгүй байгаа энэ ядуурал, энэ бүгд чинь ажлын байранд бий болж байж тэр хүмүүс ажилтай болж байж энэ ядуурлаас гарах юм.

Тийм учраас бид нар энэ бизнес эдийн засгаа хөгжүүлэхийн тулд битгий хааж хориод байгаач ээ. Өөрсдөө тэр бизнест нь иргэд нь өөрсдөө сонголтоо хийх боломжийг нь л олгоод өгөөч гэж байгаа юм. Өөр юу ч байхгүй. Нэг дарга гарч ирчхээд бүгдийг нь мэддэг юм шиг бурхан багш шиг аашилаад байх шаардлага

байхгүй шүү дээ. Тэнд бизнес хий, үүнийг боль, ингэ тэг, энэ хэн бэ, хэдийн тоо вэ л гэж би хэлнэ. Тийм учраас энэ нь ийм нээлттэй байна. Иргэд бизнес хийх боломжоо хийх, сонголт хийх тэр эрх чөлөөг нь олгоод өг гэдэг ийм үндсэн зарчмыг яриад байгаа юм.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Манай Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуулиуд хөтөлбөрүүдэд энэ зорилтуудаа маш сайн тодорхойлсон байдаг. Харамсалтай нь зорилтууд маань хэрэгжилт муутай байгаа юм. Энэ хөрөнгө оруулалтын хуулийг дэмжиж байна. Тэгэхдээ дотор нь засах юмнууд байна. Сая тэр Жаргалмаагийн хэлээд байгаа зүйтэй шүү. Эзэмшүүлэхийг хорьчихно гэсэн юм энэ дотор харагдахгүй байгаа, үүнийгээ үзнэ биз дээ гэж нэгдүгээрт.

Хоёрдугаарт, бид нэг их бусдын муу муухайг гайхаад байх хэрэггүй ээ. Тэр улсууд өөрсдийнхөө жамаар хөгжиж байгаа. Манай энэ ханшийн уналт энэ 30 жилийн хугацаанд энэ инфляц, өвчлөл, утаа, түгжрэл, гадаад өр тэгээд тоочих юм бол бид магадгүй зарим талаараа тэд нараас доор орчихсон ч байж магадгүй. Өөрсдийнхөө гэрийг гэрэлтүүлчээд хүний гэрийг гэрэлтүүл гэж үг байдаг. Тийм учраас эндээс бодолтой ярихгүй бол болохгүй гэдгийг би хэлж байгаа юм.

Монгол Улс бол хаалттай биш нээлттэй улс. Хэн ч орж ирээд, юу ч хийж болно. Бид 1992 онд энд ардчилал гээд нэг сайхан бөмбөлөг хөөргөчихсөн, түүнийгээ тойроод л гүйж байх хооронд нэг нөхөр орж ирээд Монголын 60 илэрцтэй зэсийн лиценз аваад явчихсан байна. Түүний нэг нь Оюутолгой, тэр нөхөр Магта сорреер гэж компани. ВН-д худалдсан. ВНР нь Фрийландад 42 сая доллар. Фрийланд нь буцаж ирээд худалдсан. Ингээд наймааны хөгиин морь шиг явсаар байгаад энэ

Оюутолгойн гэрээ маань төсөл маань нэг иймэрхүү үргэлжилж явж байгаа юм. Энэ жил Монгол Улсын төсөвт 760 тэрбум төгрөг нийлүүлнэ. Монгол Улсын нийт төсөв 27 их наяд төгрөг. Үүнтэй нь харьцуулах юм бол 2.7 хувийг нь бүрдүүлэх юм байна. Энэ том төсөл энэ их баялагтай харьцуулах юм бол харамсалтай.

Тэр 2023 онд болсон тэр эдийн засгийн форумын үеэр тэр Доминик Бартон гээд тэр Рио тинтогийн ТУЗ-ийн дарга Оюутолгойн төслийн үр ашиг монголчуудад ийм хүссэн хүлээлт хүрээгүй гэдгээ хүлээн зөвшөөрч, энэ зааланд зогсож байсныг би харж байсан. Тэгээд ер нь бол нэг буруу хийсэн гэрээ цаашид жишиг болоод явчихдаг. Тэр гэрээ л жишиг болоод явчихдаг. Ийм учраас 21 дүгээр зуунд амьдарч байна, бид нар. Цаашидаа гаднын хөрөнгө оруулалтыг хийхдээ Монгол Улсын эрх ашиг, Монголын ард түмний эрх ашгийг нэгдүгээрт тавьж үр ашигтай хийх нь зүйтэй. Ийм жишиг бол Казакстанаас эхлээд байна, бидэнд алга байна. Яагаад ингээд энэ гадаадын хөрөнгө оруулалт дайжчихав. 5500 аж ахуйн нэгж яагаад Монголоос татан буугдчихав аа. Яагаад энэ нийт аж ахуйн нэгжийн 3.7-хон хувь нь гаднын хөрөнгө оруулалттай байна. Яагаад тэр төсөвт орж байгаа мөнгө нь 10-аад хувиар буурчхав гэхээр зэрэг энэ хуульдаа байв уу эсвэл өөр ямар шалтгаанууд байна. Энд нэг хариулт өгөөч гэсэн ийм асуулт байна.

Хоёр дахь асуулт. Энэ банкны шинэчлэлийг бид нар хийсэн Монголбанктай хамтраад би тэр банкны санаачлагч нь би байгаа юм. 2023 оны 12 сарын 31-нд дууссан тэр 20 хувийнх нь хэмжээ. 2026 он болгож өөрчилье гээд оруулсан Засгийн газар бүлгээр хэлэлц гээд ингээд буцаачихсан. Хоёр дахь заалт нь бол тэр 1 хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийг заавал 1 биш 2 ч байж болно гэж ингэж оруулсан юм. Үүнийг би биш гадна дотнын байгууллагууд өөрснөө

шаардаад байгаа шүү дээ. Энэ эдийн засгийн форумын үеэр л тэр 10 дугаар салбар хуралдааны банк санхүүгийн секторын хуралдаан дээр энэ 2 асуудлыг хоёулаа дахин хугацааг нь тодорхойлъя.

Банкны тухай хуульд өөрчлөлт оруулъя гээд бид өөрснөө тэр хөрөнгө оруулагч нарын өмнө амлалт авчихсан шүү дээ. Тэгээд одоо байхгүй. Хууль зөрчигдөөд ингээд яваад байдаг. Тэгээд бүлгийн хурал гэж, бүлгээрээ оруул гэж байна. Би Улсын Их Хурлын гишүүний хувьд хууль санаачлах эрхтэй. Миний санаачилсан хуулийг хэн ч өнөөдөр ингээд саад хийх ёсгүй шүү дээ. Хүрэлбаатар сайд энэ дээр хариулт өгөөч. Энэ одоо ямар юм болоод байна, энэ юу болоод байгаа юм бэ. Энэ хууль нь зөрчигдөөд яваад байдаг. Гаднынх нь хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулъя гээд байдаг. Ингээд байдаггүй. Ингээд энэ хуулийнх нь зохицуулалтуудыг нь хийж өгдөггүй ингээд байгаад байдаг. Үүнийг ингээд янзалъя гэж. Үүнийг яагаад анхаарсан гэхээр тэр тухайн үеийн нөхцөл байдал нь тийм байсан юм. Ингэхээс өөр аргагүй байсан. Үүнийг энэ хуулиар ингэж биш, өөр аргаар зохицуулах боломжууд нь бас байгаа юм аа. Тэгээд энэ 2 асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Энэ хууль оруулж ирэхийн өмнө бид нар нэлээд бас олон удаагийн хэлэлцүүлгүүдийг хийгээд л явуулсан. Тэгээд яг энэ хөрөнгө оруулахад юу саад болоод байна. Яагаад энэ гадаадын хөрөнгө оруулагч нь орж ирсэн, гараад яваад байна вэ. Яагаад тэр гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн тоо цөөрөөд байна. Яагаад нийт аж ахуйн нэгжүүд дотор эзлэх хувь хэмжээ нь буураад байна вэ гэдгийг ингээд нэлээн сайн судалж үзсэн. Ингэхээр ерөөсөө л бүртгэл зөвшөөрөл авах, шүүхэд хандах, шүүх дээр очиж шүүхээр асуудлаа шийдвэрлүүлэх гээд энэ

бүгд дээр нь асуудал гардаг. Хөрөнгө оруулагчдын гомдлыг Засгийн газар дээр ярьдаг болж эхэлсэн юм. Эхлээд 8 гомдол ирсэн, одоо 69 аж ахуйн нэгж гомдол тавьчихсан байгаа юм.

Ингээд үзэхээр ерөөсөө л тэнд манай зарим хуулийн байгууллагын хүмүүс нь нийлж байгаад хүний бизнесийг булааж авдаг, хуулиар шаардах ёсгүй зүйлүүдийг шаарддаг, нэхдэг зарим лицензийг нь хүчингүй болгуулдаг тэгээд өөрсдөө тэрийг нь авдаг. Хар тамхи аваачиж гэрт нь энд тэнд нь нуучаад, түүнийг нь илрүүлээд хөөж гаргадаг. Хөрөнгийг нь дээрэмддэг ийм зүйлүүд ингээд гараад байгаа учраас энэ улсад хөрөнгө оруулалт орж ирэхгүй байгаа юм.

Ийм учраас энэ бүгдийг засъя гэж энэ хуулийг оруулж ирж байгаа юм. Гомдол гарвал түүнийг нь шийдчихдэг ийм л байя. Гомдол гаргавал энэ ил тод нээлттэй явдаг. Эхлээд маргаан таслах зөвлөл шиг асуудлаар хэлэлцдэг байя. Дараа нь ч тэр шүүхээр хэлэлцүүлбэл шүүхээр хэлэлцүүлэх нь нээлттэй, арбитраар явъя гэвэл арбитраар явах нь нээлттэй. Ингээд боломжийг нь л олгож өгөөд байгаа юм. Түүнээс биш зөвхөн энэ, шүүхээр шийд, энэ хүн л шийднэ гэдэг ийм, ийм зүйлээр явахгүйгээр аль болохоор боломжийг нь нээж өгсөн ийм зүйлүүд гэдгийг би хэлмээр байна.

Банктай холбоотой асуудлыг би хувьцааг нь олон нийтэд гаргах тухай асуудал гэж ойлгож байгаа шүү дээ. Уг нь энэ арилжааны банкнуудыг бид нар хувьцаагаа олон нийтэд гаргахаар шахаад л хууль байсан юм чинь түүнийгээ хэрэгжүүлэхийг шаардах ёстой байсан болов уу гэж бодож байгаа юм. Тэгээд хэрвээ банкнууд хууль зөрччихсөн байгаа бол тэдэнд нийцүүлж хууль өөрчилнө гэсэн асуудал байхгүй шүү дээ. Банкнууд хуульдаа нийцээд ажиллах ёстой гэсэн байр суурьтай байна.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Өнгөрсөн хугацаанд 3 банк Монголын мөнгөний эргэлтийн 70-80 хувийг нь барьдаг ийм болчихсон байсан юм. Үүнийг бид нар бүгд харж байгаа шүү дээ. Тэгээд үүнийг 5 банк нээлттэй хувьцаагаа гаргаад 470 тэрбум төгрөгийн нэмэлт хөрөнгийг татаад 70 мянган хувьцаа эзэмшигчтэй болсон өнөөдрийн байдлаар. Тэгээд энд бол нээлттэй компаниуд болсон. Одоо гаднынхан чинь та нарын тэр нэг хөрөнгө оруулагч нэг банканд гэдэг чинь болохгүй байна гэдгийг Хүрэлбаатар сайд өөрөө мэдэж байгаа шүү дээ. Хөрөнгө оруулалтын чуулганыг өөрөө удирдсан хүн. Бид юу гэж амлачихлаа. Тэгээд одоо ингээд үүнийг нь шийдье гэхээр ингээд байгаад байдаг.

Түүнийг бид анх санаачлахдаа бол 2026 он хүртэл санаачилсан юм. Ажлын хэсэг 2023 онд багтаагаад 20 хувь гээд орчихсон учраас болохгүй юм байна билээ. Яагаад гэхээр тийм их мөнгө алга өнөөдөр. Тэгээд үүнийг шийдэхгүй болохгүй юм. Эсвэл татгалзаж байна гэсэн хариугаа өгчихвөл бид нар үүгээрээ хэлэлцье.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Засгийн газар дээр нэг яригдаад тэгээд буцаагдсан юм. Үүнийг дахиж нэг ярьж байгаад оруулж ирвэл яасан юм бэ. Их Хуралтайгаар бүлэг дээрээ ярилцаж байгаад оруулж ирвэл яасан юм бэ гэдэг ийм л шийдвэр Засаг дээрээс гарсан гэдгээ хэлье. Тэгээд бүлэг дээрээ ярьж байгаад орвол энэ нэг дэх өдрийн бүлгийн хурал дээр ярьчих нь зөв болов уу гэж бодож байна Баттөмөр гишүүн ээ.

Г.Занданшатар: Хүрэлбаатар сайд аа, энэ гишүүдийн санаачилсан хуулийг бүлгээр ярьж байж оруулж ирдэг

тийм дэг байхгүй л дээ. Засгийн газар өөрөө санаачилж байгаа хуулиа бүлгээр хэлэлцүүлээд явуулж байсан дэг бий. Тэгэхээр энэ гишүүдийн хууль санаачлах бүрэн эрхэд халдаж байгаа хэрэг болно нэгд.

Хоёрдугаарт, энэ хуулийг чинь Монголбанк Баттөмөр гишүүд өөрсдөө санаачлаад анх өргөн барихдаа 27 гэснийг зарим гишүүд улс төржүүлээд сонгуулийн өмнө байх ёстой гээд. Тэр нь мөнгөний тооцоо, ОУВС, олон улсын байгууллагууд ч гэсэн мөнгөний зах зээлийн хэмжээ бодит боломж нь энд байхгүй гээд оруулчихсан юм. Тэгээд ийм тогтворгүй байдал үүсгээд. Нөгөө талдаа хөрөнгө оруулалттай зөрчилдөж байгаа юм нь Дэлхийн банкны IFC энэ тэр хэд хэдэн банканд ингээд 5, 5 ч гэнэ үү, 10, 10 хувь эзэмшдэг тэд нарын тавиад байгаа шаардлагын дагуу оруулж ирсэн хуулиуд юм байна. Тэгэнгүүт ингээд бүлгээр хэлэлцэж байж санал өгнө гэдэг бол гишүүдийн хууль санаачлахад эрхэд халдаж байгаа хэрэг болно шүү.

Тийм учраас дэмжиж байгаа, дэмжихгүй гэдгээ Засгийн газар санал өгөх ёстой. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн бол. Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Баярлалаа. Хөрөнгө оруулалтын тухай хуулийг хэлэлцэж байна шинэчлэн найруулгыг. Ер нь ямар ч хүн хөрөнгө оруулалтыг, хөрөнгө оруулагчийг мэдээж дэмжинэ. Гэхдээ энэ оруулж ирж байгаа энэ хууль үнэхээр учир дутагдалтай байна. Эдийн засгийн хөгжлийн яамныхан, Хүрэлбаатар сайдаа. Аливаа хөрөнгө оруулалтыг хийхдээ улс орнууд босгыг зааж өгсөн байдаг. Манай хууль дээр ч байсан. 2013 оны Хөрөнгө оруулалтын хуулийг шинэчлэн яригдаж байхад 100 мянган доллароос дээш хөрөнгө оруулбал хөрөнгө оруулагч гэж нэрлэнэ хэлнэ. Тэгээд 2013 онд 50 мянга болгох гээд бөөн маргаан болж эргээд 100 мянгаар нь

үлдсэн юм. Гэтэл энэ шинэчилсэн найруулга дээр л тэр 100 мянган босго байхгүй байна. Энэ өөрөө аюул дагуулна.

Хөрөнгө оруулагчийн дүрээр хөрөнгө оруулагчийн нэрээр цагаач иргэд нөмрөх вий гэсэн болгоомжлол төрүүлж байна. Ний нуугүй хэлэхэд, Монгол Улсад нэг компани байгуулаад 1 сая төгрөг хүрэхгүй дүрмийн сантай компани байгуулчихна шүү дээ. Хөрөнгө оруулагч болно. Барилга байшин худалдаж аваад хөрөнгө оруулагч болох нь энэ хуулиараа. Мөн машин механизм оруулж ирээд хөрөнгө оруулагч болох юм байна. Тэр барилга байшин, машин энэ тэр нь тэр хүний хэрэглээний юм шүү дээ. Үүнийг хөрөнгө оруулагч гэж хэлж болохгүй. Босго байх ёстой. Энэ хууль дээр чинь босго байхгүй байна. Босгыг нь авч хаяснаараа л аюул дагуулж байна. Энэ байдлаар бол 40, 50 жилийн дараа биш 10 жилийн дараа магадгүй Монгол үндэстэн энэ газар нутаг дээрээ цөөнх болоод явж байхад үгүйсгэх арга байхгүй гэж ийм болгоомж төрүүлж байна.

Хоёрдугаарт, бас ингэж тогтворжуулалтын гэрчилгээг олгоно. Үүнийг олгодог жишиг байдаг. Гэхдээ хэтэрхий бага байна. 10 тэрбумын хөрөнгө оруулахад, 10 жилийн татварын тогтворжуулалт хэрэглэнэ түүнээс дээшээ бол ингээд 20 хүртэл тогтворжуулалтыг хэрэглэнэ гэж байна. Тэгэхээр 10 тэрбум гэдэг чинь бага л даа. 10 тэрбумын ажил үйлчилгээ бизнес гэдэг бага. Тэгэхээр гаднынхан гээд монгол хүнээс илүү татварын тогтворжуулалт хөнгөлөлт эдлээд байх нь бол үнэхээр зохисгүй. 100 тэрбумаас дээш хөрөнгө оруулж байвал тогтворжуулалтын гэрчилгээг бичиж болох юм. Татвар гэдэг өөрөө нийгмийн хөгжил, цаг үетэйгээ тохируулга болгон хэрэглэгддэг зүйл. Түүнээс 10, 20 жилээр нь хатуу байлгаж болохгүй. Аравхан тэрбум оруулсны төлөө. Ер нь тэгээд улс орныг одоо үед зэр зэвсгийн хүчээр эзлэхээ больсон шүү дээ. Хуулиар нь дамжуулж улс орныг

хохирооно, улс орны баялгийг булаана. Улс орныг хараат болгох. Би бол энэ хөрөнгө оруулалтын хуулиас тийм болгоомжлолыг харж байна. Тийм учраас ийм байдалтай орж ирж байгаа Хөрөнгө оруулалтын хуулийг дэмжихгүй гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Тэр босго, дэлхийн бүх орон өндөр босготой, тэгээд гоё яваад байгаа шүү дээ гэж ярьж байна л даа. Хэдүүлээ цээжний пангаар бас яримгүй байна. Дургүй зүйлээ болохоор ингээд үлгэр зохиогоод ярьчихдаг, бодит байдлаа хэдүүлээ харж ярмаар байна шүү дээ Болорчулуун сайд аа. НҮБ-ын Худалдаа хөгжлийн Бага хурлын Хөрөнгө оруулалтын орчны мэдээллийн санд байгаа 136 орноос 24 улс л хөрөнгө оруулалтын босготой. Би тэр улсуудыг нь заагаад нэрлээд өгчихье. Конго, Этиоп, Уганда, Ботсвани, Венесуэл, Мали, Монгол ийм л байгаа шүү дээ. Энэ улс орныг хөгжүүлмээр байна Болорчулуун сайд аа. Таны хариуцсан салбар өнгөрсөн жил 8 хувиар буурчихсан байж байгаа. Энэ асуудлуудыг та өөрсдөө санаачилж ярьж байх ёстой. Гаднын иргэд тэр цагаач иргэд орж ирдэг зүйл Хөрөнгө оруулалтын хуулиар шийдэгдэхгүй. Тэр гадаадын иргэдийн эрх зүйн орчныг тодорхойлдог тэр хуулиудаараа шийд яв.

Түүгээрээ та бүгдийг нь хорьчих, болно. Энэ Хөрөнгө оруулалтын тухай хууль. Та заавал ингэж Хөрөнгө оруулалтын хуулийг эсэргүүцэж байх ямар шаардлага байгаа юм. Зөндөө л тайлбарласан шүү дээ. Та бид 1 засагт хамт сууж байгаа гэж ойлгож байгаа.

Дараагийнх нь, тогтворжуулалтын гэрчилгээ. Тогтворжуулалтын гэрчилгээ одоо хуульд байж байгаа шүү дээ. Одоо хуульд байгаа. Түүн дээр бид нар цахимаар илүү олгодог болгочихъё гэж байгаа. Одоо байгаа аж

ахуйн нэгжүүд нь тогтворжуулалтын гэрээгээ аваад явж байгаа ийм л зүйл. Тэгэхээр түрүүн Жаргалмаа гишүүн бас хэлж байна билээ 7.1.1 гээд. Одоо хуульд нь байгаа бид нар өөрчлөхөөр хөндөөгүй зүйлүүдийг оруулж ирээд яриад байна шүү дээ. Яг орж байгаа өөрчлөлтөө яривал л болоо.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Монгол Улс бол бас онцлог л доо. 2 том улсын дунд хавчуулагдсан оршин байдаг ийм улс. Жижиг хүн амтай. Тэгэхээр бас дархлаа тэр хэмжээгээр бага гэсэн үг. Тэгэхээр Монгол гэсэн дархлаа энэ тусгаар тогтнолоо авч байхын тулд бас хэтэрхий бүсээ тайлаад бүх юмыг дэлгээд хаяж бас болохгүй байх аа. Хамгийн гол нь энэ босгогүй байна гэдэг чинь аюул дагуулж байна. Түүнээсээ хэн ч гэсэн хөрөнгө оруулалтыг дэмжинэ. Бүр 10 жилийн өмнө бид нар 100 мянган долларын босгыг 50 болгоход бөөн хэрүүл болгож эргэж 100 мянгаар нь болгож байсан. Гэтэл энэ хууль дээр 100 битгий хэл 50 ч байхгүй ийм орж ирж байгаа юм. Түрүүнд өөрөө ярьж хэллээ. Гадаадын иргэдийн тэр бол нэг.

Г.Занданшатар: Чимидийн Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Энэ босгын талаар би дахиад ярья. Ингээд компани нээх гэхээр 100 мянган доллар байршуул гээд шаардчихдаг. Тэгээд тэр мөнгийг нь шилжүүлэх гэхээр банкнууд данс нээж өгдөггүй байхгүй юу. Хамгийн гол нь. Тэгээд өмнө нь эвийг нь олж байгаад нэг түр данс нээж байсан юм байна. Гэтэл түүнийг нь мөнгө угаах болон энэ авлигатай тэмцдэг тэр арга хэмжээнүүдийн хүрээнд авлига, терроризм, мөнгө угаахтай тэмцэж байгаа тэр хууль эрх зүйн орчнуудаар түр дансыг нь бүрмөсөн хаалгаад хаячихсан. Би түүнийг зөв гэж үзэж байгаа. Түр данс нээгээд, хаагаад хаячихдаг. Тэгээд бохир

мөнгөө угаадаг ийм л зүйлийг нь аваад хаячихсан. Тэгэхээр компани байгуулаагүй байж яаж тэр хүмүүс мөнгө шилжүүлэх юм.

Ингээд үндсэндээ бид нар ингээд Монгол Улсад орж ирэх бүх хөрөнгө оруулалтыг хаачихсан байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр босгыг л бид нар аваад хаячихъя. Тэгээд мөнгөө оруулж ир үлдсэн нь тэр хууль ном журмынхаа дагуу хийгээд явна гэдгийг би энд удаа дараа хэлээд байгаа юм. Үүнийг хийхдээ юу гэдэг юм, нэг өөрсдөө бодож байгаад сууж байгаад, дээшээ харж хэвтэж байгаад оруулаад ирж байгаа юм биш шүү дээ. Үндсэндээ бид нар энэ хуулийг оруулж ирэхийн тулд удаа дараагийн, олон удаагийн хэлэлцүүлгээ хийсэн. Тэгэхээр хөрөнгө оруулах сонирхолтой аж ахуйн нэгжүүд яг энэ заалтаас болоод бидэнд хүндрэл учраад байна. Мөнгө шилжүүлэх ямар ч боломжгүй болчихоод байна.

Эсвэл хэн нэгэн хүнийг мөнгө гуйж байгаад данс руу нь шилжүүлчихвэл тэрэн дээрээс бид нар хулхидуулах ийм эрсдэлтэй. Мөнгөө авч чадахгүй байх эрсдэлтэй гэдэг ийм зүйлийг яриад байгаа юм аа.

Тийм учраас бид нар үүнийг аваад хаячхаж байгаа юм. Үндсэндээ ингээд босго тогтоосноос хойш л энэ түрүүн Баттөмөр гишүүн асууж байгаа тэр 5500 аж ахуйн нэгжүүд чинь гараад л явж байгаа шүү дээ. Бид нар хөрөнгө оруулалтыг өрсөлдөж байж татаж авч ирэх ёстой. Тийм учраас л энэ зүйлийг яриад байгаа юм шүү гэдгийг дахин, дахин би хэлээд байгаа юм.

Г.Занданшатар: Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Энэ улс орны онцлог, газар зүйн байршил, хүн амын тоо гээд энэ нөхцөл байдалтайгаа уялдуулаад гаднын хөрөнгө оруулалт дээр болгоомжтой хандаж байгаа байдлыг би

бас буруу гэж үзэхгүй байгаа юм. Тухайлбал БНСУ-ын хувьд гадаадын хөрөнгө оруулагч, хуулийн этгээдэд тавих санхүүгийн босго 100 сая доллар юм билээ. Хэрвээ 2 тусдаа хөрөнгө оруулагч байх юм бол дундаа 100 сая биш тус бүр 100 сая доллар. Тэгээд 10 жилийн өмнө Болорчулуун гишүүн бид нар энэ гаднын хөрөнгө оруулалтын энэ хууль дээр бас өөрөө ч гэсэн байсан даа. 100 мянгыг болууль гэхэд бүгдээрээ эсэргүүцээд үүнийг үлдээж байсан. Дараа нь Ганхуяг, Булгантуяа нар энэ 100000-ыг 50 мянга болгоё гээд ороод ирэхэд нь бараг Их Хурлын гишүүд тэр чигээрээ эсэргүүцээд хуулиа татаж авахад эргэж хүрсэн шүү дээ.

Тэгтэл одоо 50 мянга биш бүүр 100 мянга байхгүй болгох тухай хуулийн төсөл ороод ирэхээр зэрэг бид нар бас юм ярих нь аргагүй л дээ. Тэгээд хамгийн гол нь энэ 100 мянган доллар гэдэг босгоо байхгүй болгочихоор, аль салбарт илүү хөрөнгө оруулалт орж ирэх гээд байгаа юм. Бид нар ер нь бодлогоороо аль салбараа нээлттэй, аль салбараа хязгаарлалттай байлгая гэсэн ийм тооцоо судалгаа байгаа юм. Энд нэг хариулт өгөөч.

Хоёрдугаарт, энэ хуулийн төсөл дээр бас анхаарал татсан зүйлүүд байгаад байгаа юм. Өмнөх хуулийн төсөл дээр газрыг 100 жилээр эзэмшүүлэх байсныг одоо ашиглуулах болгож орж ирж байгаа юм байна. Эхлээд 15-60 жил хүртэл хугацаагаар, дараа нь 40 жил хүртэл хугацаагаар сунгах. Тэгээд энэ 100 жилийн хугацаанд нөхцөл байдал их өөр болно шүү дээ. Тэгэхээр бид нар энэ дээр бас бодолцох ёстой. Тэгээд яагаад та нар маань энэ тоог ингээд хийгээд ороод ирэв ээ.

Гуравдугаарт, миний нэг анхаарал татаж байгаа зүйл бол энэ хуулийн 16.1.3-д Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх гээд ороод

ирчихсэн. Энэ хураамжаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан маань ажилладаг юм. Тэгэхээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан маань эдгээрийг чөлөөлснөөс болоод санхүүжилтгүй болно гэсэн үг үү. Үүнийгээ хэрхэн яаж шийдэхээр харж байгаа юм. Эдгээр 3 асуултад хариулт аваад тэгээд тодруулъя.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Яг энэ хуулийг бид нар оруулж ирэхийн өмнө бизнес эрхлэгчид бүх талын хэлэлцүүлгүүдийг хийсэн. Тэр хэлэлцүүлэг дээр гарч ирж байгаа энэ босготой холбоотой санал их олон байсан. Яах вэ, бид нар бизнес эрхлэгчдийнхээ саналыг сонсохгүй гээд явж болно, болно. Үүнийг хийчихвэл бид нарын хувьд энэ бизнес хийх боломж нэмэгдэнэ, үүнийг хийвэл олон саад бэрхшээл алга болно. Үүнийг хийвэл бид нарын хувьд хулхидуулаад, залилуулаад, луйвардуулаад байх юм байхгүй болж байна.

Эрс багасна гээд хэлж байгаа бизнесүүдийнхээ ярьж байгаа, хэлж байгаа зүйлийг бид нар сонсохгүй явж болно шүү дээ. Харин хариу нь юу гэж гарах бол. Бид нар ардчилсан нийгэмд амьдарч байгаа. Энэ улс орныхоо хөгжлийг бид нар бий болгоё л гэж бодож байгаа. Аль болохоор хурдан хөгжмөөр байна, энэ аль болохоор энэ монголчуудынхаа амьжиргааны түвшнийг нь дээшлүүлье гэж бодож байгаа.

Бид нар дандаа хааж боосон зүйлүүд хийсээр байгаад энэ улс орныхоо эдийн засгийн байдлыг бид нар хар л даа. Бүхэл бүтэн хариуцсан яам нээлээ. Ингээд ажиллаад яваад эхлэхээр энэ улс орны хөгжлийг түргэтгэх чиглэлээр олон л арга хэмжээнүүдийг авах шаардлагатай. Монгол Улс яах вэ бүх хилээ хааж байгаад өөрсдөө хөгжсөөд явах боломжтой л доо. Гэхдээ хөгжил их удаан ирнэ шүү. Тэр

хооронд эрх баригчдыг хэд, хэд сольчих байх ард түмэн. Хэн тэр бизнес эрхлэгчдийн хэлж байгаа үгийг сонсохгүй, дураараа, би бүгдийг мэддэг гэсэн ийм сэтгэл санаагаар хандах ер нь буруу л болов уу гэж би бодож байна.

Эзэмших, ашиглах гэдэг дээр бол одоогийн хүчин төгөлдөр байгаа хууль дээр эзэмших, ашиглах гэж байгаа юм 100 жилээр. Одоо байгаа дээр нь. Тэгэхээр эзэмших гэдэг үг нь хууль, Үндсэн хууль зөрчиж байна гэж үзээд бид нар эзэмшихийг нь дараад ашиглах бол оруулаад ирчихсэн. Тэгэхээр энэ хуулийг явуулахгүй гэж байгаа бол бид нар тэр Үндсэн хууль зөрчихсөн заалтыг хамгаалж үлдэнэ ээ л гэж үзэж байгаа гэж би бодож байгаа.

Тэгээд өөр ямар асуулт байлаа. Хөдөлмөр эрхлэлтийн, бизнес эрхлэгчидтэй уулзахад яг ний нуугүй хэлэхэд ямар асуудал ярьж байна вэ гэвэл ажиллах хүчин байхгүй, ажилладаг хүн байхгүй. Ийм асуудлыг бидэнд тавьж байгаа. Монголчууд маань ажиллах юу гэдэг юм, эдийн засаг нь ажиллах компаниудын хамгийн тулгамдаад байгаа асуудал татвар энээ тэрээ гэхээс илүү бидэнд ажиллах хүчин алга болчихоод байна. Ийм асуудлыг ярьж байгаа юм. Тэгээд дээр нь бид нар хураамжуудаар дарамт учруулмааргүй байна л гэж үзэж байгаа юм.

Г.Занданшатар: Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Хуулийн төслийн хэлэлцүүлэг явж байгаа учраас дэмжих үү эс дэмжих үү гэдэг шийдлээ гаргахын тулд тодруулж л таарна. Үүнийг хөрөнгө оруулалтыг дэмжихгүй байна гэдэг юм уу, хуулийн төслийг эсэргүүцэж байна гэж бас хатуу битгий ойлгоорой. Хүрлээ сайд аа. Энэ чинь бас тодруулах юмаа тодруулна шүү дээ. Тухайлбал энэ хуулийн төсөл дээр Улаанбаатарт 20-50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийвэл 10

жилийн тогтворжуулах гэрчилгээ өгөх юм байна. Хөдөө орон нутагт 10-50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийх юм бол 10 жилийн тогтворжуулах гэрчилгээ өгөх юм байна. Энэ тогтворжуулах гэрчилгээний агуулга нь юу вэ. Энэ тогтворжуулах гэрчилгээ авснаар тухайн компани ямар давуу тал эдлэх юм бэ. Энэ дээр нэг хариулж өгөөч.

Г.Занданшатар: Шадар сайд Хүрэлбаатар хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Татварынхаа орчнуудыг тогтворжуулъя гэдэг ийм хүсэлт тавиад байгаа юм. Яг ингээд орж ирээд ажиллаж байтал, бид нар шийдвэр гаргаад явж байтал, та нар хуулиа өөрчилчихдөг бүгдийг нь. Тэгэхээр яг тэр орчин дээр бид нар шийдвэр гаргаж байгаа бол түүнийг ядахдаа 10 жилийн хугацаанд та нар тогтворжуулаад өгөөч гэдэг ийм санал санаачилгууд гарч ирээд байгаа юм.

Ер нь тогтворжуулах асуудал бол одоо хүчин төгөлдөр байгаа хууль дээрээ илүү байгаа шүү дээ. Хөрөнгийг хөдөө аймгууд руу нь явуулах ийм чиглэлүүдийн дагуу холбогдох өөрчлөлтүүдийг нь оруулж ирсэн. Тэгээд 4-хөн төрлийн татварыг тогтворжуулахаар хийгдсэн. Одоо Монгол Улсад нийтдээ 17 тогтворжуулах гэрчилгээ олгочихсон юм байна билээ. Харахаар дандаа л Монгол Улсад тэгээд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд энэ тогтворжуулалтын гэрээг авч байгаа юм байна билээ. Монгол гадаад гэлтгүйгээр үндэсний компаниуд ч хүртэл авч байгаа юм байна билээ.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Би яг энэ гадаад худалдаатай холбоотой нэг жаахан юм асуумаар байдаг. Тэгэхээр ОХУ-аас мах авахгүй нэг хэсэг боллоо. Тэгээд энэ хооронд Монголын махны компаниуд

Хятад руу мах экспортолж эхэлсэн. Тэгээд энэ жил урьд хожид байхгүйгээр үнэ унасан байгаа.

Дээрээс нь нэгхэн компани гэхэд 40 том машин мах гаргачаад нэгийг нь ч зарж чадахгүй одоо хүртэл байж байна. Бараг 2 сар гаруй болж байна. Энэ нөхцөл байдал юу руу чиглүүлж байна вэ гэхээр, энэ жил нэлээн цас зуд их болох шинжтэй. Малчид малаа их нядалж байна. Би дөнгөж сая Өмнөговь суман дээр чинь очлоо. Тэгэхэд 500 малтай айлын ихэнх нь 300-г нядалчихсан байна. Ер нь нэлээн хэдэн айл 100 малтай үлдсэн байна, 500 малтай айл. Тэгээд энэ юу гэж байна вэ гэхээр гар аргаар нядалсан мах маш их байна гэсэн үг. Тэгээд урагшаа нөхцөл байдал ийм байгаа асуудал дээр ямар асуудал тулгараад байгаа юм бэ гэхээр яг наадах хажуу талын чинь Болорчулуун сайд дээр байгаад байгаа.

Өөрөөр хэлбэл, дарга нарын компанийг урагшаа аттестатчилж явуулчихаад, жирийн компаниудыг ерөөсөө явуулдаггүй. Энэ компаниуд чинь яаж байна гэхээр 15, 16-хан л зөвшөөрөлтэй компани Хятад руу гарах зөвшөөрөлтэй компаниуд байдаг. Тэд нар яадаг вэ гэхээр 1кг махан дээр 3 юанийн төлбөр төлдөг.

Тэр 3 юань чинь 1500 төгрөг. 1500 төгрөг 20 кг-тэй мах гэхэд 30 мянган төгрөг. Тэр малчдын малыг унагаах замаар тэр мөнгөө тэр компани төлдөг байхгүй юу даа. Тийм учраас энэ ялангуяа гадаад руу, ялангуяа Хятад руу, аттестатчилалд материалаа өгчихсөн зөндөө олон компаниудыг аваачаад дарчихдаг. Одоо нядалгаа дуусчихсан. Одоо тэр аттестатчилдаг компани байхгүй байхгүй юу даа. Гэтэл тэр аттестатчилаад материалаа өгчихсөн компаниудын бичиг баримтынх нь хугацаа дуусах гээд байна. Ийм, ийм асуудлууд байна. Тэгээд тийм учраас наадах энэ тээг болоод байгаа нөхдүүд дээрээ анхаарал тавиач ээ гэж нэгдүгээрт хэлмээр байна.

Хоёрдугаарт, би танай яамныханд бас хэлье. Ер нь энэ Оростой хийж байгаа гадаад худалдааны юм ахиц гарч байгаа. Би танай яамнаас огт мэдээлэл авч чадахгүй байгаа. Би Орос талаасаа авч байгаа шүү. Ер нь та тэр хойно очоод танайх ер нь манай Монголд хориг тавьсан, 30 хэдэн жилийн турш хориг тавьсан гэж миний олон жил олон удаа энэ Их Хурлын индэр дээрээс хэлсэн үгийг та Оросын эрх баригч нарт хэлсэн байна билээ. Тэр бол зөв. Түүний үр дүнд 200 гаруй бараа бүтээгдэхүүн нь Орос руу маш татвар багатайгаар гарах ийм гадаад худалдааны ялангуяа Евроазийн гаалийн түншлэлийн тэр хэлэлцээрт орох ийм юунууд чинь сайн явж байгаа юм байна.

Түүнийгээ илүү сайн хичээвэл, Махны холбоо нэг хэдэн тонн мах гаргасан. Гэтэл очоод л нөгөө нэг бас энэ хоорондын зөвшөөрлийн асуудлаас болоод буцаад ирж байгаа ийм тохиолдлууд байна.

Ийм асуудалтай үед мах гаргана гэдэг бол нөгөө үхрийн мах гаргана. Тэгээд цаашилаад хонины махыг гаргах зөвшөөрлүүдийг бид нар бас ойрын хугацаанд авч чадна. Ийм тохиолдолд бид нар нэг алхам урагишлаад, урагишлаад, ялангуяа хойд хөриш рүүгээ бараа бүтээгдэхүүн 4, 5-хан төрлийн бараа бүтээгдэхүүн экспортолдог юм шүү дээ. Түүнийгээ олон төрөлт болоод 200 төрлийн бараа бүтээгдэхүүн болгоод явах юм бол бид нарт их гадаад худалдаан дээр маш их амжилт гаргах боломж байна. Гэтэл нөгөө Болорчулуун яасан гэхээр, төмөр замаар орж ирэх өөрөөр хэлбэл Наушик, Сүхбаатараар орж ирэх гурилыг нь хаагаад хаячихсан. Тэгэнгүүт манай нэг талын яам нь ингээд зөвшөөрөл хүсээд яваад байдаг, нөгөө яам нь болохоор хориг тавиад байдаг ийм бүтэлгүй ийм гадаад харилцаан дээр асуудалтай ийм зүйл танай энэ Засгийн газарт чинь байна шүү. Энэ дээрээ нэг бодолтой, нэг толгойтой

байгаарай гэж хэлмээр байна. Энэ дээр хариулт авъя.

Г.Занданшатар: Хүрэлбаатар Шадар сайд.

Ч.Хүрэлбаатар: Би яг өөртэйгөө холбоотой, манай яамтай холбоотой зүйлээр таны асуултад хариулт хариулъя. Өөр яамны асуудлыг бид нар яримгүй байна.

Нэгдүгээрт нь, ОХУ руу Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнүүдийг татваргүй оруулах асуудлыг бид нар 2022 оны 11 дүгээр сард ОХУ-д очихдоо хэлж, ярьж эхэлсэн. Оростой хийж байгаа манай гадаад худалдааг аваад үзвэл бид нар Оросын нийт худалдааг ингээд аваад үзвэл 97 хувь нь Оросын экспорт, 3 хувь нь манай экспорт. Энэ нь юу гэсэн үг гэвэл 97 хувь нь манай импорт, Оросын импорт 3 гэсэн үг. 3 хувь гэсэн үг. Ийм тэнцвэргүй худалдаа хийж болохгүй гэдэг асуудлыг ОХУ-ын холбогдох албан тушаалтнуудад нь хэлсэн. Нэлээд өндөр түвшинд нь ч хэлсэн. Ингээд харин энэ чиглэлээр нэлээд ажлууд эрчимтэй явагдаж байгаа гэдгийг би хэлье. Одоо манай яам ОХУ-ын яамтай ид яриа хэлцлүүд явагдаж байна. Энэ 1 сард уулзалтууд хийгдэнэ, дахиад 2 сард дахиад уулзалтууд хийгдэнэ. Тэгээд үүгээрээ бид нар нэлээд бас боломжийг нээчих ийм бодолтой байгаа. Өөрөөр хэлбэл мөн Хятадтай ч гэсэн яг ийм төрлийн гэрээ хэлцлүүдийг бид нар хийх ёстой юм байгаа. Оростойгоо одоо хийж байна. Солонгостоо хийж байна, Японтой хийчихсэн. Ийм зүйл гэрээнүүдээ бид нар хийж байж энэ улс оронд бас хөрөнгө оруулалт нэмэгдэх болов уу гэж хэлж байгаа. Пүрэвдорж гишүүн тантай санал нэг байна гэдгийг хэлье. Болорчулуун сайдын асуудлуудыг би өмнөөс нь яримгүй байна. Бид 2 сая Хөрөнгө оруулалтын хуулиар санал бодол үзэл бодол өөр байдаг ч гэсэн та бид 2 нийлж тэр хүнийг муулаад яах вэ.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Энэ их харамсалтай байгаа юм аа. Энэ гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг одоо ингээд л ярьж байгаа юм. Үүнийг аль эрт дээр үед яриад нэг тийш нь болгочих ёстой байсан юм. Тэгээд 8 жил засгийн эрхийг барьчхаад одоо тэгээд бүрэн эрх нь дуусаж байгаа ийм үед МАН-ын байгуулсан Засгийн газраас ийм юм орж байгаа нь маш их харамсалтай байна. Ганц гайгүй сайд байх шиг байна энэ Хүрэлбаатар сайд. Их ч муулуулж байх шиг байна. Ер нь их муулуулж байгаа, янз бүрээр их хэлэгдэж байгаа хүн бол хамгийн зөв зүйтэй л хүн байдаг юм шүү дээ. Тэгээд өнөөдөр улс орны байгаа байдлыг хар, амьдралыг.

Тэгээд энэ Засгийн газрын ажиллаж байгааг хар, ямар ч удаан юм. Одоо 2 хүний 1 нь ядуу. Үгүй ээ энэ чинь гадаадын хөрөнгө оруулалт ёстой агаар, ус шиг л хэрэгтэй байна шүү дээ. Ямар юмны босго вэ? Нэг хадны мангаагаар танк манкаар айлгадгаа боль л доо. Тэр 12, 13 дугаар зууны үед чинь Чингис хааны Засгийн газар чинь хэн чадвартай, эрдэмтэй, мэдлэгтэй тийм хүмүүсээр бүрдүүлж байсан шүү дээ. Тийм л байсан. Одоо яачхаад байгаа юм. 800 жилийн өмнөхөөсөө ухарчхаад байна шүү дээ бид нар. Тэгээд олон юмыг өөрчлөх хэрэгтэй. Энэ банкнуудад чинь итгэхгүй байна. Тэгээд эрэмдэг зэрэмдэг юмыг нь. Одоо энэ том банкнуудаа системийн 5 банк гээд байдаг билүү. Түүнийгээ олон нийтийн хяналтаар оруулж байна гээд л 5,10-хан хувийг нь хөрөнгийн бирж дээр гаргана. 30, 40 хувийг нь гаргах ёстой шүү дээ. Тэгж байж хяналтад орно. Ийм зэрэмдэг юм хийхээ болио.

Одоо энэ банкнуудад хэн ч мөнгөө итгэж хадгалуулахгүй шүү дээ. Гүйлгээ хийлгэхгүй шүү дээ. Түүний нэг нь Оюутолгой байна. Дандаа луйвар тэнд явагдаж байдаг, мөнгө угааж байдаг. Нөгөө талаар энэ төмөр зам нарийн

төмөр зам нааш нь оруулж ирмээр байна, бүүр Чойр хүртэл татмаар байна. Тэгэхгүй бол одоо энэ бензин тосны үнийг хар л даа. Хамгийн үнэтэй бензин тос хэрэглэж байгаа чинь Монгол Улс л байна шүү дээ. ОХУ хоригт орчихсон. Энэтхэг, Хятад, тэр Арабын нэгдсэн улсад 2 дахин хямд үнээр зарж байгаа шүү дээ. Хятадаар дамжуулаад бид нар маш хямдхан авч болно. Нэг их олон сайд нартай 20, 30 сайдтай. ОХУ-аас та нар тэгээд хямдхан аваад ирж яагаад чаддаггүй юм. Хоригт орчихсон байгаа энэ үед нь. Бусад улс орнууд авч чадаж байна шүү дээ.

Тэгээд шүүх байна. Одоо ийм шүүхээр шүүлгэх гэж хөрөнгөө оруулах уу хүн. Нөгөө талаар гаднын хөрөнгө оруулалтуудыг маш их дээрэмдсэн. Тэр Хууль зүйн сайд нь гарч ирээд тийм, тийм дээрэм тонуул явсан байна гээд ингээд ярьж байсан. Тэгээд нэг их сүртэй чанга дуугараад, дараа нь үйлдэл байхгүй. Одоо хэн итгэх юм. Өмнө нь мөнгөө дээрэмдүүлчихсэн, луйвардуулчихсан улсууд. Энэ дээр ямар ажил хийсэн юм. Тэр байтугай манайх 40, 50 оны үед латин үсэгт шилжсэн байсан. Одоо латин үсэгт ч гэсэн шилжих хэрэгтэй шүү дээ. Ийм юмнуудыг зоригтой, зоригтой хийгээч ээ. Хоног хугацаа яваад байдаг. Аягүй бол 3-ны 2 нь ядуурах нь байна шүү дээ, энэ маягаараа. Энэ нүүрсний үнэ дандаа ийм байхгүй шүү. Хэдхэн сарын дараа доошоо унана. Хөрөнгө оруулалтууд бүх газар хүсдэг шүү дээ. Хятадаас хөрөнгө оруулалтын 40 хувь нь гарч байна. Тэгэхэд наашаа орж ирж байгаа юм юу ч алга байна шүү дээ. Оросоос гарч байна, тэр Энэтхэг рүү, Вьетнам руу л яваад байгаагаас биш Монгол Улс руу юу ч орж ирэхгүй шүү дээ. Тэгэхээр та нарын ажил хангалтгүй байна. Өшөө сайн наад юмаа сайжруулах ёстой гэж бодож байна. Бас хамгийн зөв зүйтэй юм нь үүнийгээ оруулж ирж байгаа нь энэ гэж ойлгож байна.

Г.Занданшатар: Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Би Ганбат гишүүний олон зүйлтэй санал нэг байна. Би бас дотроо таныг нэг иймэрхүү үг хэлэх ч болов уу гэж бодож байсан. Үнэхээр бидэнд бас юмыг арай өөр нүдээр харах цаг ирчихсэн шүү бүгдээрээ. Энэ Монголын ард түмэн энэ том зургаараа зөв яваасай л гэж хүсэж байгаа юм. Сая тэр нүүрсэн дээр гарсан асуудлууд юу болов, Хөгжлийн банкн дээр ямар, ямар асуудлууд явав. Хөгжлийн банк нэг банкны хармаанд гүйгээд орчихсон. Нүүрсэн дээр ил тод бус байдал нь ийм байдалд орсон. Ингээд их олон зүйлийг өөрөөр харах ёстой гэж хэлж байгаа. Ялангуяа би энэ Ганбат гишүүний сая хэлсэн олон зүйлүүдийг бид нар өөрөөр харж, шийдвэрүүдийг хурдтай гаргаж явахгүй бол үнэхээр болохгүй.

Нөгөө нэг танкаа ярьсан, нөгөө нэг цусаа ярьсан, нөгөө нэг айлгах тактик авч хэрэгжүүлсэн ийм журмаар Монгол Улс явамгүй байна. Үнэхээр бас санаа зовж байгаа зүйлүүд байна шүү дээ. Тэгээд Их Хурлын гишүүд маань бид нар юмыг жаахан эрүүлээр хардаг болмоор байна. Дэлхийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлж алхдаг болмоор байна. Буруу зүйлийгээ хурдан, хурдан засмаар байна. Хулгайчдыг, мафийн эздийг, хөшигний ард бүгдийг нь зохицуулаад суудаг, хэрэг нь ирэхээр гадагшаа яваад зугтаад явчихдаг хүмүүсийг тал талдаа хамгаалмааргүй байна. Энэ дотор. Ярихдаа их гоёор ярьдаг. Би Ганбат гишүүний хэлж байгаа зүйлтэй олон зүйлтэй санал нэг байна. Би АН-аас таныг л ийм үг хэлэх болов уу гэж бодсон.

Шүүхтэй холбоотой асуудал. Энэ хууль дээр бид нар ямар нэгэн маргаан гарвал эхлээд янз бүрийн арбитр ч байдаг ч юм уу, шүүх дээр очихгүйгээр нэг татварын маргаан таслах зөвлөл шиг эхлээд ярих гээд үздэг. Тэндээ ойлголцоод шийдвэрлэх ийм нэг завсрын бүтэц

оруулаад ирсэн байгаа. Түүн дээрээ шийдэж чадахгүй байгаа бол тэр шүүх рүүгээ явна уу, Арбитрыг руугаа явна уу. Тэр бүгдийг нь нээгээд өгчихсөн байгаа.

Шууд Сингапурын ч гэдэг юм уу, Лондонгийн арбитрт хандаад явах нь тэр хөрөнгө оруулагчдын хувьд энэ нээлттэй. Бид нар үүгээрээ юу гэж хэлэх гээд байгаа юм бэ гэхээр тэр бизнес эрхлэгчдэд зүгээр л боломж олгоод өгчих сонголтуудтай л байг. Хэн нэгэн хүний бодоод олчихсон юмаар чи ийш нь хий гэж ингэхгүйгээр тэр шүүх нь ч байг, арбитр нь ч байг. Эхлээд бас маргаан таслах зөвлөл шиг ийм зүйл дээр яриад асуудлаа шийдье гэдэг нь нээлттэй, сонголттой болох ёстой.

Г.Занданишатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Ер нь уурхай дээр л жаахан гайгүй байгаа шүү дээ. Түүний ачаар бас нэлээн хэдэн залуучууд ноу хау мэдлэг туршилагатай болоод дэлхийн хэмжээнд ажиллаж байх шиг байна. Энэ гадаадын хөрөнгө оруулалттай ажил чухал аа. Сүүлийн үед энэ Францын Рона юу болсон бэ. Овоо яриад бүтэх нь барих нь гээд байсан чинь нэг л чимээгүй хачин болчихлоо. Тэр хэвээрээ явж байгаа юу эсвэл ямар нэгэн байдлаар өөрчлөлт ороод байна уу. Тэр байтугай энэ Улаанбаатарын дээр ирчхээд буцлаа ч гэх шиг. Энэ Улаанбаатарт чинь ямар хүн амьдрах юм бэ? Та нар энэ 8 жилийн дотор арай дэндүү болгосон байна шүү. Гаднын элчин сайдын яамдууд хүртэл хамгийн хүнд хортой нөхцөл гэдгээр бараг нэмэгдэл авдаг юм шиг байна билээ шүү дээ. Одоо энэ Улаанбаатараас чинь 2 хүний нэг нь амьдарч байгаа Монгол хүний. Эрүүл хүн гэж алга. 5, 10 жилийн дараа бүгд өвчтэй зовлонтой ийм болно. Энд чинь гадаадын хөрөнгө оруулалттай эмнэлэг хэрэгтэй байна, эмч нар хэрэгтэй байна.

Г.Занданишатар: Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Энэ Ронагийн хэлэлцээр явж байгаа болов уу гэж бодож байна. Асуудал хариуцаж байгаа хүмүүс нь хийгээд явж байгаа байх гэж би дотроо бодож байна. Тэгээд таны бухимдаад хэлж байгаа зүйлийг би ойлгож байна. Тэгээд энэ бүгдийгээ хэдүүлээ нийлж байгаад засъя. Жаахан өөр нүдээр харъя л гэж энэ хуулиудыг оруулж ирээд явж байна шүү дээ. Энэ бид нар өөрсдөө ингээд сууж байгаад, дээшээ харж хэвтэж байгаад биччихсэн зүйлүүд биш шүү дээ. Яг бизнес эрхлэгч нар, хөрөнгө оруулагч нар, энэ гадаад, дотоодын байгууллагууд, үндэсний аж ахуйн нэгжүүд байна, Худалдаа аж үйлдвэрийн тэнхимүүдтэйгээ тэдний янз бүрийн клубүүдтэй нь уулзаад ярилцаад тэд нарын саналыг бид нар томьёолж оруулж ирж байгаа л асуудал.

Бид нар ард иргэдийнхээ үгийг сонсдог байх ёстой. Аж ахуйн нэгжүүдийнхээ үгийг сонсдог тэд нарын хүсэлтийг анхаарч энэ нь зөв юм байна гэж үзэж бид нар оруулж ирж байгаа зүйл юм шүү гэдгийг би хэлмээр байна. Яг тэгэхээр Ганбат гишүүн таны хэлж байгаа зүйлүүд энэ хууль дээр ороод ирвэл энэ тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх ийм боломжтой юм байгаа. Дахиад хэлье. Энд 72 гишүүн байгаа. Гишүүд маань юмыг жаахан өөр нүдээр харъя, хэдүүлээ. Энэ Монголынхоо ирээдүй болсон энэ залуучуудад бид нар нэг хоногийн ч өмнө гэсэн буруу зүйлээ засах ёстой. Үүний төлөө л ажиллацгаая хэдүүлээ. Тэгээд өөр өөрсдөөсөө хамаарах зүйлээ л хийе. Түүнээс биш Бурхан багш ирээд үүнийг засахгүй, янзлахгүй. Яг засах хүмүүс нь бид нар одоо энд сууж байгаа. Хамтдаа үүнийг хийе. Тэгээд Ганбат гишүүн дэмжиж байгаа. Яах вэ хатуу үг хэлж л байна. Гэхдээ зарчмын хувьд дэмжиж байгаад баярлалаа.

Г.Занданшатар: Ганибалын Амартүвшин гишүүн.

Энэ асуудал чухал асуудал учраас сайн ярилцаад, маргаантай асуудлуудаар нийгэмд зөв ойлголт өгөхөд үүднээс гаргаж байгаа шүү дээ. Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Баярлалаа. Энэ бас нэг их сонин байна. Та нар чинь тэр намынхаа бүлэг дээр ярьдаг юм уу, ярьдаггүй юм уу энэ юмаа. Одоо энэ Ардын намын гишүүд нь хүртэл тархи толгой нь угаагдчихсан ийм байхад энэ ард түмэн чинь аргагүй шүү дээ. Энэ юмаа хүмүүст сайн тайлбарла нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ Засгийн газрын гишүүд чинь яагаад эсэргүүцээд байгаа юм. Эд нарыг огцруул л даа, тийм соль. Юугаа хийдэг юм. Ийм арга хэмжээ авч болохгүй юу. Та чинь Шадар сайд билүү ямар байгаа билээ. Шадар сайдынхаа өмнөөс янз, янз янзын юм яриад л. Танайх чинь их сахилга баттай нам гээ биз дээ. Гол нь энэ Ардын намаас нэг хэсэгтээ салмаар байна шүү. Монголын ард түмэн. Жанцан Ардчилсан намаас ч гэсэн бас салах хэрэгтэй, цэвэрлэх хэрэгтэй. Аль алийг нь. Тэр цэвэрлэнэ, барина гээд буруу зөрүү юм яриад байдаг юм билээ. Энэ дээр манай ард түмэн бас зөв зүйтэй хандаж, намын янз бүрийн энэ улс орны хөгжил тушаа болсон хэчнээн жил.

Г.Занданшатар: Ганибалын Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Баярлалаа. Хөрөнгө оруулалтын тухай хуульд оруулж ирж байгаа Эдийн засгийн хөгжлийн яамныханд талархаж байна. Үнэхээр энэ маш чухал хууль орж ирж байна. Үүнийг бид нар аль дээр үед л хэлэлцээд шийдвэрлэх байсан хууль юм. Энэ хууль дээр ингээд шүүмжилж байгаа дүрүүд ойлгомжтой. Эд нарын хийж чадах улс төр нь энэ юм л даа харамсалтай нь. Гэхдээ эд нарын ярьж байгаа нөгөө л нэг

хадны мангаагаар айлгадаг, нөгөө гаднынхан нь орж ирээд л бүх юмыг дээрэмдэж тоноод л монголчуудад юу ч үлдэхгүй гэж ярьдаг. Нөгөө төмөр замаар танк орж ирдэг гэдэгтэй яг адилхан.

Тэгэхээр бид нар энэ үлгэрээ дахин дахин яримааргүй байна. Үнэхээр бид нар энэ эдийн засгийнхаа тусгаар тогтнолдоо санаа зовж байгаа юм бол эжинхэнэ утгаар нь бид нар энэ эдийн засгаа нээлттэй болгох хэрэгтэй. Эд нарын яриад байгаа энэ 2 том хөрш бид нарын урд, хойд байгаа юм чинь бид нар аль болохоор хаалттай байх ярина гэдэг чинь маш буруу. Эсрэгээр бид нар нээлттэй байх ёстой. Тэгэхдээ тэгж байж бид нар эдийн засгийн тусгаар тогтнолоо авч үлдэнэ гэдэгт би 100 хувийн итгэлтэй байгаа. Тэгээд энэ хуулийн хэлэлцүүлгийн үеэр энэ хуулийн төслийг дэмжсэн гишүүдийг харж л байгаарай. Нэлээн хэвлэл сошиалаар харлуулах тийм үйл ажиллагаа явуулна. Энэ нь өмнө нь бас гарч байсан тохиолдол юм аа. Тэгэхлээр энэ дээр ерөөсөө шантрахгүй манай яамныхан болон бусад гишүүд, Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийнхэн энэ дээр сайн ажиллах хэрэгтэй шүү.

Одоо бид нар нэг юмыг маш сайн ойлгох хэрэгтэй. Яагаад Монголд хөрөнгө оруулалт их өндөр өртгөөр орж ирдэг вэ гэдэг чинь яг үүнээс болж байгаа юм. Хүү болон өгөөж. Яагаад манай аж ахуйн нэгжүүд гаднын хөрөнгө оруулагчийг оруулж ирэхдээ компанийнхаа үнэлгээгээ тохирчхоод илүү хувь тэр гаднынханд өгч байгаа вэ гэдэг чинь гаднын хөрөнгө оруулагчид танай улс чинь эрсдэлтэй байна. Бид нар өгөөжөө бодоод танайхаас илүү ноогдол ашиг авна. Тэгж байж бид нар энэ хөрөнгө оруулалтынхаа зөвтгөнө гэсэн ийм л шалтгаанаар манай компаниуд өгөх ёсгүй хэмжээний өндөр хувиа гаднынханд өгдөг. Яагаад гэхлээр энэ тогтворгүй байдал, аль нэг поп улс төрч нь гарч ирээд л бид нарын хөрөнгө оруулалтыг урьдчилж тооцож

боломжгүй аргаар манай эрсдэлийг нэмэгдүүлдэг болохоор бид нар ингэж эрсдэлийнхээ премиумаа авна гэж ярьдаг. Тэгэхлээр үүнийг бид нар энэ хөрөнгө оруулалтын хуулиараа нэг тийшээ болгох хэрэгтэй. Саяхан бизнесийнхэнтэй уулзахад 10, 20 жил манайд бизнес хийсэн гаднын хөрөнгө оруулагч үнэхээр шантарчихсан явж байна билээ. Би бол нэг л төрлийн бизнес 20 жил хийсэн, тэгээд жил болгон юм уу, тодорхой хугацааны дараа ингээд нөгөө л зөвшөөрлөө дахин, дахин авдаг.

Гэтэл зөвшөөрөл авах болгонд маш хүндрэлтэй. Цаг хугацаанд нь гаргаж өгдөггүй. Бид нарын бизнес ингээд л хэвээрээ байж байхад чинь дахин, дахин нөгөө анхдагч бичиг баримтаа шаарддаг. Үүнийг бид нар бас цэгцэлмээр байгаа юм аа. Энэ нөгөө далд бизнес хийх өртгийг нэмэгдүүлж байгаа энэ хүчин зүйлийг бид нар анхаар хэрэгтэй. Уг нь бид нар Зөвшөөрлийн тухай хуулиар цэгцэлсэн боловч хэрэгжилт нь бас хангалтгүй байгаад байгаа юм.

Ер нь манай эдийн засгийн онцлог нь нэг юм юу вэ гэхээр энэ төрийн оролцоог аль болохоор бид нар багасгах хэрэгтэй. Төрийн оролцоо их байгаа болохоор л бид нарын энэ бизнес хийх өртөг, энэ хомсдол, импортын барааны инфляцад бас их хэмжээгээр нөлөөлж байгаа гэдгийг хэлмээр байна. Тийм болохоор миний хувьд энэ Хөрөнгө оруулалтын тухай хуулийг 100 хувь дэмжиж байгаа. Бусад гишүүд бас дэмжихийг би уриалж байгаа юм.

Г.Занданшатар: Дэмжиж үг хэллээ. Гонгорын Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Хөрөнгө оруулалтын хууль орж ирж байна. Маш удаж байж орж ирлээ. Их ч хүлээлээ. Яах вэ, тэр бизнес хийж үзээгүй, төрөөр их олон жил явчихсан эсвэл төртэй хамтарч бизнес хийгээд сурчихсан хүмүүс үү, эсвэл бас нэг бизнесийн салбарыг эзлээд

суучихсан хүмүүс бизнесээ хамгаалах гээд, үнэтэй байлгах гээд, ашигтай байх гээд ингээд хадны мангаагаар айлгаад байгаа юмнууд харагддаг, шулуухан л ярьчихаж байх хэрэгтэй. Гадаадын хөрөнгө оруулагчид татвар өндөр байх уу, роялти өндөр байх уу, бага байх уу. Ерөөсөө ярьдаггүй. Ганц л зүйлийг хүсдэг. Тогтвортой байж чадах юм уу, нэгдүгээрт танай хууль эрх зүйн орчин.

Хоёрдугаарт, бид нарын оруулсан хөрөнгийг хамгаалж өгч чадах юм уу. Чадахгүй бол бид нар маш богино хугацаанд, маш өндөр хүүтэй мөнгө оруулж ирээд л өндөр хувиар хийгээд гараад явна гэдэг ийм бодлого хийдэг. Бизнес хийж байгаа хүмүүс бүгдээрээ л мэддэг. Тогтвортой байх юм бол урт хугацааны ашиг хийнэ. Бага хүүгээр бага ашигаар явна. Урт хугацаандаа ашигаа хийнэ гэж үзнэ. Тогтворгүй байх юм бол богино хугацаанд өндөр хүүтэйгээр орж ирээд л гараад явахыг хичээнэ. Тийм учраас хөрөнгө оруулалтын үр дүн гарахгүй байна гэдэг шүүмж гарч байгаа нь ийм учиртай. Тэгэхээр бид нар тогтвортой, хамгаалж болдог ийм л эрх зүйн орчныг бид нар өгөх ёстой.

Хоёрдугаарт, бизнесийн маргаанаа шийдэх энэ олон улсын эрх гарц үүдийг нь шууд нээх хэрэгтэй. Болж өгвөл тэр Англи саксоны хуулийн зохицуулалттай бизнесийн эрх зүйтэй тэр орнууд руу нь хандуулах ёстой. Ингэж байж бид нар гадаадын хөрөнгө оруулалтыг татна. Дэлхийн бүх улс орнууд л хөрөнгө оруулалтын хойноос үзэж байна. Дэлхийн эхний хамгийн 10-д ордог том эдийн засагтай орнууд Канад, Австрали гээд л бид нартай ижилхэн. Би яагаад энэ орнуудыг дурдаж байна гэхээр уул уурхайтай л орнууд. Эд нар ч гэсэн хөрөнгө оруулалтын хойноос үхэн хатан гүйцгээж байна шүү дээ. Тэд нар мөнгө байгаа юу. Байгаа. Гэхдээ гадаадын хөрөнгө оруулалт бол аль ч улсад хэрэгтэй л байдаг. Ажлын байрыг бий болгодог, хямд эх үүсвэрээр бий болгодог, эрсдэлийг

хуваадаг, бууруулдаг ийм л зүйл шүү дээ. Тэгэхгүй бид нар өөрсдөө төсвийн мөнгөөр үйлдвэр бариад, төсвийн мөнгөөр уурхай бариад, төсвийн мөнгөөр аж ахуй хийгээд тэндээсээ хулгайлаад, тэгээд ертөнцийн булай болоод сууж байдаг хүмүүс гэж хаана байх вэ дээ. Тэгээд хөрөнгө оруулалтыг нь нээж өгч байж энэ олон улсын засаглалыг нь оруулж ирэх хэрэгтэй.

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зайлиггүй дараачийн шалтгаан бол дахиад нэг Оюу Толгой, Тавантолгойг бид нар үйлдвэрлэх хэрэгтэй. Бий болгох хэрэгтэй байна. Тэгээд үнэхээр Оюутолгойн гэрээ муу гээд байгаа бол, үнэхээр Монголд орж ирчихсэн байгаа энэ томоохон хөрөнгө оруулалтууд муу гээд байгаа бол 2, 3, 4, 5 Оюутолгойтой болчихоод нэгнийх нь гэрээг нь, өө та нартай, та наргүй бид нар амьдарна гэж хэлж чаддаг нүүртэй, бянтай болчихмоор байна шүү дээ, эдийн засагтай. 4, 5 баганатай болж байж бид нар тэгж даналзаж байгаад, өөрийнхөө хүссэн гэрээг хийж баймаар байна. Тэгээд тийм боломж алга байна шүү дээ. Та нар зүгээр өнөөдөр л Оюутолгойг зогсоочихъё л доо. Эдийн засаг яаж элгээрээ хэвтэхийг бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд дараа, дараачийн энэ эдийн засгийн хөдөлгүүрүүдээ бид нар босгох энэ ажил бол энэ Хөрөнгө оруулалтын хуулиар хийгдэх ёстой.

Эцэст нь, гадаад ажиллах хүчний төлбөр хураамжийг чөлөөлөх ёстой гэсэн асуудал энэ дээр орж ирсэн байна. Маши зөв. Үгүй бол ажил хийх хүн алга болчихоод байгаа юм. Энд бас бид нар өөрсдөө буруутай. Тасралтгүй л халамжийн бодлогоор дэмжиж байна шүү дээ. Халамжлаад л тасралтгүй мөнгө тараагаад байгаа юм чинь хэн ажил хийх юм. Ажил хийхгүй бол бизнес яаж тэлэх юм. Бизнес тэлэхгүй бол эдийн засаг яаж томрох юм. Эдийн засаг томрохгүй бол энэ тараах мөнгө чинь хаанаас орж ирэх юм. Тэгэхээр үүнийгээ хэдүүлээ бодоод

энэ хадны мангаагаар айлгадаг нэг ийм хачин юмнууд байх хэрэггүй байна. Тэгээд хөрөнгө оруулалтын орчноо л сайн болгочихмоор байна. Хуулийг дэмжиж байгаа. Ажлын хэсэгт нь орж ажиллаж гэсэн бодолтой байгаа.

Г.Занданшатар: Дэмжиж үг хэллээ. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Хөрөнгө оруулагч нарыг татна, дуудна гээд мөн аялал жуулчлал, аялагчдыг дуудаж байгаа гээд тэгээд бид бүхэн чинь ер нь хөрөнгөтэй мөнгөтэй улсуудыг татах тэр бололцоо боломж орчин нөхцөлийг хэр бүрдүүлсэн бэ гэж. Аялал жуулчдыг татах, ирээд ая тухтай байх, амар тайван байх, үзэж харах юмтай байлгах тал дээр юу вэ гэж. Өөрсдөө цөөхүүлхнээ, өөрсдөө үйлдвэрлэгч бус худалдан авагч. Тэгээд 2 том хөршийн дунд оршдог.

Тийм учраас бид нар хөрөнгө оруулагчдыг татахаас өөр гарцаагүй л гэж би хувьдаа үздэг. Гэхдээ бас анхаарах зүйлүүд байна. Энэ гишүүдийн хэлээд яриад байгаа, сэрэмжлүүлж байгаа, болгоомжилж байгаа зүйлүүд байна. Үүнийг анхаарахгүй байхын аргагүй. Үндэсний үйлдвэрлэгчдийг яаж хамгаалах юм, үндэсний хөрөнгө оруулагчдыг энэ хуулиар бас яаж хамгаалах юм. Үндэсний үйлдвэрлэлээ яаж бэхжүүлэх юм. Гадаадын том хөрөнгө оруулагч нартаа үндэсний үйлдвэрлэлээ яаж жишиж, хий үйлдвэрлэлээ хөгжүүл гэж ингэж хамгаалж үлдэх юм. Энэ асуудал нь яаж энэ хуулиар хамгаалагдаж байгаа юм.

Нөгөө талаар бид нар гадаадын хөрөнгө оруулагч нар цөөрлөө л гээд байна. Өнгөрсөн хугацаанд дандаа л хулхидаж байсан юм билээ шүү дээ. Ярьсан хэлсэндээ байж чадаагүй. Тийм учраас л хөрөнгө оруулагч нар чинь дайтсан юм байна билээ. Энэ хуулийн шинэчилсэн найруулгаар энэ хуулиараа яаж энэ байдлаа засаж байгаа юм.

Хөрөнгө оруулагч нар эрсдэлгүй, найдвартай орчинд хөрөнгө оруулалтаа хийнэ шүү дээ. Тэгээд энэ байдал чинь яаж дээрдэж байгаа юм бэ, дээшилж байгаа юм бэ. Түүнээс хөрөнгө оруулагч нар дэлхийн зах зээл дээр жагсаад байж байгаа. Тэр дундаас хамгийн найдвартай, боломжтой, эрсдэлгүй улс оронд л хөрөнгө оруулалтаа хийнэ шүү дээ. Тэгээд бид нар боломжийг нь нээж өгөх л ёстой.

Тийм учраас хөрөнгө оруулагч нар хөрөнгөө аль салбарт, аль улсад, ямар боломжтой орчин нөхцөлд хийх вэ гэдгээ өөрсдөө сонгох ёстой. Тэгээд бид нар энэ хуулиар боломжийг нь гаргаж өгөх ёстой. Тийм учраас энэ хуулийн үзэл санаа тэр боломжийг хэрхэн яаж хангаж байгаа вэ, баталгааг яаж гаргаж өгч байгаа вэ, яаж хулхиддаггүй байдлаа бид нар засаж байгаа вэ, яаж хуурдаггүй байдлаа засаж байгаа вэ, тогтвортой байдлаа бид нар яаж энэ хуулиар бий болгож байгаа юм бэ гэдэг ийм асуултад хариулж өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Хүрэлбаатар Шадар сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: Бас үг хэлэх боломж олдсон дээр нь энэ Амартүвшин гишүүн, Дамдинням гишүүн нарт бас талархлаа. Тэгээд Сандаг-Очир гишүүн ээ би танд бас талархъя. Их чухал, чухал асуудлуудыг хөндлөө. Энэ хулхиддаг асуудал. Үндсэндээ бид нар энд тэнд очиж улс орондоо, уулзалтууд хийхдээ, хөрөнгө оруулагч нартай уулзахдаа Монголыгоо аль болохоор л гоёор ярьдаг. Тэгээд ороод ирсэн хүмүүс нь янз бүрийн бэрхшээл учирдаг, хулхидуулдаг ийм зүйлүүд гардаг. Түүрүүн би хэллээ. Хөрөнгө оруулагч нарын гомдлыг Засгийн газар дээр улирал болгон ярьдаг болчихсон байгаа. Оюун-Эрдэнийн Засгийн газрын үед. Ингэхэд анх удаагаа 8 гомдол ирж байсан аж ахуйн нэгжээс. Одоо 69. Дахиад л нэмэгдээд ирж байна. Тэгээд үзэхээр юу гэдэг юм, аж ахуйн нэгжүүдийн гаргасан гомдлыг Засгийн

газар дээрээ байнга яриад байвал тэгээд энэ гомдол дуусахгүй шүү дээ.

Тийм учраас үүнийг шийддэг ийм механизмуудыг нь ялангуяа тэр хулхиддаг асуудал, хууль зөрчдөг асуудлуудыг нь төртэй ч юм уу маргаан үүсэж байгаа энэ тохиолдол дээр тэр Татварын маргаан таслах зөвлөл гэдэгтэй адилхан Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөл гэдэг ийм байгууллагууд дээрээ тал талын оролцоог хангаад, тэгээд ярилцаад тэндээ шийдэх гээд оролдоно. Тэнд шийдэж чадахгүй бол дараа нь шүүх, арбитр руу явах нь нээлттэй хэлбэрээр оруулж ирж өгсөн байгаа. Одоо бол яадаг вэ гэхээр, шууд шүүх ийшээгээ яв гээд, нөгөөх нь 13 жил шүүхээр явсан тохиолдол Монголд бас байгаад байгаа шүү дээ. Дунджаар 3-4 жилийн хугацаатай. Яг ингээд шүүхээр явж байхад тэр хөрөнгө оруулагч аль хэдийн хөрөнгө оруулахгүй, энэ нөгөө хөрөнгөө гаргахаа ярина. Дээр нь маш олон хөрөнгө оруулагч нар түүнийгээ ярьчихдаг.

Монголд хөрөнгө оруулбал ийм л зовлонтой. Тэр дарга, тэр босс, тэр нууц ноёнтой, ингээд л юмыг шийдчихдэг. Нэг хүнээс хамаараад баймааргүй байна шүү дээ. Бүх юмны цаана орчхоод ингээд утсаар хөдөлгөөд байдаг хүмүүсээр шийдүүлээд баймааргүй байна гээд хуульдаа оруулж ирж өгч байгаа юм. Тийм учраас би энэ дээр таны хэлсэн бүх зүйлтэй би санал нэг байна. Хөрөнгө оруулалтыг оруулж ирэх орчныг нь бий болгох ёстой. Боломжийг нь өг. Тэгээд тэр хүмүүсүүд бизнес хийх эрхээ, хөрөнгө оруулалт хийхээ энэ өөрсдөө шийдэг. Харин маргаан юм уу, хулхиддаг барьдаг хууль бус зүйл байвал түүнийг нь сайн хамгаалж өгөх гэж хэлж байгаа зүйлтэй тантай санал нэг байна гэдгийг би хэлье. Тэгээд би таныг ажлын хэсэгт орж ажиллаж өгөөч ээ гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Тэгээд бас миний асуултад дутуу хариуллаа. Тэр үндэсний үйлдвэрлэгч хөрөнгө оруулагчдыг яаж хамгаалж байгаа юм бэ гэдэг дээр бас тодруулж өгнө үү нэгд.

Хоёрт, Монгол Улс ганцхан байгалийн баялагтай. Монгол Улс ганцаараа бас байгалийн үзэсгэлэнт газартай ийм улс биш шүү дээ. Дэлхийн улс орнуудад байгалийн баялагтай, хөдөө аж ахуйтай, байгалийн үзэсгэлэнт газартай улс орон зөндөө байна. Хөрөнгө оруулагч нарыг бид нар ямар бололцоо давуу талаа гаргаж дуудах вэ гэдэг маань л энэ хууль гэж би хувьдаа ойлгож байгаа юм. Тийм учраас байгалийн баялгаа борлуулах, хөрөнгө оруулалтыг татах бололцоо боломж нь бусад улс орнуудаас ийм давуу талтай юм байна. Аялал жуулчлалыг татах давуу тал нь манай улсад ийм байгаа юм байна гэдгийг энэ Аялал жуулчлалын хууль, Хөрөнгө оруулагчдын хууль, эд нар энэ бололцоо боломжийг олгосон хуулиуд байгаа юм байна гэж би хувьдаа харж байгаа юм. Тэгээд тэр дотоодын үндэсний хөрөнгө оруулагчдыг.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Энэ үндэсний хөрөнгө оруулагчдыг яаж хамгаалах вэ гээд. Яг энэ дээр би түрүүн хэлсэн. Энэ МИАТ-ийн жишээг би дахиад давтмаар байгаа юм. Гаднын нислэгүүдийг зөвшөөрөөд оруулаад ирэх юм бол манай МИАТ дампуурчихна гэдэг ийм зүйлийг би олон жил сонсож ирсэн юм. Ярьдаг цөөхөн хүнтэй л дээ. Тэгээд түүнийгээ их гоё үгээр хэлээд, хаагаад яваад байсан. Тэгээд түүнд нь ч ихэнх нь итгээж л байсан байх. Тэгээд иргэний агаарын тээврийг либералчлаад, одоо жишээлбэл Солонгос, Монголын хооронд 7 хоногт 17 нислэг байсан бол одоо 80 орчим нислэгтэй болчихоод байна шүү дээ.

Тэгэхээр яаж байна вэ гэхээр, тэр үндэсний компани болох МИАТ компанийн чинь зах зээл улам л өргөжчихөөд байгаа юм. Яагаад гэвэл ирсэн хүн буцах билетээ авна, янз бүрээр ингэж тэр зах зээл нь өөрөө тэлдэг. Дээд талд нь МИАТ компани чинь тэр компаниудтай өрсөлдөөнд ороод эхлэхээр, өрсөлдөөн чинь тэр бүх эмгэгүүдийг, өвчнүүдийг нь бүгдийг нь эмчлээд өгч байгаа юм. Өрсөлдөөн байж байж энэ бизнес хөгждөг юм байна билээ. Хааж, боож ингэж вакумжчихаад, одоо хөгжөөрэй гээд ингээд алгаа ташаад суугаад байхаар хөгждөггүй юм байна билээ.

Бөхчүүдийг ч хар. Учиргүй ингээд хоолыг нь өгөөд, витаминьг нь тариулаад л шилэн вакумд суулгачхаад суугаад байвал тэр хүн сайн бөх хэзээ ч болохгүй. Тогтмол барилдаж бэлтгэл хийж, өрсөлдөж байж тэр бөх тасархай болно. Түүнтэй адилхан үндэсний аж ахуйн нэгжүүд тэр дотроо орж ирээд өрсөлдөөд яваг. Өрсөлдөөн бол энэ олон эмгэг гажиг, энэ зүйлүүдийг нь засаж янзална. Тийм учраас би энэ МИАТ-ийн жишээг аваад үзэхэд гаднынхан ороод ирэхэд зах зээл нь томроод, манай үндэсний аж ахуйн нэгжүүдийн хийх гэсэн боломж нь бусдаас туршлага судална, суралцана, ноу хауг нь авна. Техник технологийг нь авна, ийм маягаар хөгждөг юм байна билээ гэдгийг би хэлмээр байна. Олон монголчууд маань бөхөө үздэг.

Г.Занданшатар: 13 цаг өнгөрсөн байна. Мэдээлэл танилцуулъя. Өнөөдөр 14 цагаас хийх ёстой байсан Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын албан бичиг ирсэн байна. Соёлын сайд Номин гадаад томилолтоор ажиллаж байгаа тул Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 1 дүгээр сарын 5-ны нэгдсэн хуралдаанд хийх Соёлын харилцаа, хамтын ажиллагааг дэмжих, соёлын, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээний талаарх Ерөнхий сайдын мэдээллийн

товыг хойшлуулж өгөхийг хүсье гэсэн байна. Ийм учраас үдээс хойших Ерөнхий сайдын мэдээллийн асуудлыг хойшлууллаа.

Асуултаа явуулж л байх уу.
Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Би хөрөнгө оруулалтыг дэмждэг хүн. Тэгэхдээ хөрөнгө оруулалт нэрээр луйварчид орж ирэхийг эсэргүүцдэг хүн. Үндсэн хуулийн 5.4-д Монголын Үндсэн хуульд байгаа шүү дээ. 5.4-д төрөөс эдийн засгийг зохицуулна гэсэн заалт байгаа шүү. Бид төрийн зохицуулалттай эдийн засагтай байгаа. МАН-ынхан та нар бол социал демократууд. Тэгэхлээр зохицуулалтгүй байна гэж болохгүй шүү. Төрөөс заавал зохицуулна. Үүнийг гадаадын хөрөнгө оруулагч нарт үндэсний компаниудаа, үндэсний бизнесменүүдээ зүгээр цээжээ дэлгээд тавиад өг гэсэн асуудал биш шүү. Зохицуулалт хийнэ гэдгийг гацаа гэж ойлгож байх юм бол та нар эдийн засгаа үнэндээ ойлгохгүй байна гэсэн үг. Оюутолгойг би ярьдаг. Хэзээ ч Рио Тинто битгий Монголд орж ирээч ээ гэдэггүй.

Монголд орж ирээд та нарын хийж байгаа ажил Монголд ашиггүй байна л гэдгийг ярьдаг. Үүнийгээ ашигтай болгооч ээ гэж ярьдаг. Энэ бол хөрөнгө оруулалтын эсрэг биш. Хөрөнгө оруулалтыг 2 талдаа ашигтай байлгая л гэж байгаа юм. Үндсэндээ уул уурхайн хөрөнгө оруулалт, нийт хөрөнгө оруулалтын 72 хувь байгаа. 11 хувь нь худалдаа, 17 хувь нь бусад нь гэж байгаа. Нийт уул уурхайн хөрөнгө оруулалтуудын сүүлийн 10 жилд 50 хувь нь Оюутолгой гэж байгаа. Оюутолгой яасан бэ. Супер луйвар болсон. Хөрөнгө оруулалт нэртэй луйвар. 7 экспертизийн шинжээчийн дүгнэлт гарчихсан байгаа шүү. Өөрсдөө ч хэлсэн. Энэ дээр бид монголчуудыг хулхидсан. Ийм юм болгохгүйн тулд төрөөс зохицуулалт хийх ёстой л гэдгийг би хэлж байгаа.

Тэгэхлээр би өөрөө хэлээд байгаа юм биш ээ. Чоймский хүртэл хэлсэн байна билээ. Өмнө нь хөрөнгө оруулалт нэртэй энэ орж ирэхэд 10 хувь нь спекуляц байсан, 90 хувь нь хөрөнгө оруулалт байсан. Одоо буурай орнуудад орж ирж байгаа хөрөнгө оруулалт нэртэй энэ юмны 90 хувь нь луйвар спекуляц, бүүр яг тэр үгээр нь хэлж байгаа юм. 10 хувь нь хөрөнгө оруулалт байна. Болгоомжтой байгаарай, зохицуулалтаа сайн хийгээрэй. Энэ утгаараа зохицуулалт байх ёстой.

Би асуултуудаа асууя. Урьд нь 2013 онд орж ирж байхад ч гэсэн асууж байсан асуулт маань бас байгаа шүү. Энэ нэгдүгээрт, төслийн 16.1.1. заалт нь газрыг 100 жил хүртэл жилээр гадаадын хөрөнгө оруулагчдад ашиглуулах нь хүний амьдралын бараг 4 үе шүү дээ. Энэ чинь 4 үетэй тэнцэж байгаа. Энэ нь хойч үеийнхэнд эрсдэл үүсгэж болох уу. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс үүний дүгнэлт гарсан уу, нэгдүгээр асуулт. Олон гишүүд асуусан учраас би тайлбарлаад яах вэ.

Хоёрдугаар асуулт, төслийн 16.1.2-т заалт нь бусад хөрөнгө оруулагчийн бизнес эрхлэх өрсөлдөх боломжийг хязгаарлах нөхцөл бүрдчихсэн байна гэж би үзэж байна. Би 16.2-ыг уншиж өгөх үү. Чөлөөт бүс үйлдвэрлэл технологийн паркт үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагч дэмжлэг үзүүлэх бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсөн горимоор үйлчлэх бусад нь яах вэ.

Дараагийн асуулт, 16.1.3. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс ч хөнгөлөх чөлөөлөх, яг энэ чинь Сарангэрэл гишүүн ч түрүүн асууж байсан. 170 тэрбум төгрөг өнөөдөр хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих санд байгаа. Үндсэндээ яг энэ гадаадаас орж ирж байгаа ажилчдыг монгол ажилчдын ажлын байрыг үндсэндээ авч байгаа. Монгол ажилчид чадваргүй байж болно, хангалтгүй байж болно. Тэднийг

дэмжиж, тэднийг чадвартай болгох гэж байгаа энэ 170 тэрбум төгрөг алга болох нь ээ. Энэ дээр та нар эрх зүйн дүгнэлт гаргасан уу, яаж дүгнэх вэ. Монгол ажилчид бэрхшээлтэй байж болно. Тэгэхдээ бүүр огт байхгүй бол бид яах юм бэ.

Миний дараагийн асуулт, төслийн 16.1.5-д заалт нь, хүн ам зүйн бодлогод сөрөг нөлөө үзүүлэхэд болох юм. 1.5-ыг та нар хараарай.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Ганбаатар гишүүн ээ, зохицуулалт байна. Хууль байгаа учраас зохицуулагдаж байгаа шүү дээ. Хуулийн дагуу зохицуулагдана гэсэн үг. Түүнээс биш бүх юм зохицуулалтгүй гэж ярьж байгаа бас биш шүү. Монгол Улс хуультай. Хуулийнхаа дагуу Монгол Улсын эдийн засаг, нийгмийн бүхий л амьдрал өрнөж байгаа. Тийм учраас огт зохицуулалтгүй болох гэж байгаа юм шиг бас та битгий ойлгоорой. Энэ хуулиа ярьж байна гэдэг чинь бид нар зохицуулалтуудаа яаж хийх вэ л гэдгээ ярьж байгаа гэдгийг хэлье.

Энэ 1993 онд батлагдсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар газрыг 60 жилээр ашиглуулах тэгээд 40 жилээр сунгах гээд ийм заалттай баталчихсан юм байна билээ. Одоо яах вэ, зарим нэг хүмүүс Хүрэлбаатар хийчихсэн юм шиг яриад байгаа юм. Би 1993 онд Монгол Улсын их сургуульд багши байсан юм. Тэр үед хийгдсэн хууль юм шүү. Тэгэхээр түүнийг дахиад хэлчихье. Харин 2013 онд та бид 2 Улсын Их Хуралд хоёулаа хамтдаа гишүүн байж байх үед Засгийн газрын Ерөнхий сайд нь Алтанхуяг байхад, Улсын Их Хурлын дарга нь З.Энхболд байхад 60 жилээр газрыг эзэмшүүлнэ. 60 жилээр

газрыг эзэмшүүлнэ, ашиглуулна гээд оруулчихсан юм байна билээ.

Энэ нь одоо Үндсэн хуультайгаа зөрчилдөөд байгаа учраас бид нар энэ эзэмшүүлэхийг нь аваад хаячихсан юм. Яг эсрэгээрээ шүү. Энэ олон моёочуудын яриад, гүтгээд дайраад байгаагийн яг эсрэг заалтыг нь бид нар хийж байгаа юм. Эзэмшүүлэх гээд оруулаад ирчихсэн зүйлийг нь бид нар авч хаяж байгаа юм. Үндсэн хуульдаа нийцүүлээд гэдгийг хэлье. Тэгэхээр 2013 онд яаж хэлэлцүүлэг явж байж энэ нь орж ирснийг та ч санаж байгаа, би ч санаж байгаа. Та бид хоёр хоёулаа хамтдаа Улсын Их Хурлын гишүүн байсан, тэр заалт нь хэвээрээ явж байгаа. Тэгэхээр таны асуултад З.Энхболд, Алтанхуяг нар нэлээд тодорхой хариулт өгөх байх. Харин бид нар одоо эзэмшүүлэх гэдгийг нь Үндсэн хуульдаа нийцүүлээд авч хаяж байгаа гэдгийг хэлье.

Ажлын байрны хураамж дээр Ганбаатар гишүүн ээ, ийм юм болоод байгаа юм. Бид нар бизнесүүдтэй уулзсан. Уулзаад яг эхний асуудал бол чадалтай боловсон хүчин бидэнд олдохгүй байна. Энэ бол бид нарын өмнө боловсролын салбарт гаргаж ирсэн алдаа. Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх чиглэл дээрээ гаргаж ирсэн алдаа. Ийм л зүйл болчихсон байгаа. Тэгэхээр бид нар авдаг татвараа биш аж ахуйн нэгжүүд чадалтай боловсон хүчин олж авах энэ боломжийг нь л нээж өгч байгаа. Өөрөөр хэлбэл татвараар биш аж ахуйн нэгжүүдийн өөрсдийнх нь эрх ашигт нийцсэн сайн боловсон хүчин олж авах боломжийг нь хангаж өгсөн ийм заалт байгаа юм. Татвараа бол Сангийн сайд байсан гээд юм л бол татвар гээд та шүүмжилдэг байсан шүү дээ. Тэгээд эсрэгээр нь аж ахуйн нэгжид нийцсэн хууль оруулж ирж байгаа юм шүү гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууна.

С.Ганбаатар: Тэр түрүүний 100 жилийг би таныг оруулж ирсэн гэсэнгүй. Урьд нь ч гэсэн би асууж байсан асуултаа. Энэ дээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл буюу та бид 2 мэддэггүй, тэр шинжээч мэргэжилтнүүд нь мэддэг улсуудаас дүгнэлт гаргасан уу, олон гишүүд үүнийг асууж байна гэж би тодруулсан.

Хоёрдугаар зүйл гэвэл төслийн 17.1.4-д заалтаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тогтворжуулах боломжтой байгаа нь бусад уул уурхайн салбарын бизнесийг хязгаарлах ялгаварлалтай байдлыг үүсгэж байна. Оюутолгой 5 хувь, ГОК 16 хувь үүнийг шийдсэн үү. Энэ чинь гаднын хөрөнгө оруулагч гээд үндэсний компаниудаа ялгаварлаж болохгүй л гэдэг асуудлыг ярьж байгаа. Энэ асуудал дээр би хариулт авах хэрэгтэй байна. Хуулийн үзэл баримтлалын ер нь протекшизм гэж байдаг. Манай иргэд өнөөдөр Америк руу, Европ руу, Солонгос руу явж чадахгүй байна, виз гарахгүй байна гэдэг чинь протекшизм. Протекшизмыг муу гэж ерөөсөө үзэж болохгүй. Бид зохицуулалт хийж.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар Шадар сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: 2013 онд Ерөнхийлөгч нь Элбэгдорж байсан, Их Хурлын дарга нь Энхболд байсан, Ерөнхий сайд нь Алтанхуяг байхад тэр 60 жилээр газрыг эзэмшүүлж ашиглана, 40 жилээр сунгана гээд 100 жил гэдгийг 2013 онд хуульд хийгээд өгчихсөн шүү дээ. Тэр үеийн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл юу ярьж байж хийснийг би үнэхээр мэдэхгүй. Одоо бол Үндсэн хуульдаа нийцүүлээд тэр эзэмшүүлэх гэдгийг нь хасаж оруулж ирж байгаа. Зүгээр яг эсрэгээрээ Хүрэлбаатар гэдэг хүнийг харлуулахын төлөө би таныг гэж хэлээгүй шүү, бусад нь дайраад байгаа мочачууд. Би үүнийг Их Хурлын энэ

чуулган дээр бид нар залруулах ёстой, тэр Элбэгдорж, З.Энхболд, Норовын Алтанхуяг нар юу бодож өөрчлөлт хийж байсныг би мэдэхгүй. Тэр үедээ яригдаад хийсэн байлгүй. Тэгэхээр би архиваас тэд нар материал өгөөдхөөч гээд би хүсэлт тавиад, түүнийг нь авчхаад би танд тэр үеийн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл ийм шийдвэр гаргахдаа ингэж хандаж байсан юм байна билээ гэдгийг хэлье.

Татвартай холбоотой зүйлүүдийг би энэ Хөрөнгө оруулалтын хууль дээрээс бүгдийг нь аваад хаячихсан юм. Яагаад гэвэл, татвар бол Татварынхаа хуулиудаар шийдвэрлэгдэх ёстой. Тэгэхгүй бол Хөрөнгө оруулалтын хууль дээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлт оруулчихаар нөгөө аж ахуйн нэгж тэр Хөрөнгө оруулалтын хуулийг хараад хөрөнгө ороод ирчихдэг. Гэтэл татварын байцаагч нар -өө энэ Хөрөнгө оруулалтын хууль бидэнд нэг их чухал биш, бид нар татварынхаа багц хуулийг харна гээд л татварын багц хуулиа хараад акт тавиад явчихдаг. Тэгээд энэ чинь аж ахуйн нэгжүүдийг бид нар хэлмэгдүүлээд байгаа юм. Хооронд нь хуулиуд нь зөрөөтэй учраас.

Тийм учраас энэ татвартай холбоотой, АМНАТ-тай холбоотой зүйлүүд энэ хуулиар зохицуулагдахгүй. Тэр татварын хуулиараа, Ашигт малтмалын тухай хуулиараа зохицуулагдах юм. Энд ороогүй шүү л гэдгийг хэлэх гэсэн юм.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Практикал шаардлага гэж байна. Энэ дээр 2015 оноос хойш Монгол Улсын эдийн засгийн өсөлт гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгалаас хамаарч байгаа гэж байгаа юм. Манай эдийн засгийн бодлого уг нь бусад орны ч гэсэн эдийн засгийн бодлого гадаадын хөрөнгө оруулалтаас шууд хамаарах биш үндэсний бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанаас

хамаардаг байх нь бидний бодлого. Тэгээд 72 хувь нь уул уурхайгаас хамааралтай гэж байгаа юм. Уул уурхай үнэхээр жин дарж байгаа үнэн. Өнгөрсөн 1990 оноос 2022 онд 39.7 тэрбум долларын гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж ирсэн байна. Бид 33 тэрбум долларын өртэй болчихсон байгаа одоо. Тэгэхээр Оюутолгой шиг уул уурхайн ихэнх нь байгаа л даа 72 хувь нь. Энэ дээр дүгнэлт хийсэн үү, энэ дээр яагаад яг эрх зүйн орчны дүгнэлтүүд хийсэн үү. Яагаад би үүнийг асууж байна гэвэл хөрөнгө оруулалт амжилттай боллоо.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: Монгол Улсын хувьд бид нар гадаадын хөрөнгө оруулагчдыг хэрэггүй гэж хэлээд хэрэггүй л дээ. Монгол Улсад тэр гаднын хөрөнгө оруулагч нь ч бай, дотоодын хөрөнгө оруулагч нь ч бай. Чадалтай Монгол Улсын аавын хүүхдүүд байвал гадна гараад ч гэсэн бусад оронд хөрөнгө оруулалтаа хийгдээд яваг. Хэдүүлээ дэлхийн хөгжилтэй л хөл нийлүүлж ажилламаар байна шүү дээ. Зөвхөн бид нар өөрсдөө хийгээд хаалгаа хаагаад Хойд Солонгос шиг явж болно л доо. Тэгээд энд, энэ ард түмэн бид нараас сайхан амьдралыг нэхнэ. Үр хүүхдүүд нь өндөр боловсролыг нэхнэ, сайн эрүүл мэнд нэхнэ, үйлчилгээг сайхан үйлчлүүлэхийг хүснэ. Аятай тавтай орчинд амьдрахыг хүснэ. Бид нар жоохон том хармаар байна. Бүгдийг нь үгүйсгээд хэрэггүй. Тийм учраас бид нар хөрөнгө оруулагч нар хувийн хэвшлийг дэмжиж байж Монгол Улс хөгжинө. Бүгдийг нь Засгийн газар өр авч бүгдийг нь хий гэдэг үг бол биш ээ Ганбаатар гишүүн ээ.

Тийм учраас бид нар энэ улс оронд хөрөнгө оруулалтыг дэмждэг, хувийн хэвшлийг дэмждэг, тэр ААН бизнес ард иргэдэд боломжийг нь олгодог ийм л байх ёстой. Ингэж байж энэ Монгол улс хөгжинө. Түүнээс биш бид нар гоё нэртэй

ТЭЗҮ, гоё нэртэй судалгаа дүгнэлт бүх юман дээр нэхдэг байж болохгүй шүү дээ. Байгаль орчин ингээд хар кофе шопод нээхэд байгаль орчны үнэлгээ шаардаж байгаа шүү дээ. Гэтэл тэр зүгээр стандартаар явчих боломжтой. Ингээд ийм нэг дүгнэлт, экспортуудын дүгнэлт ийм юм нэхсээр байтал энэ Монгол Улс ингээд доошоогоо яваад, тэр бизнес эрхлэх хүмүүс чинь халгаад зүрх нь үхээд дуусаж байна шүү дээ. Ингэж боломгүй байна хэдүүлээ, жаахан эрх чөлөө энэ...

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн алга байна. Нанзаддын Наранбаатар, Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Монголд хөрөнгө оруулалт хэрэгтэй байна уу, үнэхээрийн хэрэгтэй байгаад байгаа юм. Тэгэхдээ улс орнууд нэг юм хараад байх шиг байна. Тэр юу хараад байна гэхээр зэрэг үйлдвэр байгуулах хэрэгтэй, баялаг бүтээдэг байх хэрэгтэй, татвар төлдөг байх хэрэгтэй. Ажлын байр бий болгодог байх хэрэгтэй. Тэгээд мэргэжилтэй боловсон хүчин ажилтнаа бэлтгэдэг байх ёстой. Ийм л хөрөнгө оруулалт чухал гэдэг юмыг дэлхий нийтээрээ яриад байх шиг байна.

Тэгэхээр бидний оруулж ирчхээд байгаа энэ хууль маань энэ асуудлуудаа хэрхэн цогцоор нь харж зохицуулж чадсан бэ гэдэг асуудал гол нь байгаа. Түүнээс энд нэг ч хүн Хөрөнгө оруулалтын хуулийг дэмжихгүй барихгүй гэсэн үзэл бодол байхгүй. Аль болохоор үүнийг цогцоор нь зөв шийдлийг нь олох юмсан гэдэг үүднээс асуудалд хандаж байгаа болов уу гэж би ингэж бодох юм.

Монголчуудын заяа буян өндөр юм шиг байгаа юмаа. Би тэгж боддог юм. Хүнд цаг үед заяагдмал баялгийнх нь эрэлт үнэ хоёр өндөр байгаад байгаа. Тэр нь тэжээгээд аваад явлаа. Үүнийгээ зөв ашиглаж, олон тулгуурт эдийн засгийн тухай солонгоруулах тухай ярьцаагаад

байдаг бид. Тэгэхээр үүнийгээ хийх юм нь энэ хуульдаа илүү тусаж орох ёстой болов уу л гэж би ингэж л бодоод байгаа. Эндээс харахаар зэрэг ямар салбартаа юунд тэргүүн ээлжид хөрөнгө оруулалт татах ёстой вэ, хэдүүлээ. Ямар чиглэл дээр, ямар салбар дээр хөрөнгө оруулалтыг хязгаарлах асуудал хийгдэх ёстой вэ. Энэ өөрөө их тодорхой болох ёстой юм. Үүнийг бид шийдэх ёстой гэж ингэж л би ойлгодог.

Дараагийн нэг анхаарал татагдаж байгаа зүйл. Сайхан, сайхан нэртэй үндэсний эрх ашиг. Энэ юманд өгөөж багатай төслүүд хэрэгжээд явчихсан нь энэ асуудлуудад бас эргэлзээ болгоомжлолыг үүсгээд байгаа юм.

Тийм учраас аливаа төсөл энэ хөрөнгө оруулалтууд бодитой хэрэгждэг, үр өгөөж өгдөг, эдийн засгийг тэлдэг ийм л байх ёстой. Үүнтэй нь ч уялдуулж тэр тогтворжуулалтын гэрчилгээ юмнууд яригддаг, хөөрдөг байх ёстой. Нэг сайхан ТЭЗҮ, төсөл яриад, тэгээд олигтой юм явдаггүй, цаг хугацаа сунжруулдаг ийм зүйл дээр бид янз бүрийн асуудал яриад байж боломгүй л дээ. Тийм учраас бодитой үнэхээрийн үр өгөөж өгч байгаа тийм зүйл дээр үүнийг бид тогтвортой байдлыг нь хангаж явах ёстой. Би энэ талаасаа хардаг. Бид ингэж чадалгүй алдсан нь энэ 30 жилийн чинь том алдааны нэг том хэсэг нь яваад байгаа шүү. Үүнийгээ харах ёстой гэж ингэж л ойлгоод байна.

Дараагийн нэг зүйл, төрийн бодлого ер нь нэгдмэл цогц байх ёстой. Бүсчилсэн хөгжлийн тухай хэдүүлээ ярьж тэр битгий хэл улс төрийн шийдэл талдаа ч үүнийгээ амьдруулах гээд тойргоо бүсчиллээ шүү дээ. Тэгвэл бид хэд дам, дамаа энэ Эдийн засаг хөгжлийн яам маань бүсчилсэн хөгжилтэйгөө уялдуулж үйлдвэржилт хөрөнгө оруулалтынхаа зураглалыг гаргаж олон нийтэд тавих ёстой. Тэгж байж тэнд хөрөнгө

оруулалтыг түлхүү ээлжид татах ёстой. Энэ талаар манай нөхдүүдэд.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: Би эхлээд энэ 2 дахь асуултаас нь эхэлчихье. Бүсчилсэн хөгжлийн бодлого гээд. Яг энэ чиглэлээр Эдийн засаг хөгжлийн яам нэлээдгүй ажил хийчихсэн байгаа. Намайг сайд болж очихоос өмнө энэ чиглэлээр их удаан хугацаанд төрөл бүрийн судалгаанууд хийгдээд явчихсан ийм байсан юм байна билээ. Тэгээд түүн дээрээ ингээд гаргаж ирээд танилцуулж байгаа юу нь яг үнэндээ надад их таалагддаг. Яагаад гэвэл энэ, энэ бүсэд ийм, ийм хөрөнгө оруулалт хийвэл илүү зохистой гэдэг. Өөрөөр хэлбэл нөгөө социализмын үеийнх шиг тэнд ногоо тарь, энд байцайгаа тарь, энд чацарганаа тарь гэдэг зүйл биш.

Илүү зүгээр санал болгох ийм боломжтой ийм саналуудыг бизнес эрхлэгчдэд оруулж ирж байгаа. Яг энэ салбар дээр энэ хэсэг дээр газар тариалан хөгжүүлбэл дээр, энэ хэсэг дээр уур уурхайг хөгжүүлбэл дээр гэдэг ийм судалгаанууд бүгдээрээ хийгдчихсэн юм байна билээ. Тэгэхээр үүнийг Засгийн газар хувийн хэвилийнхэнд бодлого болгож гаргаж ирээд хийгдээд явах ийм боломжтой. Нэлээн сайн судалгаанууд хийгдчихсэн байгаа. Хаана нь аль бүс нь юун дээрээ илүү анхаарч явбал илүү үр дүнтэй илүү хөгжил авчрах боломжтой гэдэг. Тэгэхээр үүнийгээ дагаад бас улсын зүгээс хийгдэх ёстой нөгөө дэд бүтцүүдийн ажлууд нь дагаад хийгдээд явчих ийм боломжтой юм байна билээ. Удахгүй Улсын Их Хуралд үүнийг оруулж ирнэ гэдгийг хэлье.

Хөрөнгө оруулалтын хууль бол нөгөө ямар ямар нэгэн салбарын тухай хууль биш учраас бид нар аль нэг салбарыг нь онцгойлоод дээшээ ч гэдэг юм уу эсвэл энэ салбар нь болохгүй гэдэг зүйлийг

оруулж ирэхгүй байгаа. Тэр хязгаарлах зүйлүүд эсвэл онцгойлон дэмжих зүйлүүд нь тэр салбарын хуулиудаараа бас зохицуулагдаад явчих боломжтой гэдгийг хэлье. Энэ бол ерөнхийд нь хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэгдсэн ийм л зориулалттай хууль юм байгаа юм.

Г.Занданшатар: Жигжсидийн Батжаргал гишүүн тодруулж асууна.

Ж.Батжаргал: Хөрөнгө оруулалт яаран орж ирэхгүй байгаад байгаа юм нь 2 гол зүйл байгаад байгаа байх л даа. Нэгдүгээрт, бодлогын тогтвортой байдал, үүнийгээ хэдүүлээ тэр тогтворжилтын гэрчилгээ элдэв бусын юмаараа ер нь бас тодорхой хэсгийг нь нөхчих бололцоо байгаа юм байна гэж хараад байгаа юм шиг байгаа юм. Хоёрдугаарт, хөрөнгийн хамгаалалт баталгааны асуудал байгаад байгаа юм л даа. Тэгээд үүнийг ер нь ямархуу байдлаар зохицуулах вэ гэдэг асуудлыг нэлээн бодмоор. Гайгүй юм тусаж явснаа нийгмийн ашиг сонирхлын үүднээс нөхөн төлбөртэй дайчлах юм яриад явчихаар чинь зэрэг сонин болчихож байгаа юм. Нөгөө улсууд чинь юу гэж ойлгох юм. Уг нь бид чинь яриан дундаа нийгмийн зайлиггүй хэрэгцээний үүднээс гээд ярьдаг байсан. Одоо бол нийгмийн ашиг сонирхлын үүднээс.

Г.Занданшатар: 80 Анар. Бат-ирээдүйн Анар. Хөрөнгө оруулалтын газрын дарга.

Б.Анар: Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Хөрөнгө оруулалтын баталгаа, нийтлэг баталгаа гээд энэ одоогийн хууль дээр ерөнхийдөө байдаг. Энэ хөрөнгө оруулалтын баталгаатай холбоотой зохицуулалтуудыг бүүр дэлгэрэнгүй оруулж ирсэн байгаа. Яах вэ, зарим заалтууд нь нөгөө хөрөнгө оруулагчийн хөрөнгө орлогыг хууль бусаар дайчлан авахыг хориглоно гэдэг ийм

зохицуулалтыг оруулсан. Энэ дотроо хэрвээ зайлиггүй нийтийн эрх, ашиг сонирхлын үүднээс зайлиггүй дайчлан авч байгаа тохиолдолд хөрөнгийн нөхөн олговрыг буцааж яаж хийх вэ гээд одоогийн байгаа хууль дээр илүү товчхон байдаг заалтуудыг илүү ойлгомжтой болгож хууль дээрээ оруулж ирсэн байгаа.

Хоёрт нь, энэ тогтворжуулах гэрчилгээтэй холбоотой асуултыг та асууж байна. Энэ яаж нөгөө олгож байгаа нөхцөл байдал хэрэгжээд явж байгаа төслийнхөө ач холбогдолтой уялдах вэ гээд. Яг одоогийн төслийн 18.1 дээр Монгол Улсын нутаг дэвсгэрт 5-аас доошгүй жилийн хугацаанд төсөл хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын хэмжээ нутаг дэвсгэрээс хамаарч доор дурдсан хугацаагаар тогтворжуулах гэрчилгээг олгоно гээд тусгасан байгаа нь яг бодитой хөрөнгө оруулалт нь дор хаяж хамгийн багадаа 5 жил байх ёстой гэсэн ийм шаардлагыг тусгаад оруулчихсан гэж ойлгож болно.

Г.Занданшатар: 14 цаг хүртэл 14 цагаас асуулт асуугаад тэгээд санал хураалтад бэлдэх учраас 14 цаг хүртэл чуулганы нэгдсэн хуралдаан завсарлууллаа.

ЗАВСАРЛАГА.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

2024 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Нэгдсэн хуралдаанаар 5 дахь өдрийн 14 цагаас Ерөнхий сайдын мэдээллийг сонсох хуваарьтай байсан боловч мэдээллийг хойшлуулах хүсэлт ЗГХЭГ-аас ирсний дагуу Ерөнхий сайдын мэдээллийн товчг хойшлуулсан байгаа.

Ийм учраас Хөрөнгө оруулалтын тухай хуулийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ ээ.

Асуулт хариулт явагдаж байгаа. Тогмидын Доржханд гишүүн асуулт асууна аа. Баярлалаа.

Т.Доржханд: *Тэгэхээр энэ хуулийн төслийг маш их дэмжиж байгаа. Тэгээд гагцхүү асуудал нь хууль маань гардаг, хэрэгжилт маань харин бид нарын хүлээснээр байж чадах уу үгүй юү гэдэг дээр л бодит байдал дээр хүлээлт жаахан өөр байгаа шүү. Өөрөөр хэлэх юм бол яг ингээд хөрөнгө оруулахад бэлэн байгаа тийм компаниуд байхгүй шүү дээ. Яагаад вэ гээд тэгэхээр хойд хөрш маань дайнтай байгаа. Энэ бүс нутагт хөрөнгө оруулалтын орчин маш муу байгаа, нэг.*

Хоёрдугаарт энэ ковид гээд манай урд хөршийн бас хил хаалттай байсан. Тэгээд нийлүүлэлтийн сүлжээ нь бас доголдолтой хэвээрээ байгаа. Дэлхий даяараа инфляцтай байгаа. Тэгээд ийм болохлоороо бас яг тэр чиглэлийн хөрөнгө оруулалтууд бас царцчихсан хэвээрээ байгаа шүү тэгээд. Ийм байгаа үед бид нар хөрөнгө оруулалтыг яаж татах вэ гэдэг дээр л толгойгоо ажиллуулах болохоос биш хөрөнгө оруулагч нар гаднаас орж ирээд энэ улсыг эзлэх гээд байна гэдэг үлгэр бүтэхгүй шүү. Тэгээд үүнтэй холбоотойгоор би нэг 3 зүйлийг л нэг хэлчихмээр байгаа юм. Эдийн засаг өсье өө. Цалингаа өсгөмөөр байна. Тэтгэврээ өсгөмөөр байна гээд. Ингээд маш олон хүмүүс чанга дуугаар ингээд л ярьдаг шүү дээ тэ? Орлогоо шахаж байгаад л ярьж байгаа гэдэг нь үнэн байхгүй юу. Үгүй тэгвэл эдийн засаг өсдөг гуравхан суваг байгаа шүү дээ.

Нэгдүгээрт болохоор экспорт байна.

Хоёрдугаарт гаднын хөрөнгө оруулалт байна.

Гуравдугаарт гаднаас мөнгө төгрөг босгодог ийм л 3 эх үүсвэр байгаа юм. Экспорт яасан юм, Гагцчихсан байсан шүү дээ. Энэ жилээс л нэг нүүрс ингээд гарч байх шиг байна. Гаднын хөрөнгө оруулалт байхгүй шүү дээ. Сүүлийн 4, 5 жил 2012 оноос хойш бараг байхгүй л болчихсон шүү дээ, байхгүй.

Гурав дахь нь өрийн таазанд ингээд тулчихсан гаднаас хөрөнгө оруулалт бас мөнгө татах боломж байхгүй. Яагаад гэхлээр зээлдэгч ирээд л сайн өндөр биш үр дүнд нь хувийн компаниуд хямд эх үүсвэр гаднаас авах боломжгүй байгаа. Ингээд энэ 3 урсгал чинь нэг нь дөнгөж онгойж байгаа. Нөгөө 2 ингээд хаалттай.

Одоо яг хоёр дахь урсгалаа нээх юм уу нээхгүй юм уу? Нээж байж өнөөдрийн байгаа энэ эдийн засаг чинь тэлнэ шүү дээ. Тэгж байж нөгөө амлаад байгаа тэтгэвэр, цалин тэгээд энэ урамшууллын чинь өгөх эдийн засгийг өсгөх бодит боломж нь бол ингэж үүсэх юм аа. Гэтэл энийгээ мэдэхгүйгээр зүгээр л ингээд Монголоороо байна гэдэг энэ хандлага бол 33 жил явж ирлээ. Одоо ингээд залуу үе гарч ирсэн шүү. Ном уншдаг, мэдээлэл мэдлэгтэй ийм үеүд гараад ирсэн. Дэлхийтэй хөл нийлүүлээд дэлхийн бизнесийн цикл дотор ороод явах ийм боломжтой үе гараад ирчихсэн. Харамсалтай нь энэ боломжийг олгохгүйгээр тэр үеүд маань зүгээр гадаа гарч хямдхан ажил хийгээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энийгээ харин Монголдоо хийх боломжийг нь бий болгоё л гэж байгаа юм. Тэгэхлээр үүнтэй холбоотойгоор яаж гаднын хөрөнгө оруулалт орж ирж бизнес хийгддэг вэ гээд тэгэхээр нэг л зүйл байгаа шүү дээ.

Монголд бол зах зээл байхгүй шүү дээ. Гуравхан сая хүнтэй 3.5 сая. Зах зээл хаана байгаа юм, Хятадад байна, Японд байна. Япон руу зах зээлийг тэлье гээд

тэгэх юм бол Монгол хүмүүс юу ч үйлдвэрлээд Япон авдаггүй байхгүй юу. Одоо юу гараад байгаа юм. Бид нар Япон руу Японы тэр зах зээлийг мэддэг Японы соёлыг мэддэг, ийм Япон хөрөнгө оруулагч Монголд орж ирээд Монголд тэр үйлдвэрлэл үйлчилгээгээ хийгээд тэгээд Японы зах зээлд гаргадаг. Энэ ингээд дэлхийн жишиг юм. Тэгэхээр бид нар үйлдвэрлэгч үндэстэн болъё, эдийн засгаа тэлье гэж байгаа бол гаднын хөрөнгө оруулалтыг хамгийн түрүүнд оруулж ирээд цаашаагаа экспортоо явна гэдэг энэ дарааллаа аягүй сайн ойлгох хэрэгтэй шүү. Ингэсний дараа нөгөө нэг зээлжих зэрэглэл чинь өснө өө. Ингэсний дараа түрүүчийн ярьдаг 3 дахь суваг чинь нээгдэнэ шүү гэдгийг би хэлмээр байгаа. Одоо бүгдээрээ нэг мэдлэгтэй, мэдээлэлтэй байж байгаад энэ асуудлынхаа ард гарахгүй бол.

Г.Занданишатар: Үг хэлчихлээ. Одоо Телуханы Аубакир гишүүн асуулт асууна.

Т.Аубакир: Баярлалаа. Хуулийг бол дэмжиж байгаа. Гишүүд хэлж байгаа энэ бол удаан хүлээгдсэн хууль. Энэ 2020 оны парламент байгуулагдсанаас хойш шинээр орж ирсэн залуучууд ялангуяа бол энэ хуулийг удаан хүлээж байсан. Тийм учраас энэ хууль оройтож л гарч байгаа юм. Гэхдээ оройтсон ч гэсэн орж ирж байгаад бас талархаж байна. Хүрэлбаатар сайдад. Тэгээд энэ дээр миний ойлгож байгаагаар энэ 7 сард анх Байнгын хороогоор орж ирж байхад нь би бас хэлж байсан. Гаднын хөрөнгө оруулалтуудыг дэмжих хүрээнд цомхон хэдэн асуудал байгаа юм шиг надад санагдаж явдаг юм.

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын зах зээл рүү хөрөнгөө оруулах гэж байгаа гаднын хүмүүс бол татварын орчин байдаг ч юм уу, бусад одоо эрх зүйн орчнуудыг нь хаанаас ч интернэтээр ороод судалчих бололцоо бий. Хөрөнгө оруулсны дараа маргаан үүсвэл энэ

Монгол Улсын шүүх ер нь биднийг шударга шүүх болов уу гэдэг дээр л хамгийн их санаа зовж байгаа юм.

Түүх саяхан болсон тохиолдлууд бий. Говь-Алтай аймаг дээр Уул уурхай ажиллуулж байсан 2 Хятад хүн Монгол залуучуудад уурхайгаа дээрэмдүүлээд нэг нь боож үхэж байсан ч ийм харамсалтай үйл явдал бий. Улаанбаатар хотод ч гэсэн гаднын хөрөнгө оруулалтуудыг дээрэмддэг, луйварддаг, хууль хүчнийхээ байгууллагатай нийлж луйварддаг энэ асуудлаас гаднын хөрөнгө оруулагчид хамгийн их санаа зовоож байгаа зүйл нь энэ болов уу гэж би боддог юм. Тийм учраас энэ хуулийг 7 сард орж ирж байхад би бас Хүрэлбаатар сайдтай санал солилцож байсан. Түрүүн Ганбат гишүүн бас хэлэх шиг боллоо. Энэ бол бизнес эрхлэгч энэ гаднын хөрөнгө оруулагчдыг хамгаалдаг тусдаа шүүхтэй байвал яасан юм бэ гэдэг асуудлыг би тухайн үед тавьж байсан юм.

Тийм учраас хамгийн эхний асуудал бол энэ шүүх байгуулах асуудлуудаа бид нар бас ер нь цугт нь аваад явбал яасан юм бэ гэж, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ Эдийн засаг хөгжлийн яам шинээр байгуулагдаад явж байгаа энэ гаднын хөрөнгө оруулагчдад үзүүлдэг үйлчилгээг нь нэг цонхны зохицуулалт руу шилжүүлмээр байгаа юм аа. Гаднын хөрөнгө оруулагч хэн нь байдаг юм нэг Япон нь байдаг ч юм уу Хятад хүн нь байдаг ч юм уу одоо танай тэр яамны харьяа нэг агентлаг дээр очоод л бүх үйлчилгээгээ нэг цонхноос авчихдаг. Тэндээ энэ гадаадын харьяат энэ иммигрэйшинээ суулгачихдаг, татварынхаа мэдээллийг өгчихдөг, татварын байцаагчид нь сууж байдаг, тусгай зөвшөөрлүүд өгдөг, яамдын мэргэжилтнүүд нь тэндээ сууж байдаг. Одоо энэ гаднын хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомжийн зохицуулалтыг тайлбарлаад сууж байдаг зөвлөхүүд нь нэг доор сууж байдаг. Энэ

түгжрээтэй хотод нэг орчуулагч дагуулчхаад л 4, 5 яамаар яваад л одоо ингээд хийчихсэн улс байгаа юм.

Хамгийн ойрын жишээ сая бид нар өнгөрсөн жил хэдэн гишүүдийн хамтдаа Казакстан улс руу очлоо. Бүгдэд нь нэг цонхны үзлэгээ үйлчилгээ үзүүлчихдэг. Маргаан үүсэхэд нь Лондоны шүүгч дээр лорд шүүгчдээр шүүлгэхдэг. Лондоны кодекс үйлчилдэг. Ерөөсөө 1 байшинд ороод л гаднын хөрөнгө оруулагч бүх асуудлаа шийдчихэж байгаа юм.

Энэний дүнд яасан Казакстан улс 270 гаруй тэрбум долларын хөрөнгө оруулалтыг татаж чадсан байгаа юм л даа. Тийм учраас энэ асуудлуудыг Хүрлээ сайд бас энэ дээрээ оруулаад явчих. Нэгэнт ингээд гарч ирж байгаа хуулиа хэдүүлээ бас сайн чанаж боловсруулаад гаргавал яасан юм. Тийм энэ танхимд сууж байгаа гишүүд ихэнх нь энэ хуулийг хүсэн хүлээж байгаа, дэмжиж байгаа. Энэ манай Эдийн засаг хөгжлийн яамны залуучууд сууж байна. Иймэрхүү шинэлэг ядаж тэр гаднын хөрөнгө оруулагчдаа нэг цонхоор үйлчилгээ үзүүлчихдэгийг нь хүртэл хамгийн түрүүнд нэвтрүүлчих бололцоо байгаа юм шиг харагдаад байгаа юм.

Тийм учраас Хүрлээ сайд энэ дагнасан шүүхийг байгуулчих бололцоо ер нь бий юу. Гол нь энэ хуультайгаа цуг авч яваад энэ хууль батлагдлаа гэхэд та тэр шүүх байгуулах тал дээр бас тодорхой хэмжээний санаачилгыг гартаа аваад явчих ийм боломж бий юу? Ерөөсөө гаднын хөрөнгө оруулагчдыг айлгадаг зүйл бол Монголын шүүх найдваргүй ээ. Монголын хууль хүчнийхэн нөхдүүдтэйгээ нийлээд бид нарыг хулхидчихдаг шүү дээ л гэж байгаа шүү дээ. Ер нь бол. Энэ 2 энэ эрх зүйн орчнуудыг шинэчлэхгүйгээр гаднын хөрөнгө оруулалт агаар ус мэт хэрэгтэй байгаа. Одоо энэ нүүрсний экспорт хязгаарлагдсан үед Монгол Улс цаашидаа яаж амьдрах юм. Сая Доржханд гишүүн бас хэлж байна шүү дээ.

Цаашидаа юугаараа амьдрах юм. Энэ шүүхийн талаар хариулъя.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар Шадар сайд Эдийн засгийн хөгжлийн сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: Аубакир гишүүн. Энэ нөгөө хуулийн төслийг дэмжиж байгаад бас талархал илэрхийлье, манай залуу гишүүд манлайлж дэмжиж байгаад чин сэтгэлээсээ баярлаж байгаагаа бас илэрхийлье.

Ингээд нэг цонхны үйлчилгээ гэсэн асуултаас нь эхэлье. Манай яам бол доороо хөрөнгө оруулалт худалдааны агентлагтай болсон. Энэ агентлагийн гол зорилго нь хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дэмжих, оруулж ирэх, орж ирээд явсан хойно нь үйлчилгээ үзүүлэх ийм зориулалттай агентлаг байгуулагдсан байгаа. Тэгээд энэ хуулийг бол хүлээгээд сууж байгаа. Яг энэ цэгт агентлаг нэг цэгийн үйлчилгээ үзүүлж байгаа. Гэхдээ цаашидаа энэ бүх өргөн хэмжээнд цогц байдлаар нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх ийм боломж бол бүрдээд явчихна аа. Яг таны хэлж байгаа зүйлээр энэ үйлчилгээ үзүүлээд явна гэдгийг хэлье.

Дагнасан шүүх гээд ингэхээр надад бол их гоё сонсогдож байгаа юм. Одоо сая өнгөрсөн сард бид нар зөвхөн авлигын асуудлаар шүүх байгуулна, авлигын асуудал ярьдаг шүүх байгуулна гээд нэлээд олон хэлэлцүүлэг явагдсан.

Тэгэхээр яг бизнесийн асуудлыг шийдвэрлэдэг ийм шүүх байгуулна гээд ингэхэд надад бол ингээд гоё сонсогдож байгаа юм. Гоё сонсогдож байгаа юм. Гэхдээ одоо байгаа тогтолцооны хүрээнд би энэ шүүхийнхээ одоо байгаа тогтолцоогоо сайжруулах замаар явах нь илүү зөв бөгөөд бага хугацаа орох болов уу гэж дотроо бодож байна. Тэгээд мэдээж

энэ шүүхийнхэнтэй бас ярилцаж байж хийж шийдэх ёстой зүйл байх. Зүгээр гоё чихэнд сонсогддог ч юм уу эсвэл их таалагдсан зүйл чинь бас их цаанаа бас асуудалтай байдаг юм шүү дээ.

Тийм учраас нэлээд сайн судалж байгаад Аубакир гишүүн би танд хариулт өгье. Гэхдээ одоо байгаа тогтолцооныхоо хүрээнд одоогоор явж байх нь илүү зөв болов уу л гэж зүгээр дотроо бодогдож байна. Тэгээд би энэ хуульч гишүүдтэйгээ сайн зөвлөлдье. Маргаан гарвал яах вэ гэдгийг энэ дээр маргаан гарвал эхлээд татварын маргаан таслах зөвлөл шиг эхлээд тийм байгууллага үүснэ. Олон талын оролцоотой ийм зөвлөл ажиллана. Тэрэн дээрээ шийдэх гэж оролдоод болохгүй бол шүүх рүү юу арбитр руу юу гэдгээ сонголтоо хийгээд явах юм. Ингээд шүүхийг аваад үзэхээр хамгийн урт урт удаан хугацаагаар шүүх дээр хэлэлцэгдсэн хэрэг бол 16.2 жил юм байна лээ дээд хугацаа нь.

Доод хугацаа нь 1.6 жил, дундаж хугацаа нь 6.2 жил зарцуулагдсан. Ийм л байдаг юм байна лээ. Тэгэхээр үнэхээр шүүх дээр бол асуудалтай гэдгийг Аубакир гишүүний хэлж байгаа асуудалтай санал нэг байна аа.

Г.Занданишатар: Буланы Бейсен гишүүн.

Б.Бейсен: Энэ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг шинэчилсэн найруулгыг дэмжиж байгаа юм аа. Гэхдээ 2 төрлийн асуулт асууя гэж бодож байна. Хүрэлбаатар сайд тэгээд энэ ажлын хэсгээс. Хуучин хууль дээр 3.1.5 дээр хөрөнгө оруулалтын хэмжээ 100 мянган доллар гээд тогтоочихсон байсан тийм ээ. Одоогийн энэ хуулийн төсөл 4.1.5 дээр гадаадын хөрөнгө оруулагч гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж байгаа хувь хүн, гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, түүнчлэн гадаад улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн. Гадаад улсад үүсгэн байгуулагдсан

хуулийн этгээд гэж оруулсан байгаа л даа. Энийг би өөрийн хувьд бас таны юуг эсэргүүцэж байгаа юм биш энэ буруу байх гээд бас бодож байна л даа. Гадаадын олон иргэд орж ирж байгаад ирэх боломжийг нээж байгаа юм биш үү. Одоо орж ирчхээд хөрөнгө оруулалт юугаа нөөц багатай уурхайнуудыг ухаад хайгуул дээрээ ашиглалт хийх асуудал байж байгаа шүү дээ, нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ үндэсний аюулгүй байдлын асуудал өсөх эрсдэлтэй юм биш үү, нэгдүгээрт.

Энэ талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, хууль хүчний байгууллага батлан хамгаалахынхандаа зөвшилцсөн үү бас асуудал дээр ярьсан юм бий юу, нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ хуульд бас Монгол Улсын хөгжлийн стратегитай холбоотой салбарууд байна л даа. Хөрөнгө оруулалт хийхээр. Одоо хөгжихгүй байгаа үйлдвэрүүд байж байна. Ялангуяа энэ газрын тосны үйлдвэрийн асуудлаар зөвхөн Энэтхэг биш бусад оронтой бас хамтарч газрын тосны үйлдвэр байгуулах асуудал байж байна. Мөн дэд бүтэц дээр зам, метроны асуудал байж байна. Мөн МАА-н гаралтай түүхий эд байж байна. Ноос, ноолуур, арьс шир. Энэний талаар үйлдвэр байгуулах асуудал дээр энэ юун дээр бас тусгамаар байх юм.

Мөн эрүүл мэндийн салбар байж байна. Томоохон клиникийн эмнэлгүүд хяналтын баталгаат лабораторийн талын асуудал байж байна. Энэ талын хөрөнгө оруулалт хийх нь зөв юм байх гэж бодож байна л даа би. Мөн хүнсний үйлдвэрлэлийн асуудал байж байна. Хүнсний ногоо энэ тэрийг тариалах асуудлыг өргөн хэмжээнд яаж байгаад эрүүл Монголын хөрсөнд ургасан хүнсээр хангах асуудал байж байна. Энэ талаар бас энэ яамдуудын сайд албадуудтай зөвшилцсөн асуудлаас хамтарч ярьсан юм

байна уу? Харамсалтай нь өнөөдөр Эрүүл мэндийн сайд, Хөдөө аж ахуйн сайд, Аялал жуулчлалын сайд, Соёлын сайд энэ тэр байхгүй байна л даа. Аялал жуулчлалын асуудал дээр мөн л хил дагнасан аялал жуулчлалын Баян-Өлгий аймгийн цаад тал Хятадын Ханаасын аялал жуулчлал байж байна. Наад талд нь манайд бас байгуулах боломж байгаа шүү дээ.

Ийм асуудал дээр зөвшилцсөн асуудлууд байна уу? Энэ талаар асууя.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: Бейсен гишүүний асуултад хариулъя. Зүгээр гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж ирэх гэхэд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл ч юм уу, Тагнуул, цагдаа, Батлан хамгаалах яам эд нартай зөвшилцсөн үү гээд. Уг нь энэ бол бизнесийн л зүйл л дээ. Эдийн засгийн орчныг бий болгодог. Монгол Улсын эдийн засгийг улам л тэлэх, төрөлжүүлэх, ард иргэддээ боломж олгох, бизнес эрхлэгчдэд боломж, сонголт шинээр бий болгох ийм асуудлыг хэлэлцэж байгаа зүйл.

Тэгээд ийм төрлийн хуулийг бид нар бизнесийнхэнтэйгээ л яримаар байгаа юм. Нөгөө тагнуулынхнаас оруулаад л асуугаад л. Цагдаа, Батлан хамгаалах яам гээд энэ Монгол Улс тийм хүчний байгууллагын улс биш. Би хэзээ ч тийм байгаасай гэж бодохгүй байна. Гэхдээ манай арми, цагдаа эд нар нь тагнуул нь хүчтэй байх ёстой. Гэхдээ бизнесийн харьцааны асуудлуудыг бид нар шийдвэрлэхийн тулд бизнесийнхэнтэйгээ ярьдаг, зөвлөлддөг, тэгээд бусад орны хамгийн сайн л шилдэг энэ жишгүүдийг Монголд нэвтрүүлмээр байгаа юм. Ингэвэл Монгол Улс хөгжинө.

Ямар нэгэн юм хийхийнхээ өмнө очоод гүйж очоод тагнуулаас асуудаг, батлан хамгаалахаас асуудаг, цагдаагаас асуудаг, Авлигатай тэмцэх газраасаа асуугаад байвал энэ улс хөгжихгүй шүү

дээ. Ихэнх нь болохгүй л гэж хэлнэ, эрсдэлтэй л гэнэ.

Тийм учраас бид нар улсад дэлхийн улс орнуудад байгаа хамгийн сайн жишгийг л дагаж явах ёстой юм. Түүний дагуу энэ босго болчихоод байгаа юм Бейсен гишүүн. Яагаад вэ гэхээр гадаадаас хүн компани байгуулах гээд шилжүүлэх гэхээр Монголд хаашаа шилжүүлэх вэ? Нөгөө хуучин бол компани байгуулагдаагүй юм чинь данс байхгүй. Төр данс нээхээр нөгөө мөнгө угаах, авлига терроризмтой тэмцэх, юугаараа болохгүй болчихоод байгаа юм.

Тийм учраас компаниа байгуулж чадахаа больчихсон эсвэл хууль зөрчиж оруулж ирдэг. Одоо нөгөө чемодаманд хийж аваад онгоцоор бариад ороод ирэхэд хэцүү шүү дээ. Боломжгүй шүү дээ, тэр чинь эрсдэлтэй аюулгүй байдал. Тийм учраас ерөөсөө л энэ боломжийг нь бид нар гаргаж өгч байгаа. Тэгээд босго тогтоосон орон дэлхий дээр 24 билүү 26 байгаа. Дэлхийн ихэнх орнууд нь үгүй. Тэгээд би түрүүн босго тогтоочихсон байгаа хэдэн орнуудыг нэрийг нь хэлсэн тийм үү, хөгжлөөрөө Монголоос доошоо байгаа орнууд биш.

Тэгэхээр бид нар дээшээгээ харж очих гэж байгаа хүрээллийн бүлэгт байгаа улс орнуудын жишгийг харж явна уу гэхээс биш хөгжлөөрөө манайхаас доошоо орчихсон орнуудын жишгийг хараад Монголд нэвтрүүлээд байвал Монгол дээшээгээ биш доошоогоо л явна.

Тийм учраас бид нар сайн жишгийн дагуу л хөгжиж явах учиртай. Тэгээд хиймэл бэрхшээлүүдийг бизнест учруулаад хэрэггүй ээ, илүү боломж, олгоё, эрх чөлөөг нь олгоё, сонголтыг нь бий болгоё л гэдэг ийм л санал хэлж байгаа юм. Ийм хууль хийгдсэн. Салбарын асуудлууд бол салбарын энэ.

Г.Занданшатар: Бейсен гишүүн тодруулъя нэг минут.

Б.Бейсен: Энэ хуулийн төсөлд бас бизнес эрхлэгч дэмжиж байгаа асуудалд бас талархаж байна л даа. Гэхдээ бас Монгол улсын хөгжлийн стратегитай холбоотой асуудлыг түлхүү оруулбал сайн байх гэж бодож байна л даа. Тэгэхээр энэ ялангуяа эрүүл мэндийн салбарын хүн учраас хэлье л дээ. Турк улс бол Америкийн, Францын том том клиникийн эмнэлгүүдийг байгуулсан. Казахстан бол мөн Туркийн эмнэлгүүдийг байгуулсан. Тэрэн шиг клиникийн эмнэлгүүдийг нээхгүй бол ард иргэдийн байдал хэцүүдлээ шүү дээ. Эмнэлгүүд маань барилга барих талбай ч байхгүй. Ийм асуудлууд дээр түлхээд оруулбал, 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ чөлөөт бүсийн асуудал байж байна. Хуучин соц нийгмийн үед чинь 4 том бааз байхад түүхүүдээ тэрүүгээр гаргадаг байсан. Зарим үйлдвэрүүд ч байсан. Тэгэхээр чинь энэ орон нутагт бас Монгол Улсдаа үйлдвэрийг хөгжүүлэх тал дээр одоо энэ юун дээр тодорхой асуудал оруулахгүй юм уу гээд асууж байна.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: Бейсен гишүүн энэ бол нөгөө 1 ерөнхий хууль. Хөрөнгө оруулагч нарын чөлөөт бүсийн асуудал бол Чөлөөт бүсийн хуулиараа хэрэгжээд явна. Гэхдээ би тантай яг хувь санал нэг байна. Үнэхээр тэр гаднын хүмүүс эмнэлэг байгуулъя гэж байгаа бол орж ирээд эмнэлгээ байгуулаад явмаар байна. Алийн болгон Монголчууд байдаг мөнгөө аваачиж гаднын эмнэлэг эмч нарт зарцуулах юм бэ. Энд орж ирээд хийг л дээ. Тэр боломжийг л хангаж өгөх гээд байгаа юм.

Чөлөөт тэр үйлдвэрлэгч нар нь Монголд оруулж ирээд хөрөнгө оруулалтаа хийгээд, үйлдвэрээ

байгуулаад, нэмүү өртөг боловсруулаад явах бий болгоод явах энэ боломжуудыг нь бид нар нээж өгөх гэж байгаа юм. Тэгэхээр хиймэл тавьчихсан байгаа тэр саад бэрхшээлүүдээ л орхичихъя гээд тэр эрүүл мэндийн салбарт бизнес эрхэлдэг ч юм уу ийм хүмүүс энийгээ хийхэд элдэв бусын саад хэрэггүй л болгочихож байгаа юм. Одоо энэ мөнгө угаахад мөнгө угаахтай холбоотой мөнгө шилжүүлэхэд нарийн зохицуулалттай улс орнуудаас ингээд дуртай хаа хамаагүй нэг хүн рүү мөнгө шилжүүлдэг нь хуулиараа хориотой шүү дээ. Цаана нь бүхэл бүтэн шалгалтууд явагддаг. Тэгэхээр өөрөө оруулж ирээд компаниа нээчихээд тэгээд дараа нь тэрүүн дээрээ мөнгөө шилжүүлээд үйл ажиллагаагаа явуулах нь нээлттэй байгаа. Бид нар одоо мөнгөний шилжүүлэлт дээр асар нарийн зохицуулалттай ийм хяналттай байх үед бол 100 мянга гэдэг босго тавьчихаж байгаа нь үндсэндээ Монгол Улсад хөрөнгө оруулахгүй шүү гэдэг ийм зүйл байгаа байхгүй юу. Ярихдаа гоё ярина. Гэхдээ яг бодитойгоор шууд хааж хориглож байгаа л арга гэсэн үг.

Тийм учраас энийг авах гээд байгаа юм. Тэр хөрөнгө оруулаад ирвэл тэр 100 байтугай мянган долларуудыг Монголд оруулж ирээд явчих байх л гэж би бодож байгаа. Тэгэхээр илүү хиймэл тийм зохиомол хязгаарлалтууд хэрэггүй. Үүний цаана хэсэг хүн л мөнгөжнө, баяжна. Ийм л зүйл. Авлига авна. Элдэв бусын хууль бус юмаа хийнэ. Тэгэхээр хэдүүлээ тэр бүх зөвлөх гэдгийг нь л алга болгох ийм л санал оруулж ирж байгаа юм л гэдгийг би бас хэлье. Би өөрөө энэ Монгол Улс богинохон хугацаанд хурдан хөгжсөөсэй л гэж бодож байгаа. Ард иргэдийн амьдрал үүнийгээ дагаад сайжраасай гэж бодож байгаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу?

Доржханд гишүүнээр тасаллаа. Тогмидын Доржханд гишүүнээр тасалсан.

Т.Доржханд: *Би дэмжиж үг хэлж байгаа юм аа.*

Тэгээд дэмжиж үг хэлэхдээ дахиад хэлье. Энэ нөгөө хэрэгжилт маш хэцүү шүү. Тэгээд хэрэгжилтийг хийхдээ Хүрэлбаатар сайд анхаараарай. Бид нар бас Эдийн засгийн байнгын хороон дээр ярьж байсан. Энэ ЭСЯ-дуудын элчин сайд нар болоод эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөхүүдийг ажилд нь оруулаарай. Одоо ингээд маш олон гаднын эдийн засагч элчин сайд нартай уулзаж байхад тэр хүмүүсийн ажлын үр дүнг юугаар үнэлдэг вэ гээд тэгэхлээр тухайн сууж байгаа улсаасаа ямар хэмжээний хөрөнгө оруулалтыг татсан юм бэ гэдгээр үнэлдэг юм гээд. Тэгээд тийм болохлоор маш их прагматик төслүүдийг ярьдаг. Тэгээд бизнесүүдийг холбодог, бизнесүүдийн форумуудыг аягүй сайн ингээд хийж өгдөг. Тэгээд маш их идэвхтэй ажилладаг байх байхгүй юу.

Гэтэл манай нөгөө Элчин сайдууд маань ЭСЯ-нд ажиллаж байгаа нөхдүүд маань эсрэгээрээ тэгээд л чемодан л зөөгөөд байдаг юм шүү дээ. Тэгээд энийг нь үүрэгжүүлэх хэрэгтэй байна гээд.

Хоёрдугаарт энэ хэрэгжүүлэх шатанд бас ингээд гаднын ажиллах хүчнийг оруулж ирэх шаардлагатай байна гэдэг үндэслэл бол яриад байх шиг байна. Гэхдээ энэний нөхцөл нь юу байна гээд тэгэхээр энэ халамжийн бодлого чинь явж байгаа тохиолдолд бол яг бодит байдал дээр тэгээд л Монголчууд нь ажлаа хийхгүй гаднынхан л ажлаа хийнэ гэдэг ийм л логик явна шүү дээ. Тэгэхээр хөдөлмөрийн зах зээл дээр бизнес эрхлэгч нарт яалт ч байхгүй хүний нөөц маш их хэрэгтэй байгаа. Хүний нөөцийг бэлддэг тэгээд мэргэшүүлдэг ийм тогтолцоо хэрэгтэй байгаа. Энэ дээрээ анхаараарай. Тэгээд халамжийнхаа асуудлыг хумих

хэрэгтэй. Хумихгүй бол ажил хийх хүн олдохгүй. Тэгээд үр дүнд нь тэгээд л дандаа гаднаас өндөр үнээр ажилтан оруулж ирэх ийм асуудал бол бодитойгоор үүснэ шүү. Энэ балансаа бид нар алдаж болохгүй юм гээд.

Дараагийн нэг юм нь хөрөнгө оруулалт хаашаа орж ирээд байгаа юм гээд. Тэгээд манайхан их сайхан л яриад байх шиг байна л даа. Ингээд манай салбарт тэр салбарт гээд байхгүй шүү дээ. Уур уурхайн салбараас өөр салбарт хөрөнгө оруулалт бодит хөрөнгө оруулалт байхгүй шүү. Уур уурхайн салбараас яагаад вэ? Татвар өндөр шүү дээ. Байгалийн татвар маш их өндөртэй. Хамгийн боломжтой нь энэ уур уурхайн салбар руу яагаад оруулаад байна гэхлээр дөнгөж урд тал нь зах зээл байгаа байхгүй юу.

Гэтэл би энэ уул уурхайн бүтээгдэхүүнүүдийг ингээд Хятад руу зах зээл нь ингээд байгаа болохлоор нийлүүлж болж байна. Энийг чинь хараад хүмүүс бизнес хийгээд. Бусад салбарт тэр бизнес хийе гэхлээр хаашаа зарах юм зах зээл байхгүй шүү дээ. Орос юу ч авахгүй байна. Манайхаас хувийн л импорт авч байна гээд тэгж байна. Бодитой байдал нь тэр.

Цаашаа даваад Европын зах зээл хол байна. Америкийн зах зээл бүүр хол. Тэгээд хамгийн ойрхон зах зээл нь Хятадын зах зээл байна гээд. Гэтэл Хятадынхаа зах зээл рүү хүртэл бид нар нөгөө энэ уул уурхайн бүтээгдэхүүнээс өөр юм борлуулж чадахгүй ийм л нөхцөл байдал байхгүй юу.

Тэгвэл асуулт нь. Үгүй тэгээд цаашаа уул уурхай руу чинь хөрөнгө оруулалт хийж чадахгүй бол яах билээ. Хүрэлбаатар сайд аа? Уур уурхайн энэ компаниуд чинь бүгдээрээ төрийн өмчийн компаниуд шүү дээ. Төр өөрөө ингээд дүрмээ тогтоогоод, төр өөрөө ингээд энд бизнесээ хийгээд явж байгаа тохиолдолд хувийн секторынхон орж ирэх үү?

Гаднын хөрөнгө оруулалт нь уурхай руу орж ирэх үү? Энэ чинь өөрөө Монголын зовлон шүү. Өөрөөр хэлэх юм бол төр нь ингээд данхайчихсан бүх ашигтай бизнесүүдийг дандаа төр нь хийдэг. Санхүүгийн сектороо хар л даа. Хөгжлийн банк яаж дампуурав. Одоо Төрийн банк бид нар нэг жилийн дотор аваад л хувь руу шилжүүлнэ гэсэн. Одоо ингээд 12 жил болчихлоо. Дарга энэ салбарт гаднын хөрөнгө оруулалт орж ирсэн үү, орж ирэхгүй шүү дээ.

Яагаад гэвэл дүрэм тогтоогч нь өөрөө тэр өрсөлдөөн дотроо орж ирээд байгаа болохлоор. Тэгэхлээр одоо ганц гаднын хөрөнгө оруулалт татаж байгаа уулын уурхайн салбараа ингээд бүгдээрээ төр нь ингээд монополчихлоор хэн орж ирж өрсөлдөх билээ дээ. Тэгээд ийм болохоор энэ хэрэгжилт тал дээр яг гаднын хөрөнгө оруулалтын энэ асуудал чинь маш хүнд шүү. Хуулиа хийж болно. Хэрэгжүүлнэ гэдэг бол та бүгдийн ажил шүү. Тэгээд энэ дээрээ анхаараарай гэдгийг хэлмээр байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Доржханд гишүүн үг хэллээ.

Энэ яагаад гишүүдийн тоо зөрөөд байна? Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14.12-т заасны дагуу хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно гэж заасны дагуу бас санал хураалтын цагийг жич зарлана. Одоо энэ ирцийн байдал бол дэгийн шаардлага хангахгүй. Санал хураалт явуулах боломжгүй нөхцөл үүсэж байна.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүдийг энэ улс орны хөгжил дэвшил, ард иргэдийн амьжиргааг сайжруулах дээшлүүлэхдээ чухал ач холбогдолтой энэ хуулийн төслийг хэлэлцүүлгийн шатад бас онцгой анхаарч бас хэлэлцүүлгийн шатад сайжруулах асуудлыг энэ хооронд ярилцаж нэгдсэн ойлголтод хүрэлцэх

шаардлагатай гэж үзэж байна. Хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулагчид түнштэй ч хөрөнгийг шингээж байгаа. Монгол Улс Монголчууддаа ч үр өгөөжтэй байх нь чухал.

Тэгээд сая яриад байгаа бас гишүүдийн Доржханд нарын гишүүдийн яриад байгаа бас тэр хөрөнгө оруулалт олон салбар олон чиглэлээр тогтвортой тэгээд өрсөлдөөний тэгш шударга орчныг үржүүлж байх нь юу юунаас чухал.

Тэгээд нэг ийм 2, 3 асуудал сая асуулт хариултын хувьд их их яригдлаа.

Нэгдүгээрт нь энэ Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэсний дараа Газрын тухай хуультай маргаан дэгдээд ард иргэдийн эсэргүүцлээр Засгийн газар буцаагаад татаад авчихсан. Гэтэл одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөрөнгө оруулалтын хуулийн 12.1.1-д зааснаар хөрөнгө оруулагч яг тэр хугацаагаар нь эзэмших ашиглах эрхтэй байхаар хувьчилчихсан юм байна лээ. Энэ хуульд байгаа ийм зөрчилтэй асуудлуудыг нэг мөр ойлголт болгоё.

Яагаад гэхээр хөрөнгө оруулагчид, гадаадын хөрөнгө оруулагчид, дотоодын хөрөнгө оруулагч хоёулаа хамаарч байгаа. Хамаарч байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэр аль нэг нь болох болохгүй нөгөө тэгш шударга өрсөлдөөний нөхцөлөөсөө гадна, энэ заалтыг чинь бас шууд тийм үгүй гээд байхад хэцүү. Тэгээд ирэхээрээ одоогийн хүчин төгөлдөр болж байгаа Хөрөнгө оруулалтын хуульд баахан татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлнэ гээд заачихсан. Тэгтэл тэр хөнгөлөлт чөлөөлөлтүүд нь бас тэгш шударга биш. Яг саяын хэлж байгаа энэ авлигал, хээл хахуулийн шугамаараа байдаг юм уу, аль нэгэн байдалд нь давуу байдал бий болгодог хөнгөлөлтийг чөлөөлчихдөг. Яг

үндсэн бүх хүнд нь тэгш шударга үйлчилдэггүй.

Ерөөсөө манай энэ хөрөнгө оруулалтын хуулиуд 1993 оны хууль гаргахад ч гэсэн бас хуулиуд боломжийн хууль байгаа юм. Яг хэрэгжүүлэх шатан дээрээ ийм нугалаа завхрал, давуу байдал, нэгэнд нь давуу байдал олгодог, нөгөөдүүлийг нь дарамталдаг, хөрөнгийг нь дайчлан хурааж авдаг энэ бүх байдал чинь тэгээд шүүхийн процесс, маргаан хянан шийдвэрлэж байгаа процессууд, хөрөнгө оруулагчдын итгэлийг алдаж байна гэж. Бүх судалгаагаар гадаадын хөрөнгө оруулагчдаас хийсэн судалгаагаар тийм судалгаа ирүүлсэн. Шүүхийн шатнаас авхуулаад бүх шатанд энэ тэгш шударгаар хөрөнгийн оруулж байгаа хөрөнгийнх нь найдвартай байдал, хууль эрх зүйн орчных нь тогтвортой байдал тэгээд энэ бүх байдлуудыг чинь тогтворжуулах шаардлагууд бий.

Тэгээд л арга ядаад л тогтворжуулах гэрчилгээ гэж байгаа юм. Тэгээд бас л нэг хэсэгт нь өгдөг, нэг хэсэгт нь өгдөггүй бас л нэг авлигалын шугамаар юм шиг тэгш бус орчин бүрдүүлж байгаа. Дотоодын хөрөнгө оруулагчдыг бас хамгаалдаг гадаадын хөрөнгө оруулагч хэн гуайн ч бай одоо жишээлбэл огт байхгүй гэж Доржханд гишүүн хэлж болохгүй л дээ. Одоо жишээлбэл ХАА-н салбарт хүнсний хувьсгал гээд маш их хөрөнгө оруулалт орж байгаа.

Тэгтэл тэднийг татварын бодлого, зээлийн бодлого, бүх юм нь энэ үйлдвэрлэлийг дэмжихэд чиглээгүй юм шиг эсрэг бодлого яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бүх төрлийн хөрөнгө оруулалтыг чинь энэ нь хөрөнгөө оруулж байгаа бол тэрнийх нь найдвартай байдал, тогтвортой байдал энэ тэрийг хангасан ийм зөрчилтэй асуудлуудыг нэг мөр шийдэх шаардлагатай юм билээ.

Тэгээд гадаад дотоодын хөрөнгө оруулагч нийлээд нэг, дотоодод хөрөнгө оруулагч, нэг хөрөнгө оруулагч гэсэн ангилалд бүгд орж байгаа. Тэгснээ одоо Засгийн газар татаад авчихсан хуулийн энэ заалт нь Хөрөнгө оруулалтын хуульдаа татварын бус урамшуулал олгох зохицуулалтын хүрээнд газрын талаарх тэр маргаанд дурдсан асуудлууд яг тэр агуулгаараа байж байгаа.

Бас бусад заалтуудын хувьд ч гэсэн ингээд нэг мөр ойлгох нь яг 2013 оны тэр хуулийн үндсэн зарчим дээр л шинэчилсэн найруулга хийчихсэн юм байна лээ.

Тийм учраас энэ дээрээ бол ард иргэдийн дунд сайн ярилцлага ойлголцол төрүүлж байж нэг талын нэг шуурсан давллагаалсан мэдээллээр хандахгүйгээр хэлэлцүүлэг сайн өрнүүлэх хэрэгтэй. Одоо хуулийн төслийг ди парламент дээр 7 дугаар сард байршуулсан. Гэвч иргэд олон нийтийн оролцоо туйлын бага, маш цөөхөн саналууд ирсэн байна.

Тэгээд энэ дээр идэвхжүүлэхийг холбогдох Байнгын хороод анхаараад тэгээд энүүгээрээ саналуудыг аваад, хэлэлцүүлэг сайн зохион байгуулж байгаад ингээд санал хураалт явуулна.

Хэлэлцүүлгийн шатад ч гэсэн сайжруулах жигдрүүлэх асуудлууд олон байна. Ерөөсөө хөрөнгө оруулалт амин чухал. Улс орны хөгжил дэвшил, эдийн засаг, ноу хау, туршилага олон зүйлийг хэрэгжүүлэхэд энэ хөрөнгө оруулалт шиг чухал юм байхгүй. Энэ хууль ч гэсэн бас энэ хөрөнгө оруулагчдад даллан дуудах итгэлийн илэрхийлэл болох ёстой. Үндэсний хөрөнгө оруулагчид үндэстний эрх ашгаа бодно, бодолгүй яах вэ.

Ийм учраас энэ хууль дээр бас нэг мөр ойлголттой болж байж санал хураалт явуулах шаардлагатай байна.

Уул уурхайн салбар манай экспортын 73 хувь биш 94, 95 хувь

болчихсон л доо экспортын. Төсвийн орлогын эдийн засгийн гол зонхилох салбар мэдээж үгүйсгэж болохгүй. Тэгэхдээ эдийн засгаа солонгоруулна, төрөлжүүлнэ гэж уриа лоозон 10, 20 жил хашихирлаа. Энэ хуулиудаар чинь л бодитой хэрэгжих ёстой л доо. Хамгийн бодитой юмнууд нь энэ татвар, зээлийн хөнгөлөлт бодлого, энэ хөрөнгө оруулалтын орчин байх ёстой. Ийм учраас энэ талаар бас гишүүд бүлэг дээр ярилцаж, нэн ялангуяа Засгийн газрын гишүүд нэгдсэн ойлголтод хүрэх хэрэгтэй байна. Засгийн газраас өргөн барьсан хуулиуд дээр ерөөсөө л ингээд л Засгийн газрын гишүүд танхимд орж ирж маргалдаж байгаад ингээд унагаад гацаачихдаг болчихлоо.

Ийм учраас үүн дээрээ онцгой анхаарч ажиллуулахыг санал болгоод Дэгийн тухай хуулийн 14.12-т заасны дагуу энэ асуудлын санал хураалтын цагийг хойшлуулж байна.

14.43 цагт

Эцсийн найруулга.

Дараагийн асуудалд оръё.

Батлагдсан хууль тогтоомжийн эцсийн найруулгуудыг уншиж сонсгоё.

Гэрийн тэжээвэр амьтадын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

2. Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга

байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна алга байна, эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах хүсэлт ирсэн тул хэлэлцэх асуудал дууссан байна.

Ингээд өнөөдрийн хуралдаан
өндөрлөснийг мэдэгдье ээ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА

14.45 цагт